МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР**

UNDP
*Empowered lives.*
*Resilient nations.*

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ЗАЛГАМЖ ЧАНАР, УЯЛДААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

## (Тайлан I)

**Улаанбаатар хот**
**2018 он**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР

UNDP
Empowered lives.
Resilient nations.

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ЗАЛГАМЖ ЧАНАР, УЯЛДААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

## (Тайлан I)

Улаанбаатар хот
2018 он

## АЖЛЫН БАГ

**Судалгааг удирдан зохион байгуулагчид**

Б.Баярсайхан, Үндэсний хөгжлийн газрын дарга, Докторант
Ж.Должинсүрэн, Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Докторант
С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд

**Судлаачид**

Академич Т.Намжим (Багийн ахлагч)
Доктор Б.Батмөнх
Доктор О.Бат-Эрдэнэ
Магистр П.Болормаа

**Хянан тохиолдуулагч** Доктор Б.Батхишиг

Энэхүү судалгааны ажлыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн техникийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

Үндэсний хөгжлийн газрын судалгааны ажлууд нь хөгжлийн бодлогын чиглэлээр тулгамдаж буй чухал асуудлуудыг хөндлөнгийн судалгаан дээр тулгуурлан хөнддөг тул судалгааны санал, дүгнэлт нь тус газрын албан ёсны байр суурийг зайлшгүй илэрхийлэх албагүй болно.

Илтгэлийг ашгийн бус зорилгоор хуулбарлах, олшруулж тараахыг зөвшөөрнө.

## ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо, түүний өнөөгийн байдал болон алдаа дутагдал, цаашдын сургамжийн талаар, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдааг үнэлэх, бодлогын тэргүүлэх чиглэл, үзүүлэлтийн хүрэх түвшинг тодорхойлох, төлөвлөлтийн арга зүй, түүнчлэн 2020-2025 оны дунд хугацааны хөгжлийн хүрээ зэргийг тодорхойлсон таван боть тайланг та бүхэнд толилуулж байгаадаа таатай байна.

Өнгөрсөн хугацаанд, Монгол Улс зах зээлийн шилжилтийг туулж, ардчилсан тогтолцоог нутагшуулсан 28 жилийн хугацаанд эдийн засаг өсч, хөгжлийн тодорхой хэд хэдэн үзүүлэлтүүдээрээ дэлхийн дундаж түвшний хөгжилтэй орнуудын тоонд багтаж, уул уурхай, газар тариалан, барилга, худалдаа, үйлчилгээний салбарт тодорхой ахиц дэвшилд хүрсэн боловч эдийн засгийн төрөлжилт, үйлдвэржилт, засаглал, дэд бүтэц, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон салбарын хөгжилд бэрхшээлүүд тулгарсан хэвээр байгаа билээ.

1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халснаас хойш урт хугацааны хөгжлийн хэд хэдэн стратегийг боловсруулж байсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх бодлого хөтөлбөрүүд нь бодит байдалтай нийцгүй, залгамж чанаргүй, төсөвтэй уялдаагүй байсаар иржээ. Үүний зэрэгцээ дөрвөн жил тутам зохион байгуулагддаг сонгуулийн циклийг даган Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, чиглэл ойр ойрхон өөрчлөгддөг, мөн бодлогын баримт бичгүүд хэт олширсон тэдгээрийн хоорондын уялдаа хангагддаггүй зэргээс үүдэн хөгжлийн бодлогын баримт бичгүүд үр дүнтэй хэрэгжээгүй байна.

Үүний улмаас, Монгол Улсын хөгжил тогтворгүй, эмзэг, баялгийн тэгш бус хуваарилалт нэмэгдсэн, иргэдийн төрд итгэх итгэл суларсан, нийтээрээ хөгжлийн талаарх нэгдсэн ойлголтгүй болсон гэх мэт олон сөрөг үр дагаврууд бий болжээ. Энэ бүх хугацаанд хөгжлийн талаарх олон баримт бичиг, бодлогууд боловсруулж батлуулсан боловч нийгэмд нийтээрээ хүлээн зөвшөөрөгдөхүйц бодит өөрчлөлт, үр дүнд хүрэхгүй байгаа нь улсын тогтвортой хөгжлийн нэгдсэн ойлголт, бодлого, зохицуулалт, түүнийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм, хууль эрх зүйн орчин дутагдалтай байсны илрэл юм.

Үүний мөрөөр, Үндэсний хөгжлийн газар (ҮХГ)-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын өнөөгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог шинэчлэх, шинжлэх ухаан, тооцоо судалгаанд үндэслэн харилцан уялдаа

бүхий бодлого, стратеги боловсруулдаг байх, түүнд чиглэсэн чадавхыг сайжруулах зорилгоор энэхүү таван боть тайланг боловсрууллаа. Энэхүү тайланд судалсан арга зүйг дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго (ДТХЗ)-уудыг хэрэгжүүлэхэд хэрэглэж буй олон улсын сайн туршлагад үндэслэн манай орны салбар бүрийн төрийн болон төрийн бус байгууллагын, мэргэжлийн судлаачдын олон талын төлөөллийн үнэтэй санал, зөвлөмжийг тусган боловсруулсан. Энэхүү тайланд тусгагдсан арга зүй, санал зөвлөмжүүдийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх ажлууд үргэлжлэн хийгдэх бөгөөд цаашид Монгол Улсад цэгцтэй, уялдаатай, залгамж чанар бүхий бодлого, хөтөлбөр, механизмуудтай, харилцан уялдаа бүхий зохицуулалттай төрийн институцтэй, зах зээлийн эдийн засагт нийцсэн төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх бидний хүчин чармайлт биелэлээ олно гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү таван боть тайланг боловсруулах ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн удирдлагаар ханган бүх талаар дэмжин ажилласан Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан танд гүн талархлаа илэрхийлье. Мөн түүнчлэн тайланг боловсруулахад нөр их хөдөлмөр, хичээл зүтгэл гаргаж ажилласан судлаачдийн баг болон тайланг боловсруулахад бүхий л талаар оролцон хөдөлмөр зүтгэлээ гаргасан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтнүүд болох С.Сюзанна, Х.Онон, Э.Тодмэргэн, Л.Амарбаясгалан, Д.Эрхэмбаяр, Р.Сийлэн нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Түүнчлэн манай улсын хөгжлийн төлөвлөлтийг сайжруулахад үнэ цэнэтэй дэмжлэг туслалцаа өгч, хамтран ажилласан Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Монгол дахь суурин зохицуулагч, НҮБХХ-ийн суурин төлөөлөгч хадагтай Беате Транкманн, НҮБХХ-ийн орлогч суурин төлөөлөгч хадагтай Даниела Гаспарикова болон НҮБХХ-ийн хамт олонд гүн талархлаа илэрхийлье.

**Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга**
**Жамбалын Должинсүрэн**

# АГУУЛГА


**ӨМНӨХ ҮГ**

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

**ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ**

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

**УДИРТГАЛ**

**БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГҮҮД: БОДЛОГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ЗАЛГАМЖ ЧАНАР**

1.1. Төрийн урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ 1

1.2. Төрийн хөгжлийн бодлогын онол болон үзэл баримтлалын алдаа, сургамж 8

1.3. Төрийн хөгжлийн нэгдмэл бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага 12

**БҮЛЭГ 2. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР ГАРСАН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД ХИЙСЭН СУДАЛГАА**

2.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ 19

2.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг төгөлдөржүүлэх санал, зөвлөмжүүд 20

**БҮЛЭГ 3. ДТХЗ БОЛОН МУТХҮБ-2030-ЫН СУУРЬ ТҮВШИНГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

3.1. ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын суурь түвшингийн харьцуулалт 23

3.2. МУТХҮБ-2030-ын суурь түвшингийн талаар 24

3.3. МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтийн түвшинг завсрын онуудаар тодорхойлсон байдал 26

**БҮЛЭГ 4. ҮНДЭСНИЙ БОЛОН САЛБАРУУДЫН ХӨГЖЛИЙН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАРИМ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХООРОНДЫН БОЛОН ДТХЗ БОЛОН МУТХҮБ-2030-ЫН ЗОРИЛТУУДТАЙ НИЙЦЭЖ БАЙГАА БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА**

4.1. МУТХҮБ-2030-ын ДТХЗ-тай нийцсэн байдалд хийсэн шинжилгээ 29

**НЭГДСЭН ДҮГНЭЛТ** 31

**НОМ ЗҮЙ** 33

**ХАВСРАЛТ** 35

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсын алсын харааг тодорхойлсон байдал 2

Хүснэгт 2. Урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлсон байдал 3

Хүснэгт 3. Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн давуу болон сул талууд 4

Хүснэгт 4. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үнэлэх үндсэн 20 үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь түвшин болон 2030 онд хүрэх түвшингийн харьцуулалт 24

Хүснэгт 5. МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтүүдийн хүрэх түвшний төсөөлөл 27

Хүснэгт 6. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн байдал 29

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хариуцах чиг үүргийн шилжилт 15

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. МУТХҮБ-2030-д орсон 52 үзүүлэлтийн хүрэх түвшингүүд 35

Хавсралт 2. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал 38

Хавсралт 3. МУТХҮБ-2030 зорилтуудын ДТХЗ-тай нийцэж байгаа эсэх байдал 40

Хавсралт 4. МУТХҮБ-2030-ын зорилгуудын ДТХЗ-тай нийцэж байгаа эсэх байдал 58

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУТХҮБ-2030 - Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

ДТХЗ - Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго

НҮБ - Нэгдсэн Үндэстний Байгууллага

НҮБХХ - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

ОУВС - Олон Улсын Валютын сан

ДХБ - Дэлхийн худалдааны байгууллага

УИХ - Улсын Их Хурал

МАХН - Монгол Ардын Хувьсгалт нам

ҮХГ - Үндэсний хөгжлийн газар

ҮСХ - Үндэсний статистикийн хороо

МУИС - Монгол Улсын Их Сургууль

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн

ҮНО - Үндэсний нийт орлого

ОХУ - Оросын Холбооны Улс

БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс

АНУ - Америкийн Нэгдсэн Улс

МУХҮБ - Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал

ҮХЦБ - Үндэсний хөгжлийн цогц бодлого

ТЭЗҮ - Техник эдийн засгийн үндэслэл

# УДИРТГАЛ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн дээд чуулганаар 2015 оны 9 дүгээр сард Дэлхийн тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг нийт 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлттэй батлан гаргасны дагуу Монгол Улсын Их Хурал 2016 оны 16 дугаар тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (МУТХҮБ-2030)-ыг баталсан билээ.

Дэлхийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Монгол Улс 1996 онд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, 1998 онд Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2008 онд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг баримт бичгийг батлан гаргасан бөгөөд урт хугацааны хөгжлийн бодлогын эдгээр баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, хэрэгжээгүй учир шалтгааныг тогтоох, дүгнэлт гаргах замаар Монгол Улсын хууль эрх зүйн актуудтай уялдуулах шаардлагатай байна.

Түүнчлэн одоо хэрэгжиж буй үндэсний хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн зарим баримт бичгүүдийг судалж тэдгээрийг өөр хоорондоо нь МУТХҮБ-2030 болон ДТХЗ-уудтай уялдуулах, Монгол Улсын тогтвортой хөгжлийн дунд хугацааны хөгжлийн хүрээг боловсруулах, салбаруудын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэрэгцээ шаардлага гарч байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий баг нь ДТХЗ болон МУТХҮБ-2030-тай уялдсан Монгол Улсын дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд хөгжлийн бодлогын өнөөгийн баримт бичгүүдийг судлан шинжилж, “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нийтлэг арга зүйг боловсруулах, зарчим, урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдааг шалгах, үнэлгээ өгөх аргачлалыг боловсруулах, салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэл, дараалал, хүрэх түвшинг тодорхойлох арга зүй” гэсэн тайланг бичээд байна.

Түүнчлэн багийн зүгээс улс орны дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг төрийн мэргэшсэн байгууллагууд, их дээд сургууль, шинжлэх ухааны академийн эрдэмтэн, судлаачид, салбарын мэргэшсэн хүмүүс, мэргэжлийн холбоод, улс төрийн намууд болон иргэний нийгмийн төлөөллийн оролцоотой боловсруулдаг тогтолцоог бий болгох саналыг дэвшүүлж байна. Үүний тулд Үндэсний хөгжлийн газрын дэргэд бие даасан бодлогын судалгааны хүрээлэнг байгуулах шаардлагатай байна. Энэхүү хүрээлэн нь “Think tank” зарчмаар ажиллаж, Монгол Улсын эдийн засаг, нийгэм, байгаль, газар зүйн онцлогт тохирсон үндэсний хэмжээний хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, түүний хэрэгжилтийг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байх юм.

Ингэснээр нам төвтэй засаглалын өнөөгийн тогтолцоо өөрчлөгдөж иргэн төвтэй шударга засаглал руу шилжиж, төрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн онол, практикийн уялдаа, залгамж чанар хангагдаж, аж үйлдвэрийн суурь бүтцүүд байгуулагдах үндэс бүрдэх ёстой гэсэн практик зөвлөмжийг гаргаж, үйл ажиллагааныхаа эхний шатны тайланг та бүхний сонорт хүргэхээр өргөн барьж байна.

# БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГҮҮД: БОДЛОГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ЗАЛГАМЖ ЧАНАР

## 1.1. Төрийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ

1990 оноос хойш гарсан урт хугацаатай хөгжлийн бодлогын эхний баримт бичиг нь 1996 онд Улсын Их Хурлын (УИХ) 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал (МУХҮБ) нэртэйгээр батлагдсан юм. Түүнээс хойш ердөө 2 жилийн дараа буюу өмнөх баримт бичгийг хэрэгжүүлж бараг эхэлж амжаагүй байхад 1998 онд Засгийн газрын 82 дугаар тогтоолоор хоёр дахь баримт бичгийг "Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр" нэртэйгээр баталсан байна. Энэ нь нэг бол өмнөх баримт бичиг нь туйлын хариуцлагагүй, муу боловсрогдсон байсан, эсвэл дараагийн УИХ, Засгийн газар өмнөхөө үгүйсгэсэн гэсэн дүгнэлт хийхэд хүргэдэг. МУХҮБ баримт бичгийг 1996 оны 5 дугаар сарын 3-ны өдөр УИХ-аас баталсан бөгөөд энэ үед Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын П.Жасрайн тэргүүлсэн Засгийн газар 4 дэх жилдээ ажиллаж байсан юм.

Удалгүй 1996 оны 6 сард болсон УИХ-ын сонгуульд Ардчилсан нам анх удаа ялж, М.Энхсайханы тэргүүлсэн Засгийн газар гарч ирж, улмаар өмнөх хөтөлбөрийг өөрчилж, 1998 оны 5 сард Засгийн газрын 82 дугаар тогтоолоор Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг баталсан байна. 1996 оны хөгжлийн үзэл баримтлал нь дөнгөж 8 хуудастай, хэтэрхий товчхон, хөгжлийн олон асуудлыг бүрэн тусгаагүй байсан. Ялангуяа салбаруудын хөгжлийн бодлого тодорхойгүй байсан бөгөөд анх удаа хөгжлийн бодлогоо зах зээлийн нөхцөлд тодорхойлохыг оролдсон учир энэ чиглэлийн туршлага, дадлага дутсан нь тодорхой. Эндээс харахад, улс төрийн намууд тухайн үед урт хугацааны хөгжлийн бодлогоо зөвшилцдөггүй, бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гаргадаггүй, өөр улс төрийн намын үед баталсан хөгжлийн бодлогыг хүлээн зөвшөөрөхгүй, өөрсдийнхөөрөө өөрчилдөг, төрийн тогтвортой нэгдсэн бодлого байгаагүй зэргийг нотолж байна. Нөгөө талаас, тэр үед хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль эрх зүйн орчин хангалтгүй, улс төрийн хүчнүүд өөрсдийн дураар янз бүрийн бодлого, хөтөлбөр гаргаж, төрийн бодлогын нэгдсэн, уламжлалт чанарыг алдагдуулж байжээ.

Хөгжлийн урт хугацааны бодлогын гуравдагч баримт бичиг нь 2008 онд УИХ-аас баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ) юм. Энэхүү баримт бичиг нь 2008-2015 болон 2016-2021 он гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжих ёстой байсан боловч эхний үе шат нь дуусах үед дараагийн бодлогын шинэ баримт бичгийг МУТХҮБ-2030 гэсэн нэртэйгээр 2016 онд батлан гаргасан. Үүнээс үзэхэд МАХН төрийн эрх барьж байх үед буюу 2008 онд батлагдсан ҮХЦБ-ыг Ардчилсан нам эрх барьж байхдаа МУТХҮБ-2030 нэртэйгээр шинэчлэн баталжээ. Гэхдээ 2015 оны 9 сард НҮБ-аас ДТХЗ-ыг батлан гаргасан нь хуучин урт хугацааны бодлогоо шинэчлэн гаргахад нөлөөлсөн тал бий.

Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн дэргэдэх Эдийн засгийн судалгааны хүрээлэнгээс 2014 онд гаргасан "Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харьцуулсан судалгаа"[1]-нд[1] Монгол Улс ҮХЦБ-ыг 2007-2008 онд боловсруулсан боловч, эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм тодорхойгүй

1 Б.Түвшинтөгс, Д.Эрдэнэбулган, 2014.

байсан учраас тус хөтөлбөр тунхагийн шинж чанартай хэвээр үлдсэн гэж дүгнэжээ.

2012 онд Монгол Улсын Засгийн газрын захиалгаар НҮБХХ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: Ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго тайланд түүнийг эрхлэн зохиогч, доктор, профессор Б.Хулдорж “Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн уламжлалыг хадгалсан эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр үлэмж амжилт олжээ... Гэвч эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилт, уялдаа холбоог хангах, дараа дараагийн шатны баримт бичгийн уламжлал, нэн ялангуяа мэргэшиж туршлага хуримтлуулсан хүний нөөцийн залгамж холбоог хангах талаар хангалтгүй ажиллажээ” гэж дүгнэжээ.

1990 оноос хойш батлагдсан урт хугацааны хөгжлийн бодлогын дээрх 4 баримт бичгүүдэд хөгжлийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал, тодорхой асуудал, сэдвүүд дээр ямар байсныг харьцуулан доорх хүснэгтүүдээр харуулав.

**Хүснэгт 1. Урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсын алсын харааг тодорхойлсон байдал**

| Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал (1996) | Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998) | Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008) | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 |
|---|---|---|---|
| Монгол Улсын ойрын 15-25 жилийн хөгжлийн гол стратеги нь нийгмийн баримжаатай, байгаль орчиндоо зохицсон, оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын чиглэл бүхий харьцангуй бие даасан эдийн засагтай, ардчилалд үндэслэсэн улс төрийн боловсронгуй тогтолцоотой, соёл, оюуны өндөр хөгжилтэй, үйлдвэржсэн орон болох явдал мөн. | Монгол Улсын алсын хараа нь ямар нийгэмд хүрэхийг зорьж байгааг илтгэнэ. Энэ нь хуулийг дээдэлсэн хүний хөгжлийн бүх боломжийг монголчуудад олгох, байгалийн нөөцийг ухаалаг ашигладаг, түүнийг зөвхөн өнөө үеийнхэнд бус ирээдүй хойч үеийнхэнд зориулан хамгаалдаг нийгэм байх ёстой. Энэ бүхэн нь бүх иргэдэд ажил эрхлэх, боловсрол эзэмших, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг бодитой хүртээх замаар монголчуудын амьдралын чанарыг дээшлүүлэх хурдацтай, үр ашигтай, тэнцвэртэй эдийн засгийг бий болгох, монголчуудад элбэг хангалуун, сэтгэл дүүрэн амьдрах, аюулгүй байдал, боломж, эрх чөлөөгөөр хангасан нийгмийг байгуулах явдал юм. | Монгол Улсын үндэсний хөгжлийн 2021 он хүртэлх алсын харааг дор дурьдсан байдлаар тодорхойлж байна. “Монгол Улс нь өргөн уудам нутаг, байгалийн нөөц, баялаг, бахархам түүхтэй, итгэл найдвар дүүрэн, ирээдүйн цог жаргалтай орон” мөн. Бидний монголчууд түүх соёлоо эрхэмлэн хүндэл ж, үндэсний бахархалтай, өндөр боловсролтой, өөрсөддөө итгэлтэй байж, хүсэл тэмүүлэлдээ хүрч, эх орондоо тав тухтай, чинээлэг, сэтгэл хангалуун аж төрнө. Монгол Улсын хөгжил бол аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгаа мөн. Хөгжлийн үндэс нь үндэсний эв нэгдэл юм. | Монгол Улс 2030 он гэхэд 1 хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөж байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн цэвэр байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно. |

*Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын 26 дугаар тогтоолын хавсралт, “Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал” (1996); Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр” (1998); Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008); “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”.*

Хүснэгт 1-ээс харахад дээрх дөрвөн баримт бичигт Монгол Улсын алсын харааг янз бүрээр тодорхойлжээ. Урт хугацаандаа алсын хараа өөрчлөгдөж болох боловч ийм богино хугацаанд баримт бичиг бүрт өөр өөрөөр тодорхойлогдсон нь бодлогын залгамж чанар, тогтвортой байдал хангалтгүй, үргэлж өөрчлөгдөж ирснийг харуулж байна.

ҮХЦБ-д Монгол Улсын алсын харааг тодорхойлсон байдал оновчтой бус, уран сайхны халил ихтэй, тунхаглалын шинжтэй болсон байна.

1996 оны үзэл баримтлалд нэлээд амбицтай томоохон зорилтууд, тухайлбал үйлдвэржсэн улс орон болох зорилтыг тодорхойлсон бол 1998 оны тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон 2008 оны цогц бодлогод түүнийг үргэлжлүүлэн авч үзээгүй байна. Эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлсон байдал өөр өөр байгааг доорх Хүснэгт 2-оос харна уу.

**Хүснэгт 2. Урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлсон байдал**

| Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал (1996) | Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998) | Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008) | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 |
|---|---|---|---|
| Монгол Улс ойрын ирээдүйд оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан экспортын баримжаатай, харьцангуй биеэ даасан эдийн засагтай, үйлдвэржсэн орон болно.<br>**Нэгдүгээр үе шат** (1996-2000 он):<br>Эдийн засгийг тогтворжуулан сэргээж цаашдын өсөлтийн үндсийг тавина. Энэ нь хөгжилд шаардлагатай хуримтлалыг нэмэгдүүлэх эхний үе шат юм.<br>**Хоёрдугаар үе шат** (2001-2010 он): Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж, бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэн түүний экспортод баримжаалсан чиглэлийг хүчтэй болгоно.<br>**Гуравдугаар үе шат** (2010-2020 он): Эдийн засгийн голлох салбаруудад үндэсний болон дэлхийн өндөр зэргийн технологи нэвтрэн Монгол улсад өрсөлдөх шинэ давуу талууд бий болж, экспортод баримжаалсан оновчтой бүтэц бүхий харьцангуй бие даасан эдийн засаг бүрдэнэ. | Эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлого нь эдийн засгийн хөгжлийг дэмжих тогтвортой хөгжил рүү чиглэсэн эдийн засгийн бодлогын хэрэгслүүдийг үр ашигтай ашиглах, зах зээлийн механизмуудыг үр ашигтай ашиглах, байгаль орчин-эдийн засгийн тооцооны нэгдсэн системийг байгуулахад чиглэнэ. | Эдийн засгийн бодлогын гол зорилт нь 2007-2015 онд “Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 14%-д, нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийг 5000-аас доошгүй ам.долларт хүргэж, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үндэс суурийг тавих. | Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ.<br>Хөдөө аж ахуй, аж үйлдвэр түүний дотор хөнгөн хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ. |

*Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын 26 дугаар тогтоолын хавсралт, “Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал” (1996); “Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр” (1998); “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008); “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”.*

1990 оноос хойш батлагдсан хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд өгсөн ерөнхий үнэлгээг Хүснэгт 3-аас харна уу.

**Хүснэгт 3. Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн давуу болон сул талууд**

| Давуу болон сул талууд | Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал (1996) | Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998) | Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008) | Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 |
|---|---|---|---|---|
| **Давуу талууд** | Анх удаа урт хугацааны бодлогоо тодорхойлох оролдлого байсан. Монгол Улсын давуу болон сул талыг анх удаа тодорхойлсон. | Бүтэц, бичсэн арга хэлбэр нь олон улсын жишиг харгалзсан. Бодлогыг тодорхойлохдоо зах зээлийн нийгмийн зарчмыг баримталсан. | Иж бүрэн, олон талыг хамруулсан бодлогын зорилтуудыг тодорхойлохыг оролдсон. | Логик дэс дараалал, цэгц сайтай, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан, товч тодорхой болсон. Зорилтуудыг статистик үзүүлэлтээр илэрхийлэх тал дээр илүү сайн болсон. |
| **Сул талууд** | 8 хуудастай хэтэрхий товчхон, салбаруудын хөгжлийн бодлогыг тодорхойлоогүй, Алсын хараа нь маш том зорилготой хэрнээ түүнд хүрэх зорилго, зорилтууд нь тодорхой бус үлдсэн. Дунд хугацааны төлөвлөлтөд тусгагдаагүй тул хэрэгжээгүй. | Зорилтуудаа үзүүлэлтээр илэрхийлэх тал нь дутагдалтай. Манай орны онцлогийг тусгах тал дээр дутуу дулимаг болсон. Дунд хугацааны төлөвлөлт байгаагүй тул бүрэн тусгагдаж хэрэгжээгүй. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд бүрэн тусгагдаагүй. | Нүсэр том, нуршуу, тунхаглалын шинжтэй зорилтууд олонтой, Үндэслэл судалгаа муутай, жишээ нь 2007-2015 онд эдийн засгийн дундаж өсөлтийг 14% байна гэж үндэслэлгүй тооцсон. Дунд хугацааны төлөвлөлт байгаагүй тул бүрэн тусгагдаж хэрэгжээгүй. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд бүрэн тусгагдаагүй. | ДТХЗ-ыг хангалттай хэмжээнд Монголын нөхцөлд хэрэгжүүлэхээр тусгаагүй, ялангуяа жендерийн тэгш байдлыг хангах талаарх 9 зорилтоос огт тусгаагүй орхигдуулсан. Арай цомхон болсон. Эдийн засгийн дундаж өсөлтийг өмнөх онуудын дунджаас бууруулж төлөвлөсөн. |

Монгол Улсад 1990 оноос хойшхи 27 жилд улс төрийн тогтворгүй байдал газар авч, Засгийн газруудын ажилласан дундаж хугацаа ердөө 1,5 жил байсан нь төрийн бодлогыг залгамж чанаргүй болоход нөлөөлсөөр ирсэн. Тухайлбал, эхний засгийн газрын хэрэгжүүлж байсан бодлогыг дараагийн Засгийн газар нь өөрчилж цоо шинэ бодлого хэрэгжүүлж ирсэн нь олон зүйл дээр харагдаж байна. Үүний нэг тод жишээ бол авто замын салбар дахь бодлого байлаа. МАХН-ын 2000 онд байгуулсан Засгийн газар “Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийг батлах” тухай УИХ-ын 9 дүгээр тогтоол баталж, түүнийг 2011 он хүртэл хэрэгжүүлж, зарим чиглэлийн замыг барьж байгуулсан боловч Ардчилсан Намын 2012 онд байгуулсан энэхүү бодлогыг Засгийн газар эрс өөрчилж, “Бүх аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай замаар холбох бодлого” болгон сольсон.

Ингэж Монгол Улсын хууль эрх зүйн орчин тогтворгүй болж байнга өөрчлөгдөж ирсэн бөгөөд УИХ-аар батлагдан гарсан олон хууль, тогтоомжууд судалгаа шинжилгээ дээр тулгуурлаагүй байна. Энэ нь манай улсын төрийн бодлого, зохицуулалт тогтворгүй, залгамж чанаргүй, төрийн алба чадваргүй, засаглал доройтолд ороход нөлөөлсөн гэж үзэж байна. Ийм байдал нь гадаадын хөрөнгө оруулагчдын гайхширалыг төрүүлж, тэднийг эргэлзэхэд хүргэж байна. Тухайлбал, ард иргэдийн дунд “урт нэртэй” гэж нэрлэгддэг Гол мөрний урсац, бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хэрэгждэггүй хуулийн хэлж болно.

Өнгөрсөн 27 жилд Монгол Улсад улс төрийн намууд төрийн дээд эрх мэдлийг гартаа авч, мэргэшсэн төрийн албан хаагчдыг олноор нь сольж, халж, төрийн албыг баг бүрдүүлэх гэсэн нэрийн намын нөхөд эсвэл танил тал, найз гэх мэт мэргэжлийн бус хүмүүсээр дүүргэх болсон нь төрийн албаны уламжлалт нэгдсэн тогтолцоо, түүний залгамж чанарыг алдагдуулж, тэнд мэргэшсэн албан хаагчид тогтвор, суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах боломжгүй болгосноор засаглалын чанар улам муудахад хүргэж байна. Нөгөө талаас, төрийн эрх мэдэлд гарсан улс төрчид бизнесийн томоохон бүлэглэлийг төлөөлж, тэдний өмнөөс ашиг сонирхолын зөрчилтэй шийдвэр гаргаж төрийн албыг авилга, хээл хахуульд автуулах нөхцлийг бүрдүүлсээр байна.

Энэ тухай Япон улсаас Монгол Улсад сууж байсан Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд асан Такенори Шимизү “Өдрийн сонин”-ы 2015 оны 9-р сарын 17-ны 226 (5178) дугаарт өгсөн ярилцлагадаа “Монголд эрх баригч нам, сайдууд өөрчлөгдөх тутамд төрийн албан хаагчид солигддог ийм нэг жишиг байх юм. Эцсийн эцэст энэ холио солионы үр дүнд яаманд ажлаа мэддэг мэргэжлийн хүн үлдсэнгүй. Мэдээж энэ нь Монголын эрх ашигт нийцэхгүй. Мэргэжлийн албан хаагчид байхгүй болсноор гадаад орнуудтай хамтран ажиллахад ихээхэн саад тотгор болж байна гэдгийг хэлмээр байна” гэж аргаа баран хэлж байжээ.

Ийнхүү, өнөөдөр Монгол Улсын хөгжлийн бодлогыг бүрэн төлөвшиж чадаагүй улс төрийн намууд тодорхойлж, тэдний үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр нь нийт ард түмэн, улс үндэстний язгуур эрх ашгийг бүрэн төлөөлж чадахгүй байна. Онолын хувьд улс төрийн намуудын гол зорилго нь аливаа сонгуульд ялалт байгуулах, ингэснээр төрийн эрх мэдлийг авахад оршдог. Сонгуульд ялсан улс төрийн намын байгуулсан засгийн газрын мөрийн хөтөлбөр нь сонгогчиддоо таалагдаж, амлалтаа биелүүлэх, дараагийн сонгуульд ялалт байгуулахад чиглэгдсэн явцуу популист шинжтэй 4 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөр нь улс орны урт хугацааны хөгжлийн алс хэтийн зорилго, зорилтгүй, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн дэс дараа, үе шатгүй, хариуцах эзэнгүй, хэрэгжих үндэсгүй цаас болж, төрийн өндөр албан тушаалтны ширээн дээр тоосонд дарагдан орхигддог нь цөөнгүй.

Өнгөрсөн хугацаанд хэрэгжиж ирсэн төрийн хөгжлийн бодлого нь шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, улс орны эдийн засаг, нийгмийн онцлогт тохироогүй, үндэсний эрх ашигт нийцээгүй, тодорхой тойрог, жалга довны эрх ашгийг илүү тавьсан байхын зэрэгцээ барууны орнууд болон олон улсын байгууллагуудаас тулгадаг манай онцлогийг тооцоогүй санал, зөвлөмжийг шууд хуулбарласан байхын хамт неолиберал үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Энэ нь манай оронд төрийн урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахдаа үндэсний эрдэмтэн, мэргэд, олон нийтийнхээ санал, дуу хоолойг тусгадаггүйтэй холбоотой гэж үзэж байна.

Үүний үр дүнд ажил хөдөлмөр эрхлэх хүсэлгүй, төрөөс тэтгүүлэх сонирхолтой давхарга хүн амын дунд бий болсныг нуух хэрэггүй. Энэ бол үндэсний язгуур эрх ашигт харшлах туйлын явуургүй бодлого билээ. Намуудын энэ бодлогыг хөрөнгө оруулалтын үр ашиг, үндэсний эрх ашиг талаас нь харвал бүр ч их шүүмжилж болно. Үнэн хэрэгтээ улс төрийн намуудын бодлого нь 4 жилийн хугацаанд төрийн эрх мэдэлд байхдаа дараагийн сонгуульд ялалт байгуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлэхэд чиглэгддэгийн зэрэгцээ эрх мэдэлтнүүд сонгуульд зарцуулсан мөнгөө хэд дахин нугалан олж авах, хөлжиж, баяжих боломжийг өөрсөддөө олгох төсөл, хөтөлбөрүүдийг дэмжих хувийнхаа бизнесийг өргөжүүлэх, бусдын бизнесийг боймлоход илүү анхаардаг нь нууц биш юм. Эрх баригч намын бодлого нь үндэсний эрх ашгаас дээгүүрт тавигддаг учраас төрийн бодлого төдийлөн оновчтой байж чаддаггүй. Үүнийг сүүлийн 10 жилийн маш олон баримт нотолдог. Тухайлбал, Монгол Улсад сүүлийн 10 жил нефть боловсруулах үйлдвэр, 5 дугаар цахилгаан станцыг барих, Таван Толгойн уурхайгаас Гашуун Сухайт хүртэлх төмөр зам тавих, нүүрсийг гүйцэд боловсруулах зэрэг зорилтуудын тухай олон удаа ярьж, төлөвлөж, зарим дээр нь төр, засгийн шийдвэр гарч байсан боловч огт хэрэгжилгүй үлджээ. Энд үндэсний эрх ашиг биш, харин улс төрчид, эрх баригчдын хувийн явцуу эрх ашиг хөндөгддөг учраас л тэд дээр дурьдсан төслүүдэд саад тавьж, хэрэгжүүлэхгүй байгааг олон түмэн мэдэх болжээ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл нь дунд хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлж ирсэн боловч дээрх шалтгаануудын улмаас 1 жилийн хугацаатай Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын нэгдсэн төсөв, Төрөөс мөнгөний талаар баримтлах бодлого зэрэг баримт бичгүүд нь улс орны хөгжлийн урт хугацааны бодлого, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүрэн чиглэгдэж чадахгүй байна.

Иймд, чадварлаг боловсон хүчнээр бэхжсэн, мэргэшсэн төрийн байгууллагууд, урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулдаг мэргэшсэн институц, “Think tank” хэмээх бодлогын судалгааны чадварлаг байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэд, салбарын мэргэшсэн хүмүүсийг оролцуулан төрийн дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөлтийг боловсруулдаг болсноор үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн, өөрийн улс орныхоо онцлогт тохирсон, бодитой судалгаа, шинжилгээнд тулгуурласан, урт, дунд хугацааны тогтвортой хөгжлийн бодлоготой болох боломжтой гэж үзэж байна.Үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн, төрийн урт хугацааны тогтвортой, үр ашигтай, үр дүнтэй, оновчтой зөв бодлоготой болохын урьдчилсан нөхцөл нь нам төвтэй засаглалаас салж, ард түмэн төвтэй төрийг жинхэнэ ёсоор нь байгуулж, тогтвортой ажиллуулах явдал гэж үзэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, Монгол Улсад дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг шинжлэх ухааны судалгаа шинжилгээнд үндэслээгүй, популист шинжтэй, олон түмэнд таалагдах зорилго агуулсан, улс орны эдийн засаг, нийгмийн онцлогийг тооцоогүй, үндэсний эрх ашгаас тодорхой тойрог, жалга довны эрх

ашгийг илүү тавьсан эрх баригч намын байгуулсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр орлох болжээ. Сонгуульд ялсан нам засгийн эрхийг барьж байсан өмнөх нам болон Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг үгүйсгэн өөрчилж, ондоо бодлого, үйл ажиллагааг эхлүүлж ирсэнээс төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал алдагдах боллоо. Энэ нь төрийн албыг тогтворгүй болгож, засаглалын хямралыг бий болгох үндэс болж байна. Нөгөө талаас төрийн бодлогыг боловсруулах мэргэжлийн институц байхгүй учир эрх баригч намд амьдралаас тасархай, хаалган, бодлогыг дур зоргоороо боловсруулах, хэрэгжүүлэх нөхцлийг бий болгож өгч байна. Үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн, төрийн дунд болон урт хугацааны тогтвортой, үр ашигтай, үр нөлөөтэй, оновчтой бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд нам төвтэй засаглалыг халж, ард түмэн төвтэй засаглал руу шилжих шаардлагатай гэж үзэж байна.

Өнөөгийн төр, засгийн дунд болон урт хугацааны оновчтой бодлого, төлөвлөлтийг сайжруулахад дараах арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Урт хугацааны хөгжлийн бодлогыг төрийн мэргэшсэн байгууллагууд, “Think tank” хэмээх бодлогын судалгааны чадварлаг байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн мэргэд, салбар бүрийн мэргэжлийн хүмүүсийн оролцоотой боловсруулж, намууд болон иргэний нийгмээрээ өргөн хэлэлцэж, зөвшилцсөний эцэст үндэсний хэмжээний тогтвортой мөрдөх бодлого болгон баталдаг зарчмыг хэвшүүлэх;

2. Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг болгох;

3. Монгол Улсад төрийн албыг мэргэшсэн, ажлын зохих дадлага, туршлага бүхий хүмүүсээр бэхжүүлэх, тогтвортой ажиллуулах, улс төрөөс хараат бус байлгах талаар Төрийн албаны хуулинд тусгаж, хэрэгжүүлэх, тогтвортой, мэргэшсэн төрийн албатай болох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;

4. Төрийн урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулдаг мэргэшсэн институц, “Think tank” бодлогын судалгааны чадварлаг байгууллагыг одоогийн ҮХГ-ын дэргэд байгуулах, үүндээ их, дээд сургууль, эрдэмтэн мэргэд, салбар бүрийн мэргэжлийн хүмүүсийг оролцуулдаг бүтцийг төрөөс дэмжиж, ажиллуулах;

5. Монгол Улс нам төвтэй засаглалаас салж, улс төрийн намуудын эрх мэдлийг хязгаарлах, улс төрийн намууд төрийнхөө дээр гарсан эрх мэдэлтэй болсныг таслан зогсоох талаар Үндсэн хуулийн өөрчлөлтөд тусгах;

6. ҮХГ-ын дэргэдэх Бодлогын судалгааны хүрээлэнд доорх асуудлуудаар гүнзгийрүүлсэн судалгаа явуулж, санал, зөвлөмж гаргах шаардлагатай байна. Үүнд:

    - Монгол Улсын төрийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанарт үнэлгээ, дүгнэлт өгөх, санал, зөвлөмж боловсруулах;
    - Улс төрийн намуудаас эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар явуулж ирсэн бодлогын ялгаанууд, тэдгээр нь үндэсний язгуур эрх ашигт хэрхэн нийцэж байсан талаар дүгнэлт гаргаж, санал, зөвлөмж боловсруулах;
    - “Хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ, шинжилгээ хийх механизм, хариуцсан институцийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд” сэдэвт судалгаа хийх;
    - “Төрийн бодлого боловсруулах үйл явц, арга зүйн өнөөгийн байдал, анхаарах асуудлууд” сэдэвт судалгааг захиалгаар хийлгэх гэх мэт.

### 1.2. Төрийн хөгжлийн бодлогын онол болон үзэл баримтлалын алдаа, сургамж

Зах зээлийн эдийн засгийн шилжилтийг хэрэгжүүлэх явцад 1990 оноос өмнө бүтээн байгуулсан аж үйлдвэрийн салбар сүйрч, ядуурал хүн амынх нь гуравны нэгийг хамарсан, хүн амын дотор баян хоосны ялгаа эрс нэмэгдсэн, ард түмэн өр зээлэнд баригдсан бөгөөд төр нь авилгад идэгдэж, засаглалын чанар улам доройтсоор байна. Энэ нь Монгол Улс анхнаасаа зах зээлийн эдийн засагт шилжихдээ “мордохын хазгай” гэгч болсонтой холбоотой. Үүний хамгийн гол учир шалтгаан нь шилжилтийн онолын үзэл баримтлал буруу, хөгжлийн бодлого нь судалгаа шинжилгээнд сайтар үндэслээгүй, үндэсний эдийн засгийн онцлог, ард түмний язгуур эрх ашгийг тэргүүн зэрэгт тавиагүй, өөрийн орны онцлогт тохирсон дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлж чадаагүйтэй холбоотой юм. Монгол Улс 1991 оноос зах зээлийн эдийн засагт шилжихдээ Дэлхийн банк, Олон Улсын Валютын сан (ОУВС) болон Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын санхүү, эдийн засгийн онолч, номлогчид, тухайлбал, Жон Уильямсоноор удирдуулсан хэсэг эрдэмтэд, онолчид, гадаад улсын зарим нөлөө бүхий улс төрчдийн зөвлөсөн “цочир эмчилгээ” хэмээх аргыг ашигласан. Энэхүү эдийн засгийн бодлогын шинэ загвар нь түүхэнд “Вашингтоны тохиролцоо” гэсэн нэрээр үлдсэн билээ. Энэхүү загварын гол агуулга нь неолиберал[2] бодлого байсан бөгөөд макро эдийн засгийн тогтворжуулалтыг хангах, үүний тулд инфляцтай тэмцэж, түүнийг хамгийн бага түвшинд барих, бүх талаар чөлөөт байдлыг хангах, үүний тулд эдийн засгаа нээлттэй болгож, гадаадын хөрөнгө оруулалтад үүд хаалгаа бүрэн нээх, гадаад худалдаа, үнэ тарифийг чөлөөлөх, төрийн өмчийг хувьчлах, өмчийн эрхийг баталгаажуулах, төрийн зохицуулалтыг эрс багасгах, Засгийн газрын зардлыг багасгах, татварын 2 шатлалт шинэ тогтолцоог бий болгоход оршиж байв.

Монгол Улсад “цочир эмчилгээний” эдийн засгийн загварын дагуу үндэсний боловсруулах үйлдвэр, аж ахуйн газруудын хувьчлалыг ямар ч бодлогогүйгээр өргөн хүрээтэй явуулсан бөгөөд хувьчлан авсан эзэд нь тэдгээрийг ажиллуулж чадаагүйн улмаас олон зуун үйлдвэр, үйлчилгээний болон аж ахуйн газрууд хаалгаа барьж, олон мянган ажилчдыг гудамжинд гаргаж, ажилгүйчүүдийн тоог эрс нэмэгдүүлэн, өнөөгийн ажилгүйдэл, ядуурлын суурийг тавьсан.

АНУ-ын Колумбын их сургуулийн профессор багш, ерөнхийлөгч асан Билл Клинтоны эдийн засгийн зөвлөх, Дэлхийн банкны ахлах дэд ерөнхийлөгч, ерөнхий эдийн засагчаар ажиллаж байсан, 2001 онд эдийн засгийн салбарын Нобелийн шагнал хүртсэн Жозеф Е. Стиглиц “Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь” номондоо “Ажилгүйдэл, ядуурал нь ОУВС-ийн гаднаас нь тухайн улсын төр, засгийг дарамталж, хилийн чанадаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн юм. Өнөөдөр аль нэг улс орныг атомын бөмбөгөөр бөмбөгдөн устгах хэрэггүй болжээ. Учир нь үүнээс илүү үр дүнтэй, хохирол багатай, илүү боловсронгуй колоничлолын шинэ хэлбэр, эдийн засгийн технологийг олжээ. Өөрөөр хэлбэл, ОУВС, Дэлхийн банкыг энэхүү бодлогыг хэрэгжүүлэгч институт болгон хувиргажээ” гэж дүгнэсэн байдаг[3].

Монгол Улс неолиберал онолын дагуу зах зээлээ чөлөөтэй нээж, 1996 оноос импортын татварыг тэглэсэн нь үндэсний үйлдвэрлэлд дахин сэхэхгүй цохилт болж, Монголын зах зээлийг импортын чанаргүй, хямд хүнс, өргөн хэрэглээний бараагаар

2 Неолиберализм нь 1930-аад оны үеэс нэвтэрсэн эдийн засгийн философийн урсгал юм. Энэхүү урсгал нь хязгаар тавиагүй өрсөлдөөн дэвшил хөгжлийн үндэс болж, төрийн оролцоог дэмжсэнээр эдийн засгийн өсөлтөд нөлөөлж нийгмийн асуудлыг шийдэх хөрөнгө буй болгоно гэж үздэг үзэл.

3 Joseph E. Stiglitz, Globalization and it’s discontents, 2003.

дүүргэж, ард иргэдээ хордуулах нөхцлийг бүрдүүлсэн. Хэдийгээр Оросын Холбооны Улс (ОХУ), Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д гишүүнээр элссэн ч гэсэн нэг болон олон талт гэрээ хэлэлцээрт орохдоо өөрийн онцлогийг худалдааны түншүүддээ ойлгуулсны үр дүнд импортын бараанд 30-аас дээш хувийн татвар ногдуулж чаджээ. Тэгэхэд Монгол Улс дөнгөж 5 хувийн импортын татвар ногдуулж байгаа нь гаднаас тулгасан неолиберал бодлогыг үг дуугүй хүлээн зөвшөөрч, шууд дагасны нотолгоо юм. Энэ нь үндэсний үйлдвэрлэлийг боймлох замаар улс орныг гадаад зах зээлээс хамааралтай болгож, ажилгүйдэл, ядуурлыг нэмэгдүүлэхэд хүргэжээ.

Ийнхүү "Вашингтоны тохиролцоо"-ны үр дүнд хэрэгжсэн "цочир эмчилгээний" загвар аюултай болох нь олон улс орны жишээгээр нэгэнт батлагдсан бөгөөд энэхүү бодлогыг зах зээлийн эдийн засагт шилжиж байсан орнуудад хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцсон ноён Жеффри Сакс[4] ч өөрийн буруугаа хүлээн зөвшөөрсөн байдаг.

"ОУВС-ийн Монголд тулган явуулсан мөнгөний хатуу бодлого нь зээлийн өндөр хүүг бий болгосноороо дотоодын хөрөнгө оруулалтыг ашиглах ямар ч боломжгүй болгож, Монголын аж үйлдвэрийг сүйрэлд оруулсан" гэж Кейт Гриффин бичжээ[5].

Ер нь хөгжлийн онол, үзэл баримтлал буруу байх нь хөгжил дэвшилд хүргэдэггүй нь тодорхой юм. Хуучин социалист систем задран унасны дараа тус системийн орнуудын зарим нь сайн дураараа, зарим нь мөнгөн зээл, тусламж авсныхаа төлөөсөнд зөвлөмж нэртэй тулгалтын доор барууны орнуудын эрх ашгийг хамгаалсан, хөгжиж байгаа орны эд баялгийг маш хямд цөлмөх гэсэн неолиберализмын үзэл баримтлалаар улс орноо удирдаж ирсэн боловч амжилт олоогүй, харин ч улсын өр, зээлийн хэмжээг нэмэгдүүлжээ. Неолиберал онолын үндсэн шаардлагуудад мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж, инфляцийг бууруулах, эдийн засаг дахь төрийн оролцоог хумих, үнэ, тариф, валютын ханшыг чөлөөлөх, хувьчлалыг өргөнөөр явуулах, гадаад худалдааг чөлөөлөх замаар протекционист[6] бодлогоос татгалзаж, тухайн улс орны зах зээлийг нээлттэй байлгах, гадаадын бараа, хөрөнгө оруулалтыг уул уурхайн салбар руу оруулахыг дэмжих зэрэг багтаж байна.

Либерал эдийн засгийн онолыг XVIII зууны эдийн засагч Адам Смит ба түүний үзэл нэгтнүүд үндэслэсэн бөгөөд одоо Монгол Улсад хэрэгжиж байгаа бодлого нь орчин үеийн неолиберал эдийн засгийн онолын шинэчилсэн хувилбар юм. Неолиберал үзэл 1960-аад онд үүсч, 1980-аад оноос хойш газар авган одоог хүртэл эдийн засгийн онолд голлох байр суурийг эзэлж байна. Харамсалтай нь барууны орнуудад боловсрол эзэмшсэн залуучуудын ихэнх нь энэхүү онолоор толгойгоо угаалгачихаад ирж байна. Гэхдээ энэ онолын алдааг ойлгосон шинэ үеийн залуучууд гарч ирж байгаа нь сайшаалтай. Тухайлбал, төрийн шагналт, инженер Д.Нацагням өөрийн лекцэндээ Их Британи зэрэг орнуудад чөлөөт өрсөлдөөн гэгч байгаагүй, харин ч эсрэгээр монополийн ноёрхлыг төрөөс дэмжиж байсан тухай өгүүлсэн.

Ер нь неолиберал эдийн засгийн онол бол хөгжингүй орнуудаас хөгжиж байгаа орнуудад тулгадаг буруу онол болохыг Кембрижийн их сургуулийн эдийн засгийн тэнхимд 1990 оноос хойш багшилж байгаа, 2005 онд "Эдийн засгийн ухааныг тэлсэн сэтгэгчдийн" Леонтьевын шагналыг хүртсэн, солонгос гаралтай доктор, профессор багш Чан Ха Жүн "Чөлөөт худалдааны домог ба капитализмын нууц товчоо" гэсэн номондоо

4 Нобелийн шагналт эдийн засагч.
5 Keith Griffin, Poverty reduction in Mongolia, Asia Pacific Press, 2003.
6 Хамгаалах худалдааны бодлого.

тодорхой өгүүлжээ. Тэрээр энэхүү номондоо баян орнуудын эвсэл тэргүүлж, ОУВС, Дэлхийн банк, ДХБ гэсэн гурван байгууллага зуучилж, неолиберал бодлогыг хөгжиж байгаа орнуудад тулгадаг гэжээ. Дэлхийн банк, ОУВС зээл олгохдоо неолиберал бодлогыг хэрэгжүүлэх хатуу нөхцөл тавьдаг. Үүн дээр ДХБ нэмэгдэж, баян орнуудын өрсөлдөх чадвартай салбаруудад чөлөөт худалдааны дүрмийг тулгадаг. Профессор Чан Ха Жүн: "Их Британи, АНУ нь неолиберал эдийн засгийн үндсэн үзлээс тэс ондоо бодлогуудыг баримталж баяжсан" гэдгийг энэхүү номондоо нотолжээ. Өнөөдөр баян болсон орнууд тухайн үедээ гадаадын бараанд протекционизмын арга хэмжээг авч, экспортын үйлдвэрлэлд татаас хэрэглэж, гадаадын хөрөнгө оруулагчдыг хавчих бодлого явуулж байсан бөгөөд энэ нь өмнө дурьдсан олон улсын байгууллагуудын үндсэн зарчмуудтай харшилж байжээ. Дээрх олон улсын байгууллагуудад үзэл суртлын бүхэл бүтэн арми ажилладаг. Тэдний зарим нь нэр хүнд бүхий академичид байдаг бөгөөд тэд уг нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн онолын дутагдалтай бөгөөд аюултай талыг мэдэх боловч хөгжиж байгаа орнуудад бодлогын зөвлөлгөө өгөхдөө мэдэхгүй царайлдаг гэж бичжээ. Жишээ нь, Өмнөд Солонгос Улс 1960-1980-аад онд эдийн засгийн өсөлтийн гайхамшгийнхаа үед эдийн засгийн хөгжлийн неолиберал бодлогыг баримталсан гэж худлаа сурталчилж байсан.[7] Гэтэл Солонгосын төр засаг нь хувийн хэвшилтэй зөвшилцөн аж үйлдвэрийн шинэ салбаруудыг байгуулж, тэднийг импортын татвараар хамгаалж, татаас болон өөр бусад аргаар хөхүүлэн дэмжсээр олон улсын өрсөлдөөнд оролцож чадах хүртэл өсөн томортол нь нөмөр нөөлгөндөө авч явжээ. 1998 оны Азийн санхүүгийн хямралаас өмнө Өмнөд Солонгосын төр бүх банкуудыг эзэмшиж байсан тул бизнесийн судсаар урсдаг цус болох зээлийг тодорхой салбаруудад чиглүүлж олгодог байжээ. Зарим томоохон төслүүдийг төрийн өмчит үйлдвэрүүд шууд хэрэгжүүлдэг байсан ажээ. Энэ нь Өмнөд Солонгосыг өнөөгийн өндөр хөгжилд хүргэсэн бодитой жишээ юм.

Үндэсний язгуур эрх ашгаа дээдэлсэн, өөрийн орны онцлогт тохирсон, төрийн зөв, оновчтой бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн нөхцөлд хөгжил дэвшилд хүрэхэд 27 жил бол огт багадахааргүй хугацаа юм гэдгийг Зүүн өмнөд Азийн улсуудын туршлага нотлон харуулж байна. Тухайлбал, Сингапур Улс 1965 онд 2 сая гаруй хүн амтай, Их Британий колоничлолоос дөнгөж чөлөөлөгдсөн ядуу буурай загасчдын тосгоноос 25 жилд буюу 1990 он гэхэд нэг хүн амд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээ нь 12,5 мянган долларт хүрч, Азийн эрчимтэй хөгжиж байгаа улс орон болсон туршлага бидэнд их сургамжтай юм. Энэ тухай Сингапурын гайхамшгийн эцэг гэгддэг тус улсын Ерөнхийлөгчөөр олон жил ажилласан Ли Куан Ю-гийн бичсэн "Сингапурын хөгжлийн нууц" гэдэг номонд тодорхой өгүүлжээ. Сингапурын үсрэнгүй хөгжлийн онолын үндэс нь неолибарал үзэл биш, харин Ли Куан Ю-гийн өөрийн гэсэн "гуравдагч" замаар хөгжих ёстой хэмээх үзэл санаа байжээ. Энэхүү үзэл санааны мөн чанар нь нийгэмд бүрэлдэн бий болсон тодорхой түүхэн нөхцөл байдал, үндэсний болон шашин шүтлэг, соёлын онцлогуудыг сайтар тооцож, эдийн засгийн хөгжил дэвшлийг уламжлалт ёс суртахууны болон соёлын үнэт зүйлстэй хослуулж, хуучин ардын уламжлалт цэцэн мэргэн ухааныг хийсвэр онолоос дээгүүр тавьж, эх оронч үзэл, авах гээхийн ухаан, бүтээлч байдлыг үзэл сурталжсан элдэв төрлийн онолын үзэл баримтлалаас чухалд үздэгт оршино хэмээн дээрх номын өмнөтгөлд дурджээ.

Сингапурын Ерөнхийлөгч асан Ли Куан Ю өөрийн номондоо "Хэрэв бидний амжилтыг тайлбарлах ганцхан жор байгаа гэж үзвэл тэр нь бидний зүгээс юу хийвэл

7 Солонгосын эдийн засгийн гайхамшигийг неолибералчид хэрхэн ташааруулж бичдэгийг А.Амсден (1989), Чан Ха Жүн (2006) нар шүүмжилсэн байдаг.

амжилт олох, эсвэл яаж хийвэл илүү амжилт олж болох вэ гэдгийг зогсолтгүй судалж, эрэл хайгуул хийж байсан явдал гэж би хэлнэ. Би хэзээ ч аль нэг онолын барьцааны хүн байгаагүй. Бид зөвхөн учир шалтгаан, бодит нөхцөл байдалд захирагддаг байсан юм. Аль нэг онол, тогтолцоог судлахдаа бодит амьдрал дээр энэ бүтэх үү гэдэг асуултыг зайлшгүй тавьж, шинжилдэг байсан. Энэ бол миний олон жил алба хашихдаа хийсэн ажлуудыг маань холбосон алтан утас билээ" гэж бичжээ.[8] Энэ үг нь бид хөгжлийн бодлого, төлөвлөлтөд аль нэг онол, үзэл номлол, тэр тусмаа неолиберал бодлогыг сохроор дагах бус, харин өөрийн улс орны онцлог нөхцөл байдлыг харгалзсан прагматик хандлага баримтлах нь чухал гэдгийг нотолж байгаа юм.

1965 оны Сингапурын дэргэд 1990 онд Монгол Улс хүн амынх нь 97 хувь нь бичиг үсэгтэй, гадаад, дотоодод өндөр боловсрол эзэмшсэн мэргэжилтнүүдтэй, хөнгөн, хүнсний аж үйлдвэр, хүнд үйлдвэрийн зарим салбар хөгжсөн, хэрэндээ үйлдвэржсэн, байгалийн арвин их баялагтай, 25 сая малтай, үр тариагаар улс орноо бүрэн хангачихдаг, ядуурал гэдгийг мэддэггүй, насанд хүрсэн хүн бүр шахам ажил эрхэлдэг улс орон байсан. Гэтэл 27 жилийн дараа эргээд харахад Монгол Улс аж үйлдвэр нь хувьчлалаар бүрэн сүйрч унасан, ядуурал хүн амынх нь гуравны нэгийг хамарсан, хүн амын дотор баян, хоосны ялгаа эрс нэмэгдсэн, өр зээлэнд баригдсан, төр нь авилгад идэгдсэн улам доройтсоор байгаа улс болж хувираад байна. Сүүлийн жилүүдэд ард олны төрд итгэх итгэл алдарч, засаглалын чанар эрс муудаж, авлигын улмаас төр, засгийн үйл ажиллагааны залгамж чанар улам алдагдаж байна. Монгол Улс өнгөрсөн 27 жилд Сингапур шиг үсрэнгүй хөгждөггүй юм аа гэхэд ядаж хүн амынхаа 1/3-ийг ядууралд оруулахгүйгээр, дан ганц уул уурхайг шүтэж амьдардаггүй, гадаадын үндэстэн дамнасан корпорацуудад үнэт баялгаа зүгээр өгчихөөд дээр нь өрөнд ороод хүлээгээд сууж байхгүй улс болж болох байлаа. Өнгөрсөн 27 жил бол засаглалын хямрал, хүний ёс суртахууны доройтол болон төрийн алдаатай бодлогын улмаас "буруу замаар будаа тээсэн", хөгжлийн боломжоо алдсан он жилүүд байлаа.

Иймд, Монгол Улсын төрийн бодлогын онол болон үзэл баримтлалын алдааг цэгнэн үзэж, дахин давтахгүй сургамж болгохын тулд төр, засгийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахад мэргэшсэн "Think tank" бодлогын судалгааны байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн мэргэдийн оролцоо хамгийн чухал байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, өнгөрсөн 27 жилд Монгол Улсын төрөөс эдийн засгийн салбарт хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь барууны орнууд болон олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудаас хөгжиж байгаа улс орнуудад тулгаж байдаг неолиберал онол, Монгол Улсын хөгжлийн өвөрмөц онцлогоос тасархай, үндэсний язгуур эрх ашигт харшилсан бодлого болох нь бараг хүн бүхэнд ойлгомжтой болж байгаа боловч тус улсын төр, засгийн зүгээс энэхүү бодлогыг засах, залруулах талаар ямар нэг арга хэмжээ авахгүй байгаа нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна. Энэхүү неолиберал бодлогын үр дүнд өнгөрсөн 27 жилд манай орны аж үйлдвэрийн салбарыг үндсэнд нь устгаж, ажилгүйдэл, ядуурал, өр, зээлийг нэмэгдүүлэх нөхцлийг бий болгосон гэж үзэж байна. Тэгвэл өндөр хөгжилд хүрч чадсан Зүүн Азийн зарим орны туршлагаас харахад төрийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь өөрийн орны эдийн засгийн хүчин чадал, багтаамж, газар зүйн байршил, байгаль цаг агаарын нөхцөл, ард түмний ахуй, амьдрал, сэтгэлгээ, түүх, соёл, уламжлал, зан заншил зэрэг өвөрмөц онцлогуудыг сайтар харгалзан үзэж, ард түмнийхээ язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, үсрэнгүй хөгжлийн ололт, амжилтад хүргэсэн байгааг цохон тэмдэглэмээр байна. Энд ямар нэг гадны онол, арга, үзэл номлолыг шууд хуулбарлах

8 Ли Куан Ю, Сингапурын хөгжлийн нууц, 753-р тал.

бус, тэр тусмаа неолиберал бодлогыг сохроор дагах бус, харин өөрийн улс орны өвөрмөц онцлог, нөхцөл байдлыг харгалзан авах, гэээхийн ухаанаар прагматик хандсанаар амжилтад хүрч болохыг бусад орны туршлага бидэнд анхааруулж байна.

Эдгээр алдааг засаж залруулахад дараах арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Өнгөрсөн 27 жилийн туршид тус улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн зэрэг бүх салбарт хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаанд үнэлэлт өгч, улс төрийн дүгнэлт гаргах, цаашид алс хэтийн хөгжлийнхөө чиг хандлагыг тодорхойлохын тулд “неолиберал онолыг Монгол Улсад хэрэгжүүлсний үр дагавар” сэдвээр бүх нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Улс орны онцлог нөхцөл байдлыг харгалзсан, үндэсний язгуур эрх ашгаа нэн тэргүүнд тавьсан Монгол Улсын хөгжлийн бодлогын онол, арга зүйн үзэл баримтлалыг шинээр томъёолох, зарим олон улсын байгууллага, тухайлбал, ДХБ-тай байгуулсан гэрээ хэлэлцээрийг шинэчлэх, ОХУ, БНХАУ гэсэн хөрш орнуудтай худалдааны салбарт байгуулсан хоёр талт хэлэлцээрүүдийг шинэчлэх, тэгш эрхтэй худалдааг зохион байгуулах;
- Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлого, үйл ажиллагаандаа үндэсний боловсруулах аж үйлдвэрээ сэргээн хөгжүүлэх зорилтыг тавьж, неолиберал бодлогоос татгалзах, үндэсний үйлдвэрлэлээ төрөөс хамгаалах зорилгоор дотооддоо чөлөөт эдийн засгийн бодлого, гадаадад протекционист бодлого хэрэгжүүлэх;
- Дээрх арга хэмжээний хүрээнд нэн тэргүүнд төрөөс өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй эх орны үйлдвэрүүдэд өмчийн хэлбэр харгалзахгүй захиргааны болон захиргааны бус дэмжлэг, туслалцаа үзүүлэх, татаас олгох, татварын болон зээлийн хөнгөлөлт үзүүлэх замаар экспортыг урамшуулах, импортыг оновчтой, уян хатан, үе шаттай хязгаарлах (тарифын болон тарифын бус хязгаарлалт, олон зорилго чиглэлтэй стандартууд, лиценз, квотууд тогтоох) шаардлагатай байна.

### 1.3. Төрийн хөгжлийн нэгдмэл бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Монгол Улсад 1990 оноос өмнө хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг Улсын төлөвлөгөөний комисс хариуцдаг, эрх мэдэл нь тухайн үеийн яамдынхаас дээгүүр байсан бөгөөд түүнийг Сайд нарын зөвлөлийн орлогч дарга шууд удирддаг байв. Тус комисст өндөр ур чадвартай шилдэг инженер, эдийн засагчдаас бүрдсэн хүчирхэг том баг ажиллаж байсан. Энэ үед улс орны хэмжээний хөгжлийн бодлого, чиглэлийг 5 жилийн төлөвлөгөөний үндсэн дээр боловсруулж, ингэхдээ орц, гарц, ашгийн норм, нормативуудыг хатуу чанд мөрдөж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх шатанд төр, засгаас их анхаарал тавьж, хариуцлагын болон урамшууллын механизмуудыг сайн ашиглаж байсан нь түүхийн асар богино хугацаанд манай улсын эдийн засаг, нийгмийн бүх салбарууд тэгш бөгөөд үсрэнгүй хөгжих нөхцлийг бүрдүүлж, хөгжлийн хоцрогдлыг арилгахад чухал нөлөө үзүүлсэн юм.

Гэтэл ҮХГ байгуулагдаж улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах чиг үүргийг 1992-1996 онд хэрэгжүүлж байсныг өөрчилж Сангийн яам болон дараа нь Санхүү, эдийн засгийн яаманд хариуцуулах болсон.

Манай оронд дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах улс орны өөрийн нөхцөл байдалд тохирсон арга, аргачлал, арга зүй, зарчмуудыг тодорхойлсон гарын авлага, заавар, арга зүйн материал үндсэндээ ховор байна. Харин "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам" батлах тухай Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 249 дүгээр тогтоол гарснаас хойш ийм баримт бичиг шаардлагатай юм байна гэдгийг ойлгож эхэлж байна. Гэвч энэхүү журам нь нэлээд учир дутагдалтай болохыг бид судалгааны явцад олж тогтоосон юм.

Тэгвэл хөгжингүй орнууд болон хөгжиж буй зарим оронд төр, засгийн эрхэнд ямар улс төрийн нам гарахаас үл хамааран нэгэнт батлагдсан дунд болон урт хугацааны төрийн бодлого, төлөвлөгөөг тухайн Засгийн газар үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, алдаа, мадаг, хазайлтыг тухай бүрт нь залруулж байдаг хэвшчихсэн практик бий. Юуны өмнө манай оронд хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахад шаардлагатай онол арга зүйн гарын авлага, материалуудыг бий болгох хэрэгтэй.

Монгол Улсад 1990 оноос хойш нийтдээ 480 гаруй дунд болон урт хугацааны стратеги, үзэл баримтлал, хөтөлбөр, бодлого, мастер төлөвлөгөө гэх мэт хөгжлийн бодлогын баримт бичгүүд батлагдан мөрдөгдөж ирсэн байна.[9] Харамсалтай нь эдгээр бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт нь ихэнх тохиолдолд хангалтгүй байжээ. Үүний гол шалтгаан нь бодлого боловсруулах арга зүй, хэрэгжүүлэх үйл явц нь шинжлэх ухааны үндэслэл муутай, хөнгөн хийсвэр байсны зэрэгцээ зөвхөн хэсэг бүлэг сонгогчидтой хийсэн уулзалтын үр дүнг харгалзсан, эсвэл гадны туршлагыг өөрийн онцлогт тохируулалгүй шууд хуулбарласантай холбоотой гэж үзэж байна. Ялангуяа хөгжлийн бодлого боловсруулах үндэс суурь болсон өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийгээгүй, тулгамдаж буй асуудлаа сайтар судлаагүй, эдийн засгийн болон үйлдвэрлэлийн бодит нөөц боломжийг сайтар тооцоогүй, нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлаа тодорхойлоогүй, шаардагдах хөрөнгө, санхүүгийн хэмжээ тодорхой бус, хариуцах эзэн, хүрэх үр дүн, цаг хугацаа тодорхой бус, мөн мэргэжлийн хүмүүсийн оролцоо хангалтгүй байсан зэргээс эдгээр нь амьдралд хэрэгжих магадлал багатай, мөрөөдлийн шинжтэй зорилго, зорилтуудыг дэвшүүлж иржээ. Түүнчлэн сайд, дарга шинээр томилогдсоноор баг бүрдүүлэх, эсвэл шинэчлэл хийх нэрийн дор яам, агентлагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, төрийн мэргэшсэн албан хаагчдыг халж, нам, улс төр, нас хүйс, жалга довны шалгуураар мэргэжлийн бус хүмүүсээр солих явдал газар авчээ. Мөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг гадны байгууллагын шахалтаар богино хугацаанд яаруу давчуу, тооцоо судалгаагүй боловсруулж, ажил хийсэн дүр үзүүлж ирсний улмаас батлагдсан бодлогын баримт бичиг нь хэрэгжихгүй зүгээр цаасан дээр үлддэг баримт цөөнгүй байна. Тухайлбал, МХЗСЧХЦБ-д 2007-2015 онд эдийн засгийн өсөлтийг жилд дунджаар 14 хувьд хүргэнэ гэж тусгасан байв. Гэтэл 2000-2005 оны эдийн засгийн жилийн дундаж өсөлт 5,6 хувь байсан бөгөөд 2005-2010 оных 6,5 хувь, харин 2007-2015 оны жилийн дундаж өсөлт 8,1 хувь байжээ. Энэ нь эдийн засгийн өсөлтийн өмнөх онуудын дунджийг үнэхээр бодитой харгалзан үзээгүй, цаашдын өсөлтөд нөлөөлж болох гадаад, дотоод, эсрэг ба сөрөг хүчин зүйлсийг тооцоогүй, нөхцөл байдал муудахад үүсэх эрсдэлийг урьдчилан хараагүй, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй, баримжаалсан, эсвэл найдсан, хэрэгжих үндэс багатай зорилтууд байсан нь тодорхой болжээ.

Өнгөрсөн жилүүдийн практикаас харахад улс орны хөгжлийн бодлогод тодорхойлсон томоохон төсөл, хөтөлбөрүүд нь судалгаа шинжилгээнд үндэслээгүй,

9 ҮХГ-ын тооцоолол (2017 оны байдалд).

зөвхөн улс төрчдийн хувийн (мэдлэг гэхээс илүү) мэдээлэл дээр үндэслэсэн, мэргэжлийн байгууллагуудын үнэлгээ, дүгнэлтийг тусгаагүй, үндэсний эрдэмтдийн санал, зөвлөмжийг хэрэгсээгүй, өртөг, үр ашиг, үр дүнг тооцолгүй хийгдсээр иржээ. Тухайлбал, Сайншандын аж үйлдвэрийн парк байгуулах тухай өмнөх Засгийн газрын шийдвэр нь ашигт малтмалын нөөцүүдтэй төмөр болон засмал замаар холбогдоогүй, үндсэн хэрэглэгчээс хол зайтай, усны хомсдолтой говийн нөхцөлд олон тооны үйлдвэрүүдийг байгуулж, үр ашигтай ажиллуулах боломжгүй гэсэн зарим мэргэжилтний дүгнэлттэй зөрчилдсөн байна. Эгийн голын усан цахилгаан станц байгуулах асуудлыг бүр 1996 оноос ярьж эхэлсэн байдаг. Хэдийгээр уг бүтээн байгуулалтыг гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг БНХАУ шийдвэрлэхээр болсон ч өнөөдөр Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээ бүрэн сайн хийгдээгүй учир ОХУ, Монгол Улсын хооронд маргаан дагуулсан асуудал болж хувирчээ. Энэ нь аливаа томоохон төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулахдаа нөхцөл байдалд шинжилгээ хийж, ирээдүйд үүсэж болох эрсдэл, асуудлыг сайтар судалж, төслийн эдийн засгийн үр өгөөж, боломжийг сайтар тооцож, шаардагдах хөрөнгө, санхүүгийн хэмжээ, хариуцах эзэн, хүрэх үр дүн, хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхой болгож, дүгнэлт хийсний дараа эцсийн шийдвэр гаргадаг аргачлалыг ашиглах шаардлагатай байгааг нотолж байна. Энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд зориуд тусгах шаардлагатай юм. Олон улсын жишгээр бол ямар нэг тодорхой асуудлаар бодлого боловсруулахад зөвхөн зорилт дэвшүүлээд орхидоггүй, уг зорилтдоо ямар арга замаар хүрэх хувилбаруудыг боловсруулж, ямар тодорхой арга хэмжээ авах, ямар ажлуудыг хэзээ хийж гүйцэтгэх талаар оролцогч талуудыг хамруулан сайтар шүүн хэлэлцэж, төлөвлөдөг байна. Өөрөөр хэлбэл, аливаа бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд нь “Ухаалаг” (SMART) буюу дараах зарчмуудыг агуулсан байх ёстой. Үүнд:

S - Specific (зорилго тодорхой байх);

M - Measureable (хэмжиж болохуйц);

A - Achievable (зорилгодоо хүрч болохуйц байх);

R - Realist (бодитой байх);

T - Time (цаг хугацаaатай байх).

*Эх сурвалж: An Introduction to the Policy Process: Theories, Concepts, and Model of Public Policy Making/ Third Edition, Thomas A. Birkland.*

Эдгээр зарчмуудыг зэрэгцүүлэн хэрэгжүүлэх бодлогын арга хэрэгслүүдийг тодорхой болгох шаардлагатай. Тухайлбал, уг хөгжлийн бодлогын баримт бичгийг амьдралд бодитой хэрэгжүүлэхдээ төрөөс ямар арга хэрэгслээр (эдийн засгийн болон захиргааны) дэмжлэг үзүүлэхээ сайтар тодорхойлох хэрэгтэй. Үүний тулд төрийн зохицуулалтын арга хэрэгслүүд болох улсын төсвийн зардал, хөрөнгө оруулалт, төрийн болон төрийн өмчит компаниудын худалдан авалт, мөнгө, зээл, гадаад худалдааны бодлого, татварын чөлөөлөлт, зээлийн хөнгөлөлт, газрын зохицуулалт, тусламж дэмжлэг, үнэ тарифийн хөнгөлөлт, гадаад валютын хяналт, зохицуулалт зэрэг бодлогын олон арга хэрэгслүүдийг ашиглаж болно.

Нөгөө талаас, манай улсын дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх тайланг хэлэлцэх тогтолцоо байхгүй, мэдээлэл ил тод бус зэрэг дутагдлууд байна. Харин энэ ажлыг хариуцсан яам, агентлаг нь өөрсдөө дүгнэж, явцуу хүрээнд танилцуулж буй нь түүний үнэн зөв гэдэгт эргэлзэхэд хүргэж байна.

Арга зүйн хувьд Монгол Улсад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцын ялангуяа 2 дахь буюу хэрэгжүүлэх үе шатанд асуудлууд шийдэгдэлгүй явж ирснээс хөгжлийн талаар тодорхойлсон бодлого, хөтөлбөр, түүнд дэвшүүлсэн зорилго, зорилтууд бүрэн хэрэгжихгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Уг нь бол хөгжлийн дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд л баталдаг билээ. Гэтэл манай орны хувьд бодлого, төлөвлөгөөг баталдаг боловч түүнийг богино (0-1 жилийн) болон (1-3 жилийн) дунд хугацаанд хэрэгжүүлэх ажлуудын дэс дараалал, шаардагдах хөрөнгө санхүүгийн хэмжээг үндэслэлтэй тодорхой зааж өгдөггүй нь урт хугацааны бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт хангалтгүй болох үндэс болж байна. Тухайлбал, урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дунд хугацааны бодлогын төлөвлөгөөг огт хийгээгүй нь түүнийг хэрэгжүүлэх боломжгүй болгожээ. Таван жилийн хугацаатай, жил жилээр задаргаатай дунд хугацааны төлөвлөгөөндөө урт хугацааны бодлогын зорилтуудаа үе шаттайгаар үйл ажиллагаа болгон задлан шингээсэн тохиолдолд л уг төлөвлөгөө хэрэгжих бодит нөхцөл бүрдэхээр байлаа. Гэтэл манай орны хувьд дунд хугацааны бодлогын төлөвлөгөөний оронд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Сангийн яамны 3 жилийн хугацаатай нэгдсэн төсвийн төслийн хүрээний мэдэгдэл зэргийг хийдэг бөгөөд тэдгээр нь дунд хугацааны бодлогын төлөвлөгөөг орлож чадахгүй хэд хэдэн шалтгаан бий. Тухайлбал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь аль нэг улс төрийн намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан улс төрийн бөгөөд популист шинжтэй зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тул улс орны урт хугацааны бодлогын зорилтуудыг үе шаттай хэрэгжүүлэх зорилтуудыг системтэй тусгаагүй баримт бичиг байдаг. Сангийн яамнаас боловсруулдаг гурван жилийн хугацаатай төсвийн хүрээний мэдэгдэл нь макро эдийн засгийн цөөн хэдэн тооны үзүүлэлтүүд болон зөвхөн улс орны төсөв, санхүүгийн байдлын ойрын 3 жилийн төсөөлөл байдаг учир эдийн засгийн салбаруудын хөгжлийн урт хугацааны бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх үндэслэл болж чадахгүй юм. Иймд юуны өмнө МУТХҮБ-2030-д тусгагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2030 онд хүрэх түвшинг 5 жил бүрээр задлан үе шаттай, харилцан уялдаатай төлөвлөх шаардлагатай юм. Ингэснээр улс орны урт хугацааны хөгжлийн бодлого үе шаттай хэрэгжих бодит нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн залгамж шинж чанар хангалтгүй, бодлогыг хэрэгжүүлэх шатанд алдаа гардаг, ялангуяа бодлого, төлөвлөлтийг боловсруулах арга зүй, үндэслэл ихээхэн сул байгаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институцийн статус, түүний үйл ажиллагаа тогтворгүй байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

**Зураг 1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийг хариуцах чиг үүргийн шилжилт**




Аливаа улс орны Сангийн яамны чиг үүрэг нь улсынхаа төсвийн бодлого, төлөвлөлт, төсвийн зарцуулалт, тайланг, өөрөөр хэлбэл, санхүүгийн бодлого, төлөвлөлтийг голлон хариуцах явдал бөгөөд харин хөгжлийн бодлогын асуудлыг ихэвчлэн эдийн засгийн

яам, эсвэл хөгжлийн яам хариуцдаг нийтлэг практик байдаг. Тэгвэл манай улсад 2000 оноос эхлэн Сангийн яамыг Санхүү, эдийн засгийн яам болгон өөрчилж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг бүхлээр нь нэг хэлтэст хариуцуулж байсан нь улс орны хэмжээний дунд болон урт хугацааны бодлого, төлөвлөлт, салбарын бодлогыг уялдуулан төлөвлөх үүрэг бүхий төрийн институцийн хувьд томоохон ухралт болсон юм.

Дараа нь 2008 онд Үндэсний хөгжил, шинэчлэлтийн хороог байгуулж, түүнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг хариуцуулсан нь бие даасан бүтэц бий болгоход чухал алхам болсон боловч эрх мэдлийн хувьд агентлагийн статустай байв. Ийм статустай, эрх мэдэл багатай агентлаг нь яамдуудыг удирдан улсын хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийхэд үнэндээ хүндрэлтэй байсан.

2012 оны сонгуулийн дараа Засгийн газрын бүтцэд Эдийн засгийн хөгжлийн яам, Аж үйлдвэрийн яамыг байгуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг эдгээр яамдад давхар хариуцуулж, Сангийн яам голлон зангидаж байв. Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсанаар үндэсний хэмжээний урт хугацааны бодлого, төлөвлөлтийн асуудал яамны статустай болж, хөгжлийн бодлогын тогтолцоо бүтцийн хувьд төлөвших хандлагатай болсон боловч яамдуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг сайжруулах, өмнөх алдааг засаж залруулах гэсээр байгаад бүрэн эрхийн хугацаа нь дууссан. Гэвч 2016 онд байгуулагдсан шинэ Засгийн газар дээрх яамдуудыг татан буулгаж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар гэсэн 2 газарт давхар хариуцуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг дахиад агентлагийн түвшинд аваачиж тавьсан.

Эндээс дүгнэж хэлэхэд, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн институц нь бүтэц, зохион байгуулалт, эрх үүргийн хувьд тогтворгүй, шинээр Засгийн газар байгуулагдах бүрт өөрчлөгдөж байжээ. Ингэснээр төрийн яамдын үйл ажиллагааны стратеги, бүтэц зохион байгуулалт, төрийн албаны боловсон хүчний нөөц, ур чадвар, гүйцэтгэлийн чанар суларч өөрчлөгдсөнтэй уялдан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хоёрдугаарт тавигдаж иржээ. Энэ байдал нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог туйлын тогтворгүй, ойлгомжгүй болгосон.

Манай улс өнгөрсөн 27 жилийн хугацаанд Монгол Улсад Засгийн газрууд эмхлэн байгуулагдах бүрт урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг хариуцсан байгууллагын статус, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны цар хүрээ байнга өөрчлөгдөж, зарим яам, агентлагын хавсарга болж, зарим чиг үүрэг нь давхардан саармагжсан байдалтай явж иржээ.

Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг боловсруулах тогтсон арга, аргачлал, арга зүй устаж үгүй болсон гол шалтгаан нь түүнийг хэрэгжүүлэгч институцийн үйл ажиллагааны тогтворгүй байдалтай холбоотой гэж үзэж байна. Энэ нь хөгжлийн бодлогыг залгамж чанаргүй, ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй болгоход хүргэсэн байна. Өнөөдөр ч гэсэн хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал нь Сангийн яам болон Үндэсний хөгжлийн газрын дунд хоёрдмол бүтэцтэй, үүрэг хариуцлага нь саармагжсан байдалтай байна.

Өнгөрсөн он жилүүдийн практикаас харахад улс орны хөгжлийн бодлого нь зөвхөн улс төрчдийн хувийн мэдээлэл дээр илүү суурилсан, эсвэл гадны байгууллагын зүгээс өгсөн манай нөхцөл байдалд таарч тохирохгүй санал, зөвлөмжийг шууд дагасан шинжтэй байсны зэрэгцээ судалгаа шинжилгээн дээр үндэслээгүй, мэргэжлийн байгууллагуудын үнэлгээ, дүгнэлтийг тусгаагүй, өртөг, үр ашиг, үр дүнгийн судалгаагүй хийгдэж байжээ.

Ингэснээр хөгжлийн бодлого нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэлбэртэй болж, эрх баригч намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан популист амлалтыг биелүүлэхэд чиглэгдэж, нийт улс үндэсний гэхээсээ илүү тойрог, жалга довны эрх ашгийг нэн тэргүүнд тавьсан, улс үндэстний хөгжлийн эрх ашгийг хөндөөгүй зорилтуудаас бүрдэж иржээ. Энэ нь хөгжлийн бодлогыг бүрэн саармагжуулахад хүргэсэн гэж үзэж байна.

Аливаа хөгжлийн бодлого боловсруулахдаа юуны өмнө өнөөгийн нөхцөл байдал, дотоод болон гадаад орчны шинжилгээ, нөлөөлж буй эерэг ба сөрөг хүчин зүйлсийг илрүүлж, сул ба давуу талууд болон боломжууд, эрсдлийг тодорхойлж, үйлдвэрлэлийн нөөц, чадамжид үнэлгээ өгөх хэрэгтэй. Мөн уг бодлогын төслийг мэргэжлийн хүмүүс болон ашиг сонирхол нь хөндөгдөх талуудыг өргөнөөр оролцуулан хэлэлцүүлж, хөгжлийн таамаглалыг 2-3 хувилбараар дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэх соёл, зан төлвийг бий болгох нь нэн чухал юм. Үүний хамт тулгамдаж буй асуудлуудыг эрэмбэлэн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, салбаруудын оновчтой бүтэц, бодлогын арга хэрэгсэл, механизм, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, хэрэгжүүлэгч институциудын бодлого, үйл ажиллагааны уялдааг хангахад шаардлагатай нөөцийн байршлыг оновчтой тодорхойлох шаардлагатай юм. Уг бодлогыг хэрэгжүүлэх явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гарсан алдааг засах, шалгуур үзүүлэлтүүдээс хайсан шалтгааныг тогтоож, залруулга хийх ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүний тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн яамыг (институц) байгуулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн ажлын эрх зүйн орчныг бүрдүүлэх, бодлого төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллахад анхаарах;
- Урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн гол үндэс болсон дунд хугацааны (5 жилийн) төлөвлөгөөний үндэслэлийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн яам дагнан боловсруулдаг байх эрх зүйн зохицуулалтыг хийх;
- Олон улсын шилдэг туршлагатай нийцүүлэн одоо ашиглаж байгаа хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн ажлыг боловсронгуй болгох, нэгдсэн нэг аргачлалтай болох, судалгаа шинжилгээнд тулгуурлах, эдийн засгийн болон үйлдвэрлэх хүчний бодит нөөц, боломжийг сайтар тооцох, ялангуяа бодлого боловсруулалтын шатанд мэргэжлийн хүмүүс болон ашиг сонирхол нь хөндөгдөх талуудын саналыг тусгах эрх зүйн үндсийг бүрдүүлэх.

# БҮЛЭГ 2. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛААР ГАРСАН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮДЭД ХИЙСЭН СУДАЛГАА

## 2.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2.2.-т Засгийн газрын нийтлэг чиг үүрэгт “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж УИХ-д өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх” гэж тусгасан нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн эрх зүйн тулгуур үндэс юм.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-т “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдэл, дараа жилийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулж, Улсын Их Хурал (УИХ)-д өргөн мэдүүлнэ” гэж заасан нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлж өгсөн хэрэг юм. Түүнчлэн, хуулийн 10 дугаар зүйлийн 1-т “Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоон хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ” гэсэн заалт нь манай улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг шийдэхэд амин чухал болович бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна.

Цаг хугацааны хувьд нэлээд олон жил хэрэглэж ирсэн хууль нь Монгол Улсын Төсвийн тухай хууль билээ. Энэхүү хуулийн 8 дугаар бүлэгт “Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичиг болон төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах” талаар тусгасан хэдий ч энэ нь зөвхөн улс орны санхүүгийн, түүний дотор өр зээлийн бодлого төлөвлөлтийн асуудалтай холбоотой. Гэхдээ энд өр зээлийг эдийн засгийн ямар салбарыг хөгжүүлэхэд ямар хэмжээтэй, хэрхэн ашиглах, түүний үр өгөөжийг дээшлүүлэх талаар ямар ч зохицуулалт тусгагдаагүй байна.

2004 оны УИХ-ын 2 дугаар тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам”-ыг баталсан. 2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Засгийн газрын 88 дугаар тогтоолоор “эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулах нийтлэг загвар”-ыг мөн батлан гаргажээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг УИХ дөнгөж 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан бөгөөд мөн хуулийн 6.6. дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 249 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг баталжээ.

Засгийн газрын 123 дугаар тогтоолоор 2010 онд батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлах нийтлэг журам”-ыг үндэслэн Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргын 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 137 дугаар тушаалаар “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах аргачлал”, “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх аргачлал” болон “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслүүдийг эрэмблэх аргачлал”-ыг баталсан байна.

2015 оноос өмнө Монгол Улсад дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал ямар ч эрх зүйн зохицуулалтгүй явж байжээ. Тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль, журмуудын дагуу Засгийн газрын үүрэг зөвхөн улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг биелүүлэхэд чиглэгдэж ирсэн байна. Харин 2010 оноос эхлэн Засгийн газар хөгжлийн бодлогогүй явж ирснээ анзаарч, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг боловсруулах, үнэлэх, эрэмбэлэх аргачлалыг боловсруулах үүргийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд өгсөн. Гэвч улс орны хөгжлийн бодлогыг боловсруулах төрийн яамны статустай байх ёстой байгууллагын үүрэг маш жижиг зүйлд чиглэгдэж, зөвхөн төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд үнэлгээ өгөх эрх мэдлээр хязгаарлагдаж, ингэснээр хөгжлийн бодлого боловсруулах үндсэн үүрэг нь орхигдож иржээ.

Харин УИХ-аар 2015 онд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг үе шатаар төлөвлөх, хэрэгжилтийг нь зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх замаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бий болгоход чиглэгдэж, 1990 оноос хойш анх удаа Монгол Улсад дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлын хууль эрх зүйн үндсийг тавьсан маш ач холбогдолтой хууль болсон гэж энэ чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн судлаачид үзэж байна.

Тэгэхдээ дээр дурьдсан нөхцөл байдлын улмаас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг шинэчлэн батлуулах шаардлага байна.

## 2.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг төгөлдөржүүлэх санал, зөвлөмжүүд

1. *Хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт хугацааны баримт бичгийн талаар:*

- Хөгжлийн үзэл баримтлал гэснийг “Хөгжлийн чиг баримтлал” гэж өөрчлөх, ингэснээр 15-20 жилийн хөгжлийн хугацаатай чиг баримтлал байвал зохимжтой;
- Хөгжлийн чиг баримтлал дээр үндэслэн нарийвчлан хөгжлийн урт хугацаатай (15 жил) хөтөлбөрийг боловсруулах; Ингэхдээ хөгжлийн бодлогын урт хугацаатай баримт бичиг нь “Чиг баримтлал”, “Хөтөлбөр” гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд аль нэгийг нь сонгох хэрэгтэй.

2. *Хөгжлийн төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичгийн талаар:*

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 5 жилийн нэг л нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж байхаар тусгах;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.3. дахь хэсэгт “Төрөөс баримтлах бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт” гэсэн гурван баримт бичгийг тусгайлан боловсруулах шаардлагагүй гэж үзэж байна. Учир нь эдгээр баримт бичгүүдийг хөгжлийн урт хугацааны хөтөлбөр болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусдаа хэсэг, бүлэг болгон тусгах хэрэгтэй. Тухайлбал, Засгийн газрын холбогдох байгууллагууд урт хугацааны хөтөлбөр, дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулахдаа улс орны хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тусгадаг;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.4. дэх хэсэгт дурьдсан

"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр" болон "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" нь бие даасан бодлогын хөтөлбөр биш юм. Учир нь, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөр болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан бодлого, зорилтуудтай уялдуулан нийцүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бүтэц, зохион байгуулалт, арга хэмжээний төлөвлөгөө байх ёстой юм.

- Уг хуулийн 6.4. дэх хэсэгт заасан "Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр", "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийг тусгайлан боловсруулж байх шаардлагагүй юм. Учир нь, нэгдүгээрт, улсын хөрөнгө оруулалт гэдэг нь улсын төсвийн хөрөнгө оруулалт бөгөөд үндэсний хэмжээний хөгжлийн бодлого төлөвлөлтийн хөтөлбөр, төлөвлөгөөнд улсын төсвийн болон хувийн хэвшлийн, гадаад болон дотоодын бүх хөрөнгө оруулалт багтана. Хоёрдугаарт, улсын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд бүтээн байгуулалтын арга хэмжээ, төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө, түүний эх үүсвэр заавал тусгагдаж байх учир улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр гэж томьёолох шаардлагатай.

*3. Хөгжлийн богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн тухайд:*

Богино хугацааны буюу нэг жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх баримт бичгийг "үндсэн чиглэл" гэж нэрлэж ирснийг өөрчилж "төлөвлөгөө" гэж нэрлэх. Учир нь үндсэн чиглэл гэдэг бол 15-20 жилийн буюу урт хугацааны чиг баримжаа гэсэн утга агуулгатай нэр томьёо юм.

*4. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлагын бүтцийн тухайд:*

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын бүрэлдэхүүнд улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн яам байгуулах тухай зүйл заалтыг оруулах.

Өнөөгийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуульд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам хариуцахаар тусгасан байгаа нь буруу юм. Учир нь, нэгдүгээрт, Сангийн яам нь улс орны дунд болон урт хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын асуудлыг хариуцдаг яам биш юм. Хоёрдугаарт, төсвийн бодлого болон төсвийн хөрөнгөөр улс орны хөгжлийн үндсэн суурь, хүчин зүйл болох ёстой эдийн засаг, аж үйлдвэрийг хөгжүүлэх, дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх боломжгүй юм. Ийм учраас, Засгийн газрын бүрэлдэхүүнд улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг илүү өргөн хүрээнд хариуцан чиглүүлдэг, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх үүрэг бүхий байнгын ажиллагаатай тусгай яам байгуулахыг хуульчлан тогтоох шаардлагатай юм. Үүний тулд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог бүх түвшинд бүрдүүлэхийн тулд салбарын яамд болон аймаг, нийслэлийн засаг, захиргааны бүрэлдэхүүнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн газар, хэлтэсүүдийг байгуулах;

- Шинжлэх ухаанд суурилсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэхийн тулд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн яам болон Шинжлэх ухааны академийн давхар харьяалалд эдийн засгийн тулгуур судалгааны хүрээлэнг байгуулах;

*5. Хөгжлийн баримт бичгийн үндсэн агуулга, арга хэлбэр, үе шатны тухайд:*

• Уг хуулинд хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний үндсэн агуулгыг тодорхой болгох;

• Хуульд хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах арга хэлбэр, үе шатыг системчлэн тогтоох;

• Монгол Улсын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар төр засгийн бүх шатны холбогдох байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны чиглэлийг зааглаж тодорхой өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай.

*6. Хөгжлийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тухайд:*

• Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргах, хяналт шинжилгээ, үнэлэлт дүгнэлт хийх асуудлыг цогцоор нь тусгах;

• Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулах нэгдсэн арга зүйг оруулах;

• Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд хөгжлийн зорилго, зорилтууд, алсын харааг оновчтой бөгөөд бодитой тодорхойлох, тэдгээрийг ирээдүйд хүрэх түвшний төсөөлөлтэй нягт уялдуулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтөнд баримтлах үндсэн зарчмуудыг тусгах.

Дүгнэж хэлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд 12 нэр төрлийн, хөгжлийн хэт олон баримт бичгүүд, хөтөлбөрүүдийг боловсруулж байхаар тусгасан байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт нь хэтэрхий ерөнхий бөгөөд тунхаглалын чанартай, түүний хөтөлбөр, төлөвлөгөөний агуулга, тэдгээрийг боловсруулах арга аргачлал, үе шат нь тодорхой бус, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь оновчгүй байна. Засгийн газрын болон орон нутгийн захиргааны байгууллага тус тусдаа олон хөтөлбөр боловсруулж батлуулах гэж ихээхэн цаг хугацаа зарцуулж байна.

Иймд дээрх хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа холбоог хангах, зарим нэр томьёог оновчтой болгох, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн оновчтой тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэхэд ихээхэн төвөгтэй зарим бие даасан хөтөлбөрүүдийг нэгтгэн цэгцлэж, зармыг нь хасах нь шаардлагатай гэж үзэж байна.

# БҮЛЭГ 3. ДТХЗ БОЛОН МУТХҮБ-2030-ЫН СУУРЬ ТҮВШИНГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

## 3.1. ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын суурь түвшингийн харьцуулалт

2015 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий ассамблейн дээд чуулганаар ДТХЗ-ыг нийт 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлттэй баталсны дагуу Монгол Улсын Их Хурал, МУТХҮБ-2030-ыг 44 зорилт, 20 шалгуур үзүүлэлттэй баталсан билээ. МУТХҮБ-2030-ын 44 зорилтын ДТХЗ-тай нийцэж байгаа байдлыг хавсралт 3-аас харна уу. Үүнд, 21 зорилт нийцсэн, 9 зорилт хүрэх түвшингийн хувьд зөрүүтэй (5 зорилтын хүрэх түвшин дэлхийгээс доогуур, 1 зорилт дээгүүр), 8 зорилт ялгаатай байдлаар тодорхойлогдсон, нийцээгүй зорилт 1, түвшин тодорхойлогдоогүй зорилт 3, МУТХҮБ-д түвшин тодорхой, гэхдээ ДТХЗ-д тодорхойлогдоогүй зорилт 2 байна. МУТХҮБ-2030-ын зорилтууд ДТХЗ-ын 13 зорилго 43 зорилтын хүрээнд тусгалаа олсон байна. Үүнд:

- Зорилго 1: Ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгох;
- Зорилго 3: Бүх түвшинд эрүүл амьдралыг хангаж, сайн сайхан аж байдлыг хөхүүлэн дэмжих;
- Зорилго 4: Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжин хөхүүлэх;
- Зорилго 6: Хүн бүрд ус, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй хүргэж, тэдгээрийн тогтвортой менежментийг хангах;
- Зорилго 8: Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих;
- Зорилго 9: Уян хатан дэд бүтцийг байгуулж, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилтийг дэмжиж, инновацийг хөгжүүлэх;
- Зорилго 10: Улс орнууд хоорондын тэгш бус байдлыг бууруулах;
- Зорилго 13: Цаг уурын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх талаар яаралтай арга хэмжээ авах;
- Зорилго 15: Дэлхийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, түүний тогтвортой хэрэглээг дэмжих, ойг тогтвортой ашиглах, цөлжилттэй тэмцэх, хөрсний доройтлыг зогсоох, сэргээх, биологийн олон янз байдал алдагдаж буйг зогсоох;
- Зорилго 17: Тогтвортой хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг сэргээж, түүнийг хэрэгжүүлэх арга замыг сайжруулах гэх мэт.

Дээрх харьцуулсан судалгаанаас дүгнэлт хийхэд:

ДТХЗ 2: Өлсгөлөнг зогсоож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хөхүүлэн дэмжих - Зорилго 3-ын хүрээнд нэг зорилт нийцэж байна.

ДТХЗ 5: Жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг

нэмэгдүүлэх зорилго зарчмын хувьд орсон боловч тодорхой зорилтууд байхгүй.

ДТХЗ 12: Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтцийг бүрдүүлэх - МУТХҮБ-2030-д тодорхой байдлаар ороогүй байна (зөвхөн эрдэс баялгийн хүрээнд хариуцлагатай тогтвортой уул уурхай гэж орсон), хүнс, үйлдвэрийн хог хаягдал гэх зэрэг ороогүй байна.

## 3.2. МУТХҮБ-2030-ын суурь түвшингийн талаар

МУТХҮБ-2030-ын хэрэгжилтийн явцыг дараах 20 үндсэн үзүүлэлтээр 2014 оны суурь түвшинг авч, 2030 онд хүрэх түвшинг доорх байдлаар тодорхойлсон.

**Хүснэгт 4. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үнэлэх үндсэн 20 үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь түвшин болон 2030 онд хүрэх түвшингийн харьцуулалт**

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин (2014 он) | Зорилтот түвшин (2030 он) |
|---|---|---|---|---|
| 1 | Эдийн засгийн жилийн дундаж өсөлт | хувь | 7.8 | 6.6 |
| 2 | Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого | ам. доллар | 4166 | 17500 |
| 3 | Хүний хөгжлийн үзүүлэлт | эзлэх байр | 90 | 70 |
| 4 | Дундаж наслалт | жил | 69.57 | 78 |
| 5 | Ядуурлын түвшин | хувь | 21.6 | 0.0 |
| 6 | Өрсөлдөх чадварын үзүүлэлт | эзлэх байр | 104 | 70 |
| 7 | Бизнес эрхлэлтийн үзүүлэлт | эзлэх байр | 56 | 40 |
| 8 | Байгаль орчны багц үзүүлэлт | эзлэх байр | 111 | 90 |
| 9 | Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал | хувь | 84.4 | 99 |
| 10 | Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт | оноо | 36.5 | 30.0 |
| 11 | 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин | промиль | 15.1 | 8 |
| 12 | 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин | продецимиль | 30.6 | 15 |
| 13 | Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж) | хүүхдийн тоо | 27.3 | 20 |
| 14 | Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ | хувь | 0 | 60 |
| 15 | Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ | хувь | 78.2 | 68 |
| 16 | Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ | хувь | 17.4 | 30 |
| 17 | Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо | сая хүн | 0.392 | 2.0 |
| 18 | Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх | хувь | 89 | 100 |
| 19 | Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ | хувь | 17 | 50 |
| 20 | Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь | хувь | 0 | 100 |

*Эх сурвалж: "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030".*

1. МУТХҮБ-2030-ыг үнэлэх үндсэн 20 үзүүлэлтийн хувьд зөвхөн суурь 2014 оны болон 2030 оны түвшинг тодорхойлоод завсрын 2020 болон 2025 онд хүрэх түвшинг тодорхойлж өгөөгүй байна. Гэтэл МУТХҮБ-2030-д текстээр оруулсан үзүүлэлтийн ихэнхэд нь 2020, 2025 болон 2030 онд хүрэх түвшинг тодорхойлсон байв.

2. МУТХҮБ-2030-д эдийн засгийн өсөлтийн суурь түвшинг зөвхөн ганцхан 2014 оны түвшингээр 7,8 хувь хэмээн авсан нь арга зүйн хувьд ихээхэн учир дутагдалтай байна. Албан ёсны статистикийн мэдээгээр 2014 онд ДНБ-ий хэмжээ өмнөх 2013 оныхоос 2010 оны зэрэгцүүлэх үнээр 7,8 хувиар өссөн нь үнэн боловч эдийн засгийн урт хугацааны өсөлтийг жилийн дундаж өсөлтөөр тооцож байгаа тул суурь түвшинг өмнөх онуудын дундаж өсөлтийг харгалзан тооцох нь арга зүйн хувьд зайлшгүй юм. Бидний тооцоогоор Монгол Улсын ДНБ-ий 2000-2016 оны ДНБ-ий жилийн дундаж өсөлт 2010 оны зэрэгцүүлэх үнээр 7 хувьтай байжээ. Гэтэл, 2014-2030 оны хоорондох 16 жилийн дундаж өсөлтийг 6,6 хувиар буюу өмнөх 2000-2016 оны жилийн дунджаас 0,4 пунктээр дутуу тооцсон байна. Энэ нь Монгол Улсын ирээдүйн 16 жилийн эдийн засгийн өсөлтийг өмнөх 16 жилийнхээс удааширна гэж үзсэн төсөөлөлд тулгуурласан байна. Энд урагшаа харсан эрчимтэй өсөлт биш, харин ч ухралт болсон зорилтыг дэвшүүлсэн байна. Дээрх зорилт нь МУТХҮБ-2030-ын бусад тооцоо, судалгаанд зарим талаар эргэлзээ төрөх үндэс болж байна.

3. Эдийн засгийн жилийн дундаж өсөлтийн хувь болон нэг хүн амд ногдох үндэсний нийт орлогын хэмжээ хоорондоо ямар ч уялдаагүй тооцогдсон байна. МУТХҮБ-2030-д 2016-2030 оны хооронд эдийн засгийн жилийн дундаж өсөлт 6,6 хувь байхаар тусгасан бөгөөд үүгээр тооцоход 2030 онд ДНБ-ий хэмжээ 2010 оны үнээр 36,7 их наяд төгрөгт хүрч, 2017 оныхоос 2,3 дахин нэмэгдэх төлөвтэй байна. Хүн амын тоо 2030 онд ҮСХ-ны хэтийн тооцооны дундаж хувилбараар 3 сая 862 мянга болохоор байгаа бөгөөд энэ нь 2017 оныхоос 25 хувиар нэмэгдэх хэмжээ юм. Гэтэл МУТХҮБ-2030-д нэг хүн амд ногдох үндэсний орлогын хэмжээг 2030 онд 17500 ам.долларт хүргэхээр тусгасан нь 2014 онд 4166 ам. доллар байснаас 4,2 дахин өндөр түвшин юм. Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг "World Development Indicators" (2016, 2017) эмхтгэлүүдээс харахад Монгол Улсын нэг хүн амд ногдох үндэсний нийт орлогын хэмжээ 2014 онд 4280 ам.доллар, харин 2015 онд 3870 ам.доллар болж буурсан байгааг дурдах хэрэгтэй. Эдийн засгийн цар хүрээ 2030 онд 2017 оныхоос 2,3 дахин өсч, хүн амын тоо 25 хувиар нэмэгдэж байхад нэг хүн амд ногдох үндэсний нийт орлого 2030 он гэхэд 4,2 дахин өсөх боломжгүй гэдэг нь тодорхой харагдаж байна. Дээр нь манай орны хувьд үндэсний нийт орлогын хэмжээ ДНБ-ээс доогуур гардаг онцлогтойг харгалзаагүй байна. Цаашдаа ч “Оюу Толгой” болон бусад томоохон төслүүд үргэлжлэх нөхцөлд энэ зөрүү улам нэмэгдэх магадлал өндөр юм.

Суурь түвшний зарим үзүүлэлтүүд зөрүүтэй байна. Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд (2016, 2017) эмхтгэлүүдээс харахад Монгол Улсын нэг хүн амд ногдох үндэсний нийт орлого 2014 онд 4280 ам.доллар байхад 4166 ам.доллар гэж авсан байна. Дээрх хүснэгтэнд нийт экспортод боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувийг 2014 онд 17 хувь гэж тусгасан хэрнээ аж үйлдвэрийн салбарын Зорилт 1-д I үе шатанд (2016-2020) 2020 он гэхэд 15 хувь болгон 2014 оныхоос бууруулахаар тусгасан байна.

МУТХҮБ-2030-д үндсэн 20 үзүүлэлтээс гадна 52 үзүүлэлтийн тодорхой хүрэх түвшинг харуулсан Хавсралт 1-ээс үзэхэд үзүүлэлтүүдийн түвшинг тодорхойлсон байдал янз бүр байна. Эдгээр 52 үзүүлэлтийн 38 үзүүлэлтэд хүрэх түвшинг 3 оноор тухайлбал, 2020, 2025 болон 2030 оноор харуулсан байна. Чинээлэг болон дундаж давхаргын нийт

хүн амд эзлэх хувь, суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшин, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийд эзлэх байр гэсэн 3 үзүүлэлтээр зөвхөн 2030 онд хүрэх түвшинг тодорхойлж, 2020 болон 2025 онд хүрэх түвшинг зааж өгөөгүй байна. Зөвхөн 2020 болон 2025 оны түвшинг тодорхойлоод харин 2030 онд хүрэх түвшинг тогтоож өгөөгүй үзүүлэлт 4 байна. 2020 онд хүрэх түвшинг тодорхойлоогүй харин 2025 болон 2030 онд хүрэх түвшинг тогтоосон үзүүлэлт 4 байна. Зөвхөн 2020 оны түвшинг тодорхойлсон үзүүлэлт 2 байна. Нэг үзүүлэлтийн хувьд 2025 оны түвшинг төлөвлөөгүй хэрнээ 2020 болон 2030 онд хүрэх түвшинг тогтоож өгсөн байв.

Дүгнэж хэлэхэд МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтийн хувьд 2030 оны хүрэх түвшинг үндэслэлтэй тодорхойлж чадаагүй байна. Зарим үзүүлэлтийн хүрэх түвшинг 2030 он хүртэл тодорхойлоод дунд хугацаанд буюу 2020 болон 2025 онд хүрэх түвшинг зааж өгөөгүй байна. Тухайлбал, эдийн засгийн өсөлтийн суурь түвшинг 2014 оны түвшингээр 7,8 хувиар тооцсон нь арга зүйн хувьд үндэслэл багатай бөгөөд энэхүү өсөлтийг хангах үүрэг бүхий бусад дагалдах үзүүлэлтүүдийг тооцоогүй учир уг зорилтод хүрэхэд эргэлзээтэй юм. Түүнчлэн, 2030 он гэхэд хүн амын тоо дөнгөж 25 хувиар нэмэгдэхээр байхад ДНБ-ий үйлдвэрлэлийн хэмжээг 2017 оныхоос 2,3 дахин өсгөхөөр тогтоосон нь энэ хоёр үзүүлэлтийг хооронд нь уялдаагүй тооцсон болохыг нотолж байна. Түүнчлэн, 2030 он гэхэд 1 хүнд ногдох Үндэсний нийт орлого (ҮНО)-ын хэмжээг 4,2 дахин өсгөх боломжгүй болох нь тодорхой байна. Одоогийн байдлаар “Оюу Толгой”, “Таван толгой” болон бүтээн байгуулалтын бусад томоохон мега төслүүдийн хэрэгжилтээс орж ирэх орлого болон эдийн засгийн хөгжилд үзүүлэх эерэг бодитой нөлөө тодорхойгүй байгаа нөхцөлд бусад зорилтуудад хүрэх магадлал бага юм.

### 3.3. МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтийн түвшинг завсрын онуудаар тодорхойлсон байдал

МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтийн зөвхөн суурь 2014 он болон 2030 онд хүрэх түвшинг тодорхойлсныг бид дээр дурдсан. Эдгээр 20 үзүүлэлтийн 2020, 2022 болон 2025 онд хүрэх түвшинг доорх байдлаар төсөөлж, цаашид дунд хугацааны төлөвлөлтөд тусгахыг санал болгож байна. Үүний тулд доорх зарчмуудыг баримтлав. Үүнд:

1. 2030 онд хүрэх түвшинг МУТХҮБ-2030-д тусгасан хэмжээгээр нь авсан.
2. Суурь 2014 оны түвшинд зарим тодотгол хийж, албан ёсны тоо мэдээллээр өөрчлөлт оруулсан.
3. 2020 болон 2025 онуудын түвшинг төсөөлөхдөө МУТХҮБ-2030-д тодорхой заасан түвшинг шууд авсан. Харин 2020, 2022 болон 2025 онуудын түвшинг тодорхойлоогүй үзүүлэлтүүдийн хувьд дундах онуудын тоог харгалзан 2030 онд хүрсэн байх түвшинг заавал хангахуйц хэмжээгээр тооцож тогтоосон.

**Хүснэгт 5. МУТХҮБ-2030-ын үндсэн 20 үзүүлэлтүүдийн хүрэх түвшний төсөөлөл**

| № | МУТХҮБ-2030-ын үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2014 | 2020 | 2022 | 2025 | 2030 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эдийн засгийн жилийн дундаж өсөлт | хувь | 7.8 | 6.6 | | | 6.6 |
| 2 | Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого | доллар | 4280 | 7000 | 9000 | 12000 | 17500 |
| 3 | Хүний хөгжлийн үзүүлэлт | байр | 90 | 85 | 83 | 85 | 70 |
| 4 | Дундаж наслалт | жил | 69.57 | 71а | 72 | 74а | 78 |
| 5 | Ядуурлын түвшин | хувь | 21.6 | 18а | 15 | 9 | 0 |
| 6 | Өрсөлдөх чадварын үзүүлэлт | байр | 104 | 97 | 93 | 80 | 70 |
| 7 | Бизнес эрхлэлтийн үзүүлэлт | байр | 56 | 50 | 48 | 45 | 40 |
| 8 | Байгаль орчны багц үзүүлэлт | байр | 111 | 105 | 103 | 98 | 90 |
| 9 | Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал | хувь | 84.4 | 88 | 91 | 94 | 99 |
| 10 | Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт | оноо | 36.5 | 34 | 33 | 32 | 30 |
| 11 | 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин | промиль | 15,1 | 13а | 12 | 11а | 8 |
| 12 | 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин | продецемиль | 30.6 | 25а | 23 | 20а | 15 |
| 13 | Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж) | тоо | 27.3 | 25 | 24 | 22 | 20 |
| 14 | Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорио, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ | хувь | 0 | 10а | 25 | 30а | 60 |
| 15 | Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ | хувь | 78.2 | 76 | 74 | 72 | 68 |
| 16 | Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ | хувь | 17.4 | 25а | 22 | 27а | 30 |
| 17 | Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо | сая хүн | 0.392 | 1.0а | 1.2 | 1.5а | 2 |
| 18 | Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх | хувь | 89 | 93 | 95 | 97 | 100 |
| 19 | Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ | хувь | 17 | 20а | 23 | 25а | 50 |
| 20 | Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь | хувь | 0 | 20а | 50 | 70а | 100 |

*Тайлбар: Ардаа жижиг -“а” үсэгтэй түвшингүүд нь тухайн онд хүрэх түвшинг МУТХҮЗ-2030-д тогтоож өгсөн хэмжээ болно. Ийм тэмдэглэгээгүй түвшингүүдийг бид тооцож төсөвлөсөн болно.*

# БҮЛЭГ 4. ҮНДЭСНИЙ ТҮВШНИЙ БОЛОН САЛБАРУУДЫН ХӨГЖЛИЙН УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАРИМ БАРИМТ БИЧИГ ӨӨР ХООРОНДОО БОЛОН ДТХЗ БОЛОН МУТХҮБ-2030-ЫН ЗОРИЛТУУДТАЙ НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХЭД ХИЙСЭН СУДАЛГАА

## 4.1. МУТХҮБ-2030 нь ДТХЗ-тай нийцсэн эсэхэд хийсэн шинжилгээ

Төслийн хүрээнд МУТХҮБ-2030 болон ДТХЗ хэрхэн нийцэж байгаа байдлыг ДТХЗ-ын нийт 169 зорилттой тулган шалгаж, эдгээр зорилт нь шууд тусгагдсан, агуулгын хувьд уялдсан, огт тусгагдаагүй, манай оронд хамаарахгүй гэсэн 4 ангиллаар нэг бүрчлэн ялган тогтоосныг Хавсралт 4-өөс харна уу. Энд 1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй, 4-манай оронд хамаарахгүй гэж ангилсан.

**Хүснэгт 6. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн байдал**

| Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд | | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын зорилтууд | | | |
|---|---|---|---|---|---|
| Зорилгууд | Зорилтуудын тоо | Шууд тусгагдсан | Агуулгын хувьд уялдсан | Огт тусгагдаагүй | Манай оронд хамааралгүй |
| Зорилго 1 | 7 | 2 | 2 | 3 | 0 |
| Зорилго 2 | 8 | 0 | 5 | 3 | 0 |
| Зорилго 3 | 13 | 4 | 4 | 5 | 0 |
| Зорилго 4 | 10 | 3 | 2 | 5 | 0 |
| Зорилго 5 | 9 | 0 | 0 | 9 | 0 |
| Зорилго 6 | 8 | 3 | 1 | 4 | 0 |
| Зорилго 7 | 5 | 2 | 2 | 1 | 0 |
| Зорилго 8 | 12 | 4 | 1 | 7 | 0 |
| Зорилго 9 | 8 | 3 | 1 | 4 | 0 |
| Зорилго 10 | 10 | 1 | 4 | 5 | 0 |
| Зорилго 11 | 10 | 3 | 5 | 2 | 0 |
| Зорилго 12 | 11 | 1 | 5 | 4 | 1 |
| Зорилго 13 | 5 | 3 | 0 | 2 | 0 |
| Зорилго 14 | 10 | 0 | 0 | 0 | 10 |
| Зорилго 15 | 12 | 2 | 1 | 9 | 0 |
| Зорилго 16 | 12 | 1 | 2 | 8 | 1 |
| Зорилго 17 | 19 | 4 | 6 | 5 | 4 |
| Бүгд | 169 | 36 | 41 | 76 | 16 |
| Дүнд эзлэх хувь | 100 | 21.3 | 24.3 | 45.0 | 9.5 |

*Эх сурвалж: Судалгааны баг*

Хүснэгт 6-аас харахад ДТХЗ-ын нийт 169 зорилтын 21,3 хувь буюу 36 зорилт МУТХҮБ-2030-д шууд тусгагдсан бол 45 хувь буюу 76 зорилтыг огт тусгаагүй байна. Харин нийт зорилтуудын 24,3 хувьтай тэнцэх 41 зорилт МУТХҮБ-2030-д агуулгын хувьд уялдсан гэж үзлээ. Харин "Далай тэнгисийн нөөцийг хамгаалах, нөөцийг тогтвортой хөгжилд зүй зохистой ашиглах" гэх мэт 16 зорилт буюу 9,5 хувь нь манай оронд огт хамааралгүй байна.

Иймд ДТХЗ-ыг МУТХҮБ-2030-д хангалттай сайн тусгаж өгөөгүй гэж үзэхэд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, ДТХЗ-ын нийт 169 зорилтын 3/4 нь МУТХҮБ-2030-д огт тусгагдаагүй үлдсэн байгаа юм. Ялангуяа жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх Зорилго 5-д тусгагдсан 9 заалт МУТХҮБ-2030-д огт тусгагдаагүй байгаа нь анхаарах асуудал мөн. Түүнчлэн хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах Зорилго 8-ын нийт 12 зорилтын 7 нь буюу 58 хувь нь, экологийн системийг хамгаалах талаарх Зорилго 15-ын нийт 12 зорилтын 9 буюу 3/4 нь, хууль дээдэлсэн тогтвортой хөгжил бүхий нийгмийг бүрдүүлж, үр нөлөөтэй институцийг бүх шатанд бий болгох Зорилго 16-ын нийт 12 зорилтын 8 буюу 2/3 нь огт тусгагдаагүй байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд МУТХҮБ-2030-ыг боловсруулсан ажлын хэсэг хөгжлийн үзэл баримтлалын төслөө эрдэмтэд мэргэд болон олон нийтээр ил тод хэлэлцүүлээгүй, тэдний саналыг тусгаагүй, ялангуяа энэ чиглэлээр судалгаа хийдэг их дээд сургууль, эрдэм шинжилгээний болон олон улсын байгууллагуудын санал, зөвлөмжийг хангалттай аваагүй, зорилтуудын хүрэх түвшинг тодорхойлохдоо үндэсний эдийн засгийн чадавх, багтаамж, онцлогийг тооцоогүй, бодитой тооцоо судалгаа дээр үндэслээгүй, төслийн боловсруулах үеийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн нөхцөл, байдал, гадаад орчинд үнэлгээ өгөөгүй хөнгөн хийсвэр боловсруулж, маш түргэн батлуулсан байна. Дээр дурьдсанчлан жендэрийн тэгш байдлыг хангах, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зэрэг жендэрийн асуудлыг огт хөндөөгүйгээрээ ихээхэн учир дутагдалтай баримт бичиг болжээ.

Манай орны хувьд хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах, экологийн системийг хамгаалах, хууль ёст тогтвортой хөгжлийн нийгмийг бүрдүүлж, үр нөлөөтэй институцийг бүх шатанд бий болгох зэрэг зорилтууд МУТХҮБ-2030-д хангалттай тусгагдаагүй үлджээ.

Иймд ДТХЗ-аас МУТХҮБ-2030-д тусгаагүй зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг манай орны дунд хугацааны бодлого, төлөвлөлтөд тусгаж өгөх шаардлагатай гэж үзэж байна.

# НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Өнгөрсөн 27 жилд Монгол Улсын төр, засгаас эдийн засаг, нийгэм, улс төрийн зэрэг бүх салбарт хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаанд шинжилгээ хийж үзэхэд барууны өндөр хөгжилтэй зарим орон, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагын санал, зөвлөгөөг үг дуугүй хүлээн авсан, улс орны хөгжлийн өвөрмөц онцлогт нийцээгүй, үндэсний язгуур эрх ашигтай харшилсан неолиберал бодлогыг хэрэгжүүлж байна. Үүний улмаас Монгол Улсын үндэсний аж үйлдвэрийн салбарын үлэмж хэсэг нь өнгөрсөн хугацаанд устаж үгүй болсон, ажилгүйдэл, ядуурал, өр, зээлд баригдсан, гадны зээл тусламжийн байгууллагуудын амыг харсан орон болж хувирчээ.

Тэгвэл төрийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь өөрийн орны эдийн засгийн хүчин чадал, багтаамж, газар зүйн байршил, байгаль цаг агаарын нөхцөл, ард түмний ахуй, амьдрал, сэтгэлгээ, түүх, соёл, уламжлал, зан заншил зэрэг өвөрмөц онцлогуудыг сайтар тооцсон байхын зэрэгцээ түүнийг ард түмнийхээ язгуур эрх ашигт нийцүүлэн, гэхийн ухаанаар бодитой хандаж хэрэгжүүлснээр өндөр хөгжилд хүрч чадсан Зүүн Азийн зарим орны туршлага бидэнд баталж байна.

Бидний хийсэн судалгаагаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн онцлогт тохироогүй, үндэсний эрх ашигт нийцээгүй, шинжлэх ухааны тооцоо, судалгаан дээр үндэслээгүй, залгамж чанаргүй, хоорондын уялдаагүй, амьдралаас тасархай, хэрэгжих үндэслэл багатай байна гэсэн дүгнэлт гарч байна. Үүний шалтгаан нь сонгуульд ялсан намын эмхлэн байгуулсан Засгийн газар нь улс орны урт дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй мөрийн хөтөлбөрөө уялдуулан боловсруулдаггүй, эсвэл тэдгээрийг өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн өөрчилж ирсэнд оршиж байна. Улс төрийн сонгууль бүрийн дараа хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын статус, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг өөрчлөгдөх бүрт түүний тогтвортой үйл ажиллагаа алдагдаж, чиг үүргүүд нь хоёрдмол болох тохиолдол гарч байжээ.

Энэ байдлыг засаж залруулахын тулд улс орны хөгжлийн урт болон дунд хугацааны тогтвортой, үр ашигтай, үр нөлөөтэй, оновчтой бодлого, төлөвлөлтийг сайжруулахын тулд тэдгээрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын статус, эрх мэдэл, чиг үүргийг тодорхой болгож, түүний дэргэд “Think tank” бодлогын судалгааны хүрээлэнг (институц) байгуулах хэрэгтэй байна. Энэхүү хүрээлэн нь Монгол Улсын төрийн хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанарт үнэлгээ, дүгнэлт өгөх, санал, зөвлөмж боловсруулах, улс төрийн намуудаас эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар явуулж ирсэн бодлого, зохицуулалтад шинжилгээ хийж, тэдгээр нь үндэсний язгуур эрх ашигт хэрхэн нийцэж байсан талаар дүгнэлт гаргаж, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтэд хяналт, үнэлгээ, шинжилгээ хийдэг байна.

Түүнчлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын боловсруулж батлуулсан улс орны урт хугацааны хөгжлийн бодлогыг улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөрт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгах үүрэг хүлээдэг болгох тогтолцоог бий болгох шаардлагатай юм.

Үүний тулд Монгол Улсын хөгжлийн бодлогын онол, арга зүйн үзэл баримтлалыг шинээр томьёолох, олон улсын зарим байгууллага, тухайлбал, ДХБ-тай байгуулсан гэрээ хэлэлцээрийг шинэчлэх, ОХУ, БНХАУ гэсэн хөрш орнуудтай худалдааны салбарт байгуулсан хоёр талт хэлэлцээрүүдийг шинэчлэх, тэгш эрхтэй худалдааг

зохион байгуулах, үндэсний боловсруулах аж үйлдвэрээ сэргээн хөгжүүлэх, тодорхой салбарт төрийн зохицуулалт, харин харьцангуй тэнцвэрт харьцаа тогтсон салбарт дотооддоо чөлөөт эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Харин өндөр хөгжилтэй орнуудын жишгээр гадаадад протекционист[10] бодлого хэрэгжүүлэх, төрөөс өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй эх орны үйлдвэрүүдэд өмчийн хэлбэр харгалзахгүй дэмжлэг, туслалцаа үзүүлэх, татварын болон зээлийн хөнгөлөлт үзүүлэх замаар экспортыг урамшуулах, импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

10 Импортын бараа бүтээгдэхүүн, түүний тоо хэмжээнд тариф тогтоох зэргээр импортод хязгаарлалт хийх эдийн засгийн бодлого.

## НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Засгийн газрын тухай хууль.
3. Төсвийн тухай хууль.
4. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол.
5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, 2015.
6. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, УИХ-ын 1996 оны 26 дугаар тогтоол.
7. Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 1998 оны 82 дугаар тогтоол.
8. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол.
9. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харьцуулсан судалгаа, МУИС, Эдийн засгийн судалгааны төв, 2014.
10. Хулдорж.Б, "Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр: Ахиц, дэвшил, бэрхшээл, хэтийн зорилго", НҮБХХ, 2012.
11. Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилгууд, НҮБ.
12. Батболд.Т, Ариунаа.Д, Баярмаа.Б, Батцэцэг.С, Зол-Эрдэнэ.Д, "Судалгааны арга зүй", 2017.
13. Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд асан Такенори Шимизүгийн ярилцлага, Өдрийн сонин, 2015 оны 9 сарын 17, Дугаар 226.
14. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх институцийн тогтолцооны өнөөгийн байдлын үнэлгээ, цаашид боловсронгуй болгох талаар баримтлах чиглэл судалгааны тайлан.
15. Монгол Улсын 1992 онд хийсэн Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, НҮБХХ, УИХ, 2016.
16. Joseph E.Stiglitz, "Globalization and it's discontents", 2003.
17. Keith Griffin, "Poverty reduction in Mongolia", Asia Pacific Press, 2003.
18. Чан Ха Жүн, "Чөлөөт худалдааны домог ба капитализмын нууц товчоо", 2014.
19. Ли Куан Ю, "Сингапурын хөгжлийн нууц, Гуравдагч ертөнцийн орон үсрэнгүй хөгжилд хүрсэн түүх: 1965-2000".
20. Frank Fischer, Gerald J.Miller, Mara S, Sidney, "Handbook of Public Policy Analysis: Theory, Politics and Methods", 2007.
21. EU-funded Urban Transport Research Project Result, Policy formulation and Implementation, 2003.
22. "Mongolia's Sustainable Development Agenda: progresses, bottlenecks and vision for the future", UNDP, GoM, 2012.

23. Thomas A.Birkland, “An introduction to the policy process: theories, concepts, and models of public policy making”, 2016.
24. Maria J. Grant and Andrew Booth, “A typology of reviews: an analysis of 14 review types and associated methodologies”, Salford Centre for Nursing, Midwifery and Collaborative Research (SCNMCR), University of Salford, UK, School of Health and Related Research (ScHARR), University of Sheffield, UK, 2009.
25. Nguyen Le Thuy, “Mainstreaming sustainable development at national level: Vietnam experiences, opportunities and challenges”, 2015.
26. Angela Harden, “Mixed-Methods Systematic Reviews: Integrating Quantitative and Qualitative Findings”, 2010.

# ХАВСРАЛТ

**Хавсралт 1. МУТХҮБ-2030-д орсон 52 үзүүлэлтийн хүрэх түвшингүүд**

| № | МУТХҮБ-2030-ын үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2020 | 2025 | 2030 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Чинээлэг болон дундаж давхаргын нийт хүн амд эзлэх хувь | хувь | | | 80 |
| 2 | Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшин | хувь | | | 100 |
| 3 | Ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийд эзлэх байр | эзлэх байр | | | 30 |
| 4 | Төсвийн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь | хувь | 15 | 10 | |
| 5 | ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь | хувь | 35 | | 30 |
| 6 | Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувь | хувь | | 5 | 8 |
| 7 | Эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоо | мянга | | 150.0 | 200.0 |
| 8 | Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажил | хувь | 70 | 85 | 90 |
| 9 | Усалгаатай тариалангийн талбай | мянган га | 65.0 | 100.0 | 120.0 |
| 10 | Жилд шаардагдах бордооны хангамж | хувь | 50 | 70 | 100 |
| 11 | Нутагшсан сортын элит үрийн хангамж | хувь | 75 | 90 | 100 |
| 12 | Малчдын өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах хувь | хувь | 50 | 75 | |
| 13 | Арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин | хувь | 60 | 70 | 80 |
| 14 | Хүн амд нийлүүлсэн махны дотор үйлдвэрийн аргаар боловсруулсан махны эзлэх хувь | хувь | 30 | 50 | 70 |
| 15 | Хүн амд нийлүүлсэн сүүний дотор үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь | хувь | 40 | 60 | 80 |
| 16 | Ашиглалтанд оруулах хар төмөрлөгийн үйлдвэрийн хүчин чадал | мянган тонн | ган бөмбөлөг: 100.0 | ган туйван: 100.0 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17 | Геологийн 1:200000 масштабын зураглалын нутаг дэвсгэрийн хамралтын хувь | хувь | 100 | | |
| 18 | Сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын нутаг дэвсгэрийн хамралтын хувь | хувь | 40 | 45 | 50 |
| 19 | Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр хангах хувь | хувь | 85 | 90 | 100 |
| 20 | Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь | хувь | 20 | 25 | 30 |
| 21 | Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг нэмэгдүүлэх хэмжээ | км | 1600 | 800 | 470 |
| 22 | Барилгын дулааны алдагдлыг бууруулах хувь | хувь | 20 | 25 | 40 |
| 23 | Өндөр хурдны интернетийн сүлжээнд хамрагдсан хүн амын эзлэх хувь | хувь | 70 | 90 | 95 |
| 24 | Улсын төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь | хувь | 2 | 0 | 0 |
| 25 | Санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувь | хувь | 10 | 12 | 16 |
| 26 | Санхүүгийн зах зээлд арилжааны банкны эзлэх хувь | хувь | 90 | 86 | 82 |
| 27 | Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь | хувь | 58.6 | 50 | 40 |
| 28 | Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг бууруулах хэмжээ | хоног | 25 | 18 | 10 |
| 29 | Хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхийн түвшин | хувь | 66 | 68 | 70 |
| 30 | Ажилгүйдлийн түвшин | хувь | 6 | 4 | 3 |
| 31 | Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн хэмжээ | тэрбум төгрөг | 100 | 200 | 300 |
| 32 | 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин | промиль | 15 | 12 | 9 |
| 33 | 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт | продецемиль | 17.4 | 16 | 14 |
| 34 | 10000 хүн амд ногдох хорт хавдраас шалтгаалсан нас баралт | продецемиль | 10.5 | 9 | 8 |
| 35 | Товлолт дархлаажуулалтын хамралт | хувь | 98.5 | 99 | 99.8 |
| 36 | 10000 хүн амд вирусt гепатитын өвчлөлт | продецемиль | 3 | 2.5 | 2 |
| 37 | 10000 хүн амд сүрьеэгийн тохиолдол | продецемиль | 14.4 | 14 | 13 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 38 | Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн хамралт | хувь | 70 | 80 | 90 |
| 39 | Сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоо | Хүүхдийн тоо | | 25 | 20 |
| 40 | Хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог бууруулах хувь | хувь | | 30 | 50 |
| 41 | Анги дүүргэлтийн улсын дундаж | Хүүхдийн тоо | | 25 | 20 |
| 42 | Мэргэжлийн боловсрол, сургалтын сурагчдын тоо | мянга | 60 | | |
| 43 | Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь | хувь | 2 | 2.5 | 3 |
| 44 | Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн тусгай хамгаалалтад авах хувь | хувь | 50 | 55 | 60 |
| 45 | Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх газар нутгийн эзлэх хувь | хувь | 15 | 23 | 30 |
| 46 | Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь | хувь | 80 | 85 | 90 |
| 47 | Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь | хувь | 40 | 50 | 60 |
| 48 | Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хувь | хувь | 2 | 7 | 14 |
| 49 | Байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэх хэмжээ | дахин | 2 | 5 | 10 |
| 50 | Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь | хувь | 8.5 | 8.7 | 9 |
| 51 | Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувь | хувь | 15 | 25 | 30 |
| 52 | Нийт хог хаягдалд дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь | хувь | 20 | 30 | 40 |

**Хавсралт 2. Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал**

| Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр |
|---|---|
| **Тэргүүлэх чиглэл 1.** Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах; | Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцлийг бүрдүүлнэ. |
| 1.1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах; | 2.101. Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурь салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/<br>2.103. Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ. |
| 1.1.1. Анхдагч эрчим хүч, түлшний хангамжийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх; | |
| 1.1.2. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгох; | |
| 1.1.3. Эрчим хүчний нэгдсэн системийн цахилгааны ачааллын хэлбэлзлийг тохируулж, хэвийн найдвартай ажиллагааг хангах тохируулгын эх үүсвэрийг бий болгох; | |
| 1.1.4. Хот, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах, дулаан хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх; | |
| 1.1.5. Бүс нутгийн эрчим хүчний системийг дамжуулах чадал өндөр цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах; | |
| 1.1.6. Цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, хэрэглэгчид хүргэх эрчим хүчний чанарыг сайжруулах. | |
| 1.2. Бүс нутгийн орнуудтай эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх; | |
| 1.2.1. Хөрш орнуудтай эрчим хүч импортлох, экспортлох урт хугацааны харилцан ашигтай гэрээ байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх; | |
| 1.2.2. Олон улсын байгууллага, бүс нутгийн орнуудын эрчим хүчний хамтын ажиллагааны санал санаачилгад идэвхтэй оролцох, хамтран ажиллах; | |

| | |
|---|---|
| 1.2.3. Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбороос Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах; | |
| 1.2.4. Эрчим хүчний чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах. | |
| 1.3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах; | |
| 1.3.1. Эрчим хүчний инженер-техникийн ажилтан бэлтгэх дотоодын сургалтын байгууллагын сургалтын чанарыг сайжруулах, салбарын инженер-техникийн ажилтан, менежерийн чадамжийг олон улсын түвшинд хүргэх; | |
| 1.3.2. Эрчим хүчний эдийн засаг, үйлдвэрлэл, туршилт, тохируулгын судалгаа, хөгжлийн үндэсний хүрээлэнг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх; | |
| 1.3.3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийн балансыг зохистой түвшинд хадгалан удирдлагын бүх түвшинд мэргэжлийн боловсон хүчний шаталсан байршуулалтын тогтолцоог мөрдөх. | |
| **Тэргүүлэх чиглэл 2.** Эрчим хүчний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх | |
| 2.1. Эрчим хүчний салбарыг хувийн хэвшилд суурилсан, зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх; | |
| 2.1.1. Бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифийн тогтолцоог бий болгож, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах; | |
| 2.1.2. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх; | |
| 2.1.3. Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх. | |
| 2.2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх; | |
| 2.2.1. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааны удирдлага, хяналт, мэдээллийн системийг тоон системд бүрэн шилжүүлж, нэгдсэн ухаалаг сүлжээг бий болгох; | |
| 2.2.2. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх; | |
| 2.2.3. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээн дэх алдагдлыг бууруулах; | |
| 2.2.4. Үндэсний хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэглэгч талын менежментийг хөгжүүлэх; | |

| | |
|---|---|
| 2.2.5. Эрчим хүчний хэрэглээ тооцох механизмыг бүрэн хэмжүүржүүлэх. | |
| **Тэргүүлэх чиглэл 3.** Байгаль орчны тогтвортой байдлыг хангах, ногоон хөгжлийг дэмжих | |
| 3.1. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах; | |
| 3.1.1. Монгол орны сэргээгдэх эрчим хүч /нар, салхи, ус, газрын гүний дулаан, биомасс зэрэг/-ний нөөцийг нарийвчлан тогтоох, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэ техник, технологийн судалгаа, шинжилгээ хийх байгууллагыг хөгжүүлэх; | |
| 3.1.2. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувь хүртэл нэмэгдүүлэх; | |
| 3.1.3. Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүй, татварын таатай орчныг бүрдүүлэх, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизмыг бий болгох; | |
| 3.1.4. Айл өрх, аж ахуйн нэгж, алслагдсан суурин, баг, бие даасан хэрэглэгчийн эрчим хүчний хангамжид нар, салхи, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглах, илүүдэл эрчим хүчээ сүлжээнд нийлүүлэхийг дэмжих; | |
| 3.1.5. Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааны байгаль орчин, экологид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах; | |
| 3.1.6. Байгаль орчны нөлөөллийн хяналтыг сайжруулах. | |

## Хавсралт 3. МУТХҮБ-2030-ын зорилтуудын ДТХЗ-тай нийцэж байгаа эсэх байдал

| **ДХТЗ** | **МУТХҮБ - 2030 зорилтууд** | |
|---|---|---|
| Зорилго 1. Ядуурлын бүх хэлбэрийг эцэс болгох | Нийгмийн тогтвортой хөгжил 2.2.1. хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал. | |
| Зорилт 1.1. 2030 он гэхэд өдөрт 1.25 ам.доллараас бага орлоготой гэж одоогоор тооцогдож буй хүмүүсийн туйлын ядуурлыг арилгах | Зорилт 1. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно. | Нийцсэн |
| Зорилт 1.2. 2030 он гэхэд үндэсний тодорхойлолтын дагуу ядуурлын бүх хэмжигдэхүүнээр ядуу амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн хувийн жинг наад зах нь хоёр дахин бууруулах | **I үе шат** (2016-2020): Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтод бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулан хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18% хүртэл бууруулах. | Зөрүүтэй |

| | | |
|---|---|---|
| | **II үе шат** (2021-2025): Иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулан тогтвортой ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулж, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх.<br>**III үе шат** (2026-2030): Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх бүтээлч байдлыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгон, бичил, жижиг, дунд, бизнесийг дэмжих замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын хүн амд эзлэх хувийг 80 хувьд хүргэх. | Нийцсэн |
| Зорилт 1.3. Үндэсний онцлогт тохирсон нийгмийн хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгмийн хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгмийн хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулах | Зорилт 3. Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Нийгмийн даатгалын / тэтгэврийн, үйлдвэрлэлийн ослын, ажилгүйдлийн, хөдөлмөр эрхлэлтийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн даатгал/ тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлж, сангуудын бие даасан байдал, удирдлага, засаглалыг сайжруулж, захиран зарцуулалт, санхүүгийн менежментийг ил тод болгох.<br>**II үе шат** (2021-2025): Нийгмийн даатгалын олон давхаргат тогтолцоог боловсронгуй болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай, зах зээлийн нөхцөлтэй уялдуулан тогтоох.<br>**III үе шат** (2026-2030): Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, нийгмийн даатгалын бүрэн бие даасан тогтолцоог бий болгох. | Нийцсэн |
| Зорилт 1.4. 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй хүн бүр, ялангуяа ядуу эмзэг бүлгийнхэн эдийн засгийн нөөц бололцоог эрх тэгш авч ашиглах, түүнчлэн нийгмийн үндсэн үйлчилгээ, газар болон бусад хэлбэрийн эд хөрөнгө өмчлөх, захиран зарцуулах, өв залгамжлах, байгалийн баялаг зохих шинэ технологи, санхүүгийн үйлчилгээ, түүний дотор бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх | **III үе шат** (2026-2030): Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгон, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын хүн амд эзлэх хувийг 80 хувьд хүргэх.<br>Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцлийг бүрдүүлнэ. | Нийцсэн |
| Зорилго 2. Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, хоол тэжээлийн байдлыг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих | | |

| | | |
|---|---|---|
| Зорилт 2.2. 2025 он гэхэд 5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой туранхай хүүхдийн талаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн зорилтуудад хүрэх замаар хоол, тэжээлийн дутагдлын бүх хэлбэрийг арилгаж, өсвөр насны охид, жирэмсэн болон хүүхдээ хөхөөрөө хооллож буй эмэгтэйчүүд, өндөр настнуудын хоол тэжээлийн хэрэгцээг 2030 он гэхэд хангах | Зорилт 2. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна. | ДТХЗ түвшин манайхаас дээгүүр |
| Зорилт 2.3. Нэмүү өртөг шингээх, хөдөө аж ахуйн бус ажил эрхлэлтийг бий болгох үүднээс газар, үр ашигтай бусад баялаг, мэдээлэл мэдлэг, санхүүгийн үйлчилгээ, зах зээл, нөөц боломжийг ашиглах, эрх тэгш баталгаатай байх боломжийг бүрдүүлэх замаар жижиг хэмжээний хүнсний үйлдвэрлэгчид, ялангуяа нутгийн иргэд гэр бүлийн фермерийн аж ахуй эрхлэгчид, малчид, загасны аж ахуй эрхлэгчдийн хөдөө аж ахуйн бүтээмж орлогыг 2030 он гэхэд хоёр дахин нэмэгдүүлэх | Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.<br>**I үе шат** (2016-2020): Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 100 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.<br>**II үе шат** (2021-2025): Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 68 хувьд, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд хүргэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийн хэмжээг 200 тэрбумаас доошгүй төгрөгт хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 70 хувьд, ажилгүйдлийн түвшинг 3 хувьд хүргэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээг 300 тэрбумаас доошгүй төгрөгт хүргэх. | Ялгаатай |
| Зорилго 3. Бүх түвшинд эрүүл амьдралыг хангаж, сайн сайхан аж байдлыг хөхүүлэн дэмжих | 2.2.2. Эрүүл мэндийн чанартай, хүрээмжтэй тогтолцоо бий болгох. | |
| Зорилт 3.1. 2030 он гэхэд 100.000 амьд төрөлт тутамд эхийн эндэгдлийн түвшинг 70-аас доош болгон бууруулах | **I үе шат** (2016-2020): Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 25.<br>**II үе шат** (2021-2025): Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 20.<br>**III үе шат** (2026-2030): Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 15 болгон бууруулах. | Дэлхийн түвшингээс манайх дээгүүр |

| | | |
|---|---|---|
| Зорилт 3.2. 2030 он гэхэд урьдчилан сэргийлэх боломжтой нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг арилгах | **I үе шат** (2016-2020): Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 13 болгож бууруулах.<br>**II үе шат** (2021-2025): Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 11 болгож бууруулах.<br>**III үе шат** (2026-2030): Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 9, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах. | Зөрүүтэй |
| Зорилт 3.3. 2030 он гэхэд ДОХ, сүрьеэ, хумхай өвчний тархалтыг дарах, элэгний үрэвсэл, усаар дамжин халдварладаг өвчин, бусад халдварт өвчинтэй тэмцэх, устгах | Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.<br>**I үе шат** (2016-2020): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 98.5, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг 14.4 болгон бууруулах.<br>**II үе шат** (2021-2025): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2.5, сүрьеэгийн тохиолдлыг 14 болгон бууруулах.<br>**III үе шат** (2026-2030): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99.8, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2, сүрьеэгийн тохиолдлыг 13 болгон бууруулах. | Зөрүүтэй: Манай хүрэх түвшин доогуур |
| Зорилт 3.4. 2030 он гэхэд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг эмчлэх замаар халдварт өвчнөөс үүдэлтэй цаг бусаар нас барах явдлыг гуравны нэгээр бууруулах | Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.<br>**I үе шат** (2016-2020): Хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах.<br>**II үе шат** (2021-2025): Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9 хүртэл бууруулах.<br>**III үе шат** (2026-2030): 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 14, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 8 хүртэл бууруулах. | Зөрүүтэй |

| | | |
|---|---|---|
| Зорилго 4. Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийг насан туршдаа суралцах боломжийг дэмжин хөхүүлэх | 2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий монгол хүн | |
| Зорилт 4.1. 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд үнэ төлбөргүй, тэгш чанартай бага болон дунд шатны боловсролыг эзэмшиж, холбогдох үр дүнтэй эрдэм мэдлэгтэй болсон байх | Зорилт 2. Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.<br>**I үе шат** (2016-2020): Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх.<br>**II үе шат** (2021-2025): Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 30 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 25-аас илүүгүй байлгах.<br>**III үе шат** (2026-2030): Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд эзлэх байрыг 5-аар урагшлуулж, сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх сургуулийг 100 хувь хангах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 50 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 20-оос илүүгүй байлгах. | Хүртээмж, нийцэхгүй, чанар нийцсэн |
| Зорилт 4.2. 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг бага боловсролд бэлтгэж, бага насны хүүхдүүдийг хөгжүүлэх | Зорилт 1. Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ. | Нийцсэн |
| Зорилт 4.3. 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэй хүнд хямд үнэтэй, чанартай техникийн мэргэжлийн болон дээд боловсрол, түүний дотор их, дээд сургуулийн боловсролыг тэгш авах боломжийг бүрдүүлэх | Зорилт 3. Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60 мянгад хүргэх.<br>**II үе шат** (2021-2025): Мэргэжлийн боловсрол, сургалтын эрэлтэд нийцсэн тогтолцоог төлөвшүүлж, суралцагчдын тоог нэмэгдүүлэх.<br>**III үе шат** (2026-2030): Үндэсний ажиллах хүчний хэрэгцээг мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнээр бүрэн хангах.<br>Зорилт 4. Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно. | Нийцсэн |

| | | |
|---|---|---|
| Зорилго 5. Жендерийн тэгш байдлыг хангаж бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах | Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.<br>Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчим:<br>- Хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүртээмжтэй өсөлтөд суурилсан хүний хөгжил байх; | |
| | - Иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;<br>- Эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх;<br>- Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах;<br>- Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх;<br>- Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;<br>- Нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;<br>- Нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчныг бүрдүүлэх;<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх. | Хүрэх түвшин, зорилт байхгүй |
| Зорилго 6. Хүн бүрд ус, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй хүргэж, тэдгээрийн тогтвортой менежментийг хангах | 2.3. Байгаль орчны тогтвортой хөгжил<br>2.3.1. Усны нөөцийн менежмент | |

| | | |
|---|---|---|
| Зорилт 6.1. 2030 он гэхэд хүн бүрийг ундны аюулгүй, боломжийн үнэтэй усаар хангах | Зорилт 1. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тундас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх.<br>**II үе шат** (2021-2025): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх, гадаргын усыг хуримтлуулах усан сангуудыг байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 23 хувьд хийх.<br>**III үе шат** (2026-2030): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх. | Ялгаатай |
| Зорилт 6.2. 2030 он гэхэд хүн бүрийг тэгш хүртээмжтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид хамруулж, охид, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний хэрэгцээ шаардлагыг онцгойлон анхааран үзэж, ил задгай бие засан явдлыг зогсоох | Зорилт 2. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.<br>**II үе шат** (2021-2025): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85 хувьд хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох.<br>**III үе шат** (2026-2030): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэж, хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох. | Манай түвшин доогуур |
| Зорилго 7. Хүн бүрийг боломжийн, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүч хэрэглэх боломжоор хангах | 2.1.5. Дэд бүтцийн салбар | |
| Зорилт 7.1. 2030 он гэхэд боломжийн, найдвартай, орчин үеийн эрчим хүч үйлчилгээгээр хүн бүрийг хангах | Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.<br>**I үе шат** (2016-2020): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.<br>**II үе шат** (2021-2025): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 90 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.<br>**III үе шат** (2026-2030): Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүчний экспортлогч орон болох. | |

| | | |
|---|---|---|
| Зорилт 7.2. 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх | Зорилт 2. Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана.<br>**I үе шат** (2016-2020): Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах.<br>**II үе шат** (2021-2025): Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг бүрэн хангах.<br>**III үе шат** (2026-2030): Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглаж эхлэх. | Сэргээгдэх эрчим хүчний талаар нийцсэн, гэхдээ цөмийн эрчим хүч |
| Зорилго 8. Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих | Эдийн засгийн тогтвортой хөгжил | |
| Зорилт 8.1. Үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн нэг хүнд ногдох эдийн засгийн өсөлтийг хангаж, ялангуяа нэн буурай хөгжилтэй улс орнуудад жилийн ДНБ-ий өсөлтийг 7 хувьд байлгах | • Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим:<br>• Урт хугацааны эдийн засгийн дундаж өсөлтийг 6.6 хувиас доошгүй байлгах;<br>• Нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах, төсвийн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 2020 онд 15 хувь, 2025 онд 10 хувь хүртэл бууруулах;<br>• Төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлага /улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцсоноор/-ыг 2020 онд 35 хувь, 2030 онд 30 хувь хүртэл бууруулах;<br>• Өрийн дээд хязгаарыг чанд сахин мөрдөж, өрийн зохистой түвшинг хангах, гадаад зах зээл дэх Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтмол дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх;<br>• Гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулах;<br>• Гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлж байх;<br>• Төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцыг тогтвортой, нам түвшинд барих;<br>• Банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх;<br>• Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлэх; | Манай түвшин доогуур |

| | | |
|---|---|---|
| | • Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах. | |
| Зорилт 8.2. Эдийн засгийг төрөлжилт, технологийн шинэчлэл, инновациар дамжуулан, түүний дотор өндөр өртөг шингэсэн, ажиллах хүч ихээр шаарддаг салбаруудад голлон анхаарч эдийн засгийн бүтээмжийн өндөр түвшинд хүрэх | 2.1.1. Хөдөө аж ахуйн салбар<br>Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.<br>Зорилт 2. Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.<br>Зорилт 3. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.<br>2.1.3. Аж үйлдвэрийн салбар<br>Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх. | Нийцсэн |

| | | |
|---|---|---|
| | **I үе шат** (2016-2020): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.<br>**II үе шат** (2021-2025): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх.<br>Зорилт 2.Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ. | Нийцсэн |
| Зорилт 8.3. Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр бий болгох, аж ахуйн эрхлэх, бүтээлч байдал, инновацийг дэмждэг хөгжлийн чиг баримжаатай бодлогыг хөхиүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох замаар бичил, жижиг, дунд бизнесийг албан ёсны болгож, тэдгээрийн өсөлтийг дэмжих | Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцлийг бүрдүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Малчин, тариаланчдын 50 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.<br>**II үе шат** (2021-2025): Малчин, тариаланчдын 75 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрх, тариаланчдын бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох.<br>**III үе шат** (2026-2030): Малчин, тариаланчид бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болсон байх. | Манай хүрэх түвшин 75 хувь |

| | | |
|---|---|---|
| Зорилт 8.5. 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох | Зарчим:<br>• Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд байлгах;<br>• Монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх. | Хүрэх түвшин байхгүй |
| Зорилт 8.9. 2030 он гэхэд ажлын байр бий болгож, орон нутгийн соёл, бүтээгдэхүүнийг дэмждэг тогтвортой аялал жуулчлалыг хөхүүлэн дэмжих бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх | 2.1.2. Аялал жуулчлалын салбар<br>Зорилт 1. Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно.<br>**I үе шат** (2016-2020): Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж гадаадын жуулчдын тоог 1.0 сая хүргэх.<br>**II үе шат** (2021-2025): Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах, гадаадын жуулчдын тоог 1.5 саяд хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2 саяд хүргэх. | Ялгаатай |
| Зорилт 8.10. Хүн бүрт банк, даатгал, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хүргэж өргөжүүлэх, түүнийг дэмжих дотоодын санхүүгийн институцийн чадавхыг бэхжүүлэх | Зорилт 2. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ. | Нийцсэн |

| | | |
|---|---|---|
| Зорилт 8.а. Нэн буурай хөгжилтэй орнуудад үзүүлэх худалдааны холбогдолтой техникийн туслалцааны сайжруулсан нэгдсэн хүрээ, бүтцээр дамжуулан хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй улс орнуудад үзүүлэх худалдааны тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэх | 2.1.7. Бизнесийн таатай орчин<br>Зорилт 1.Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөржүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах.<br>**II үе шат** (2021-2025): Тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулан, боловсронгуй болгож, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 18 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах.<br>**III үе шат** (2026-2030): Худалдаа, үйлчилгээний дэд бүтэц, ложистик сүлжээг хөгжүүлэн экспортын барааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, импортын барааны тээвэрлэлтийн өртөг, зардлыг бууруулж, гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 10 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах. | Ялгаатай |
| Зорилго 9. Уян хатан дэд бүтцийг байгуулж, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдэржилтийг дэмжиж, инновацийг хөгжүүлэх | 2.1.5.Дэд бүтцийн салбар | |

| | | |
|---|---|---|
| Зорилт 9.1 Хүн бүрт тэгш, хүртээмжтэй байх талыг голлон анхаарч эдийн засгийн хөгжил, хүний сайн сайхан аж байдлыг дэмжих чанартай, найдвартай, тогтвортой, уян хатан дэд бүтэц, түүний бүсийн болон хил дамнасан дэд бүтцийг хөгжүүлэх | Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.<br>**I үе шат** (2016-2020): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.<br>**II үе шат** (2021-2025): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 90 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.<br>**III үе шат** (2026-2030): Эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүчний экспортлогч орон болох.<br>Зорилт 2. Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана.<br>**I үе шат** (2016-2020): Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 20-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах.<br>**II үе шат** (2021-2025): Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг бүрэн хангах.<br>**III үе шат** (2026-2030): Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглаж эхлэх.<br>Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа худаг–Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх. | Ялгаатай |
| | **II үе шат** (2021-2025): Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхайн салбарт түшиглэсэн тээвэр ложистикийн төвүүдийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 800 км-ээр нэмэгдүүлж, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж дуусгах, бүсүүдийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.<br>**III үе шат** (2026-2030): Тээвэр ложистикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай авто замын уртыг 470 км-ээр нэмэгдүүлж, бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах. | Нийцсэн |

| | | |
|---|---|---|
| | Зорилт 4. Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх, Хөшигтийн хөндийн олон улсын нисэх буудлыг барьж дуусгах.<br>**II үе шат** (2021-2025): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний нисэхийн нөөц буудал байгуулах, агаарын тээвэрт чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох.<br>**III үе шат** (2026-2030): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний агаарын тээврийн сүлжээг хөгжүүлж, бүс нутагт агаарын тээврийн транзит төвийг хөгжүүлэх. | Нийцсэн |
| Зорилт 9.2. Хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэржилтийг хөхиүлэн дэмжиж, 2030 он гэхэд үндэсний нөхцөл байдалтай уялдуулан ДНБ-д аж үйлдвэрийн салбарын ажлын байрны эзлэх хувийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудад энэ хувийг хоёр дахин өсгөх | 2.1.3.Аж үйлдвэрийн салбар<br>Зорилт 1.Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.<br>I үе шат (2016-2020): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.<br>II үе шат (2021-2025): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх.<br>III үе шат (2026-2030): Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх. | Нийцсэн |

| | | |
|---|---|---|
| Зорилт 9.5. Бүх улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнуудын технологийн чадавхыг дээшлүүлэх, шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажлыг сайжруулах, түүний дотор 2030 он гэхэд инновацийг дэмжих, 1 сая хүнд ногдох судалгаа хөгжлийн ажилтны тоог [x] хувиар нэмэгдүүлэх, судалгаа хөгжилд зарцуулах төр, хувийн хэвшлийн зардлыг өсгөх | 2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн<br>Зорилт 5. Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь хүртэлх түвшинд хүргэх.<br>**II үе шат** (2021-2025): Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2.5 хувь хүртэлх түвшинд хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь хүртэлх түвшинд хүргэх. | Ялгаатай, манайх хөрөнгө оруулалт ДТХ судалгаа хийх ажилтны тоо, хувийн хэвшлийн зардлыг нэмэгдүүлэх |
| Зорилт 9.c. 2020 он гэхэд мэдээлэл, холбооны технологийн хүртээмжийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, нэн буурай хөгжилтэй орнуудын хүн амыг хямд үнэтэй интернетээр хангахыг эрмэлзэх | Зорилт 7. Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө.<br>**I үе шат** (2016-2020): Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлэх.<br>**II үе шат** (2021-2025): Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернетийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-иас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх.<br>**III үе шат** (2026-2030): Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах. | Нийцсэн |
| Зорилго 10. Улс орнууд хоорондын тэгш бус байдлыг бууруулах | | Байхгүй |

| | | |
|---|---|---|
| Зорилт 10.1. 2030 он гэхэд бага орлоготой хүн амын 40 хувийг орлогын өсөлтийг үндэсний дунджаас дээгүүр түвшинд аажмаар хүргэж, хадгалах | Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно.<br>Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монгол Улс 2030 онд:<br>1.Нэг хүнд ногдох ҮНО 17500 ам.долларт хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ.<br>2.Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна.<br>2.2.1.Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал | Хүрэх түвшин тодорхойлогдоогүй |
| Зорилго 11. Хот, хүн амын суурьшлыг бүх талын оролцоог хангасан, аюулгүй, эрсдлийг даван туулах чадвартай, тогтвортой болгох | 2.1.5.Дэд бүтцийн салбар<br>Зорилт 5.Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.<br>**I үе шат** (2016-2020): “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг үе шаттай хэрэгжүүлэх, аймгийн төвүүдийн хөгжлийн болон улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх.<br>**II үе шат** (2021-2025): Аж үйлдвэрийн хөгжлийн тэргүүлэх бүсийг тогтоож, хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан мөрдүүлэх, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах, газар нутаг ашиглалтын мастер төлөвлөгөөг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд тус тус боловсруулж, мөрдүүлэх.<br>**III үе шат** (2026-2030): Хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үргэлжлүүлэн боловсруулж, мөрдүүлэх. | Нийцсэн |
| Зорилт 11.6. 2030 он гэхэд агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах<br><br>Зорилт 11.7. 2030 он гэхэд хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшлийн талбайгаар хангах | Зорилт 2. Хот, суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна.<br><br>**I үе шат** (2016-2020): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох. | Ялгаатай, ДТХ хүрэх түвшин тодорхойлогдоогүй |

| | | |
|---|---|---|
| | **II үе шат** (2021-2025): Хот, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 30 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 40 хувьд хүргэх. | Манай хүрэх түвшин доогуур |
| Зорилт 12.2. 2030 он гэхэд байгалийн баялгийг үр ашигтай хэрэглэж, түүний тогтвортой менежментийг бүрдүүлэх | Зорилт 1. Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.<br>**I үе шат** (2016-2020): Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхыг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх.<br>**II үе шат** (2021-2025): Геомэдээллийн нэгдсэн сан бий болгож, ашигт малтмал хайгуулын салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын хэмжээнд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 45 хувьд гүйцэтгэх.<br>**III үе шат** (2026-2030): Ашигт малтмалын эрдсийн хуримтлал бүхий талбайд нарийвчилсан эрлийн ажлыг хийх, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын хэмжээнд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 50 хувьд гүйцэтгэх.<br>Зорилт 2. Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.<br>**II үе шат** (2021-2025): Усан хангамжийн найдвартай эх үүсвэрийн төслүүдийг хэрэгжүүлж, уул уурхайн томоохон төслүүдийн үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадлыг эзэмших.<br>**III үе шат** (2026-2030): Уул уурхайн томоохон төслүүдийн шинэ бүтээн байгуулалтыг эхлүүлж, дэд бүтцийг хөгжүүлэх. | Ялгаатай |

| | | |
|---|---|---|
| Зорилго 13. Цаг уурын өөрчлөлт, түүний үр дагавартай тэмцэх талаар яаралтай арга хэмжээ авах | 2.3.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох | |
| Зорилт 13.1. Улс орнуудад тулгарч буй цаг уутай холбоотой аюул осол, байгалийн гамшгийг даван туулах, тэдгээрт зохицох чадавхыг бэхжүүлэх | Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ. | Нийцсэн |
| Зорилт 13.2. Цаг уурын өөрчлөлтийн талаарх арга хэмжээг үндэсний бодлого, стратеги, төлөвлөлтөд тусгах | **II үе шат** (2021-2025): Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 7 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 5 дахин нэмэгдүүлэх. | Манай ТХҮБ 2030 онд хүрэх түвшин тодорхойлогдсон |
| Зорилго 15. Дэлхийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, түүний тогтвортой хэрэглээг дэмжих, ойг тогтвортой ашиглах, цөлжилттэй тэмцэх, хөрсний доройтлыг зогсоох, сэргээх, биологийн олон янз байдал алдагдаж буйг зогсоох | 2.3.3. Экосистемийн тэнцвэрт байдал | |
| Зорилт 15.2. 2020 он гэхэд бүх төрлийн ойн тогтвортой менежментийг нэвтрүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих, цөлжилтийг зогсоох, муудсан ойг сэргээх, ойжуулах, моджуулах ажлыг олон улсын түвшинд [x] хувиар нэмэгдүүлэх | Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.<br>**I үе шат** (2016-2020): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх.<br>**II үе шат** (2021-2025): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 27 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.7 хувьд хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9 хувьд хүргэх. | Манай ТХҮБ 2030 онд хүрэх түвшин тодорхойлогдсон (ахиц бага) |
| Зорилго 16. Тогтвортой хөгжлийн төлөө аюулгүй, бүх талын оролцоог хангасан нийгмийг хөгжүүлж, хүн бүрийг хуулиар хамгаалуулах боломжоор хангах, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан институцийг бий болгох | 2.4. Тогтвортой хөгжлийн засаглал | |

| | | |
|---|---|---|
| Зорилт 16.5. Авилга, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах | Зорилт 3.Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана. | Нийцсэн |
| Зорилт 16.6. Бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институцийг хэвшүүлэх | Зорилт 1.Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ.<br>Зорилт 2.Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ. | Нийцсэн |
| Зорилт 16.7. Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох | Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим:<br>- төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах;<br>- хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;<br>- удирдлагын ил тод байдлыг хангах;<br>- төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;<br>- төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах. | Зарчмын хувьд нийцсэн |
| Зорилт 16.8. Дэлхийн засаглалын үйл ажиллагаанд хөгжиж буй улс орнуудыг оролцуулах явдлыг нэмэгдүүлэх, сайжруулах | Зорилт 4.Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно. | Нийцсэн |
| Зорилт 17.12. Нэн буурай хөгжилтэй орнуудын үүслийн хөнгөлөлттэй дүрмийг ил тод, тодорхой худалдааны байгууллагын шийдвэрт нийцсэн нэн буурай орнуудад урт хугацаанд үргэлжлэх татваргүй, квот бий болгох ажлыг шуурхай хэрэгжүүлж, зах зээлд нэвтрүүлэх | Хөдөө аж ахуйн салбар. Зорилт 1: (2026-2030): Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нийт газар нутгийн 60-аас доошгүй хувьд хүргэж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортод гаргах боломжийг өргөтгөх, олон улсын стандартад нийцсэн үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоотой болох. | Нийцсэн |

## Хавсралт 4. МУТХҮБ-2030-ын зорилгуудын ДТХЗ-тай нийцэж байгаа эсэх байдал

| ЗОРИЛТУУД | | ДТХЗ | МУТХҮБ-2030 | ҮНЭЛГЭЭ |
|---|---|---|---|---|
| **Зорилго 1. Ядуурлын бүх хэлбэрийг бүрэн устгах** | | | | |
| 1 | 1.1. | 1.1. 2030 он гэхэд нэн ядуурлыг бүрэн устгах. Нэн ядуурал өдөрт 1.25 ам.доллараар амьдарч байгаа хүмүүс хамрагдана. | Зорилт 1. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно. | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | 1.2. | Үндэсний үзүүлэлтээр ядуурлын түвшинд амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн тоог тэн хагасаас доошгүй хувиар бууруулах. | **I үе шат** (2016-2020): Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэн, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах.<br>**II үе шат** (2021-2025): Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулж, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлэх. | 1 |
| 3 | 1.3. | Амьжиргааны доод хэмжээг тогтоох зэрэг бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын тогтолцоо болон арга хэмжээг үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх, 2030 он гэхэд ядуу болон эмзэг бүлгийнхнийг хамруулахад дорвитой ахиц гаргах. | Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлнэ. | 2 |
| 4 | 1.4. | 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүс, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийнхэн эдийн засгийн нөөцийг ашиглах, үндсэн үйлчилгээнд хамрагдах, газар болон бусад өмчийн хэлбэрийг өмчлөх, түүнд хяналт тавих, залгамжлах, байгалийн нөөцийг ашиглах, холбогдох шинэ технологи болон санхүүгийн, бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах тэгш эрхийг хангах. | Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхүүлэн дэмжиж, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгон, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгоно. | 2 |
| 5 | 1.5. | 2030 он гэхэд ядуу, эмзэг байдалд байгаа хүмүүсийн уян хатан байдлыг бэхжүүлэх, уур амьсгалын холбоотой онцгой нөхцөл, эдийн засаг, нийгэм, байгаль орчны гамшиг, аюулд өртөх эмзэг байдлыг бууруулах. | | 3 |
| 6 | 1.a. | Хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй орнуудад ядуурлын бүх хэлбэрийг устгах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хангалттай, найдвартай арга хэрэгсэл, ихээхэн нөөцийг янз бүрийн эх сурвалжаас дайчлах, хөгжлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хангах. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | 1.б. | Ядуурлыг устгахад оруулах хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн, ядуус, жендэрийн эмзэг асуудлыг харгалзсан зохистой бодлогын тогтолцоог үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд бий болгох. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилго 2. Өлсгөлөнг зогсоож, хүнсний аюулгүй байдлыг хангаж, тэжээллэг чанарыг нэмэгдүүлж, хөдөө аж ахуйн тогтвортой өсөлтийг хөхүүлэн дэмжих.** | | | | |
| 8 | 2.1. | 2030 он гэхэд өлсгөлөнг зогсоож, бүх хүмүүс, ялангуяа ядуу болон эмзэг байдалд байгаа хүмүүс, бага насны хүүхдүүдийг аюулгүй, тэжээллэг, хэрэгцээтэй хүнсээр жилийн турш хангах байдлыг баталгаажуулна. | Зорилт 2. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна. | 2 |
| 9 | 2.2. | 2030 он гэхэд хоол тэжээлийн дутмаг байдлын бүх хэлбэрийг зогсоох, 2025 он гэхэд 5-аас доош насны хүүхдийн тураал, өсөлт саарахтай холбоотой олон улсын хэмжээнд тохиролцсон үзүүлэлтийг баримтлах, өсвөр насны охид, жирэмсэн болон хөхүүл эхчүүд, өндөр настны хоол тэжээлийн асуудлыг шийдвэрлэх. | | 3 |
| 10 | 2.3. | 2030 он гэхэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүнс үйлдвэрлэгч жижиг нэгжүүд, ялангуяа эмэгтэйчүүд, уугуул ард иргэд, өрхийн аж ахуй, бэлчээрийн болон загасны аж ахуйн орлогыг нэг дахин өсгөх, тэдэнд газар, үйлдвэрлэлийн бусад нөөц хөрөнгө, мэдлэг, санхүүгийн үйлчилгээ, зах зээл, нэмүү өртгийн боломжид тэгш, баталгаатай хамрагдах, хөдөө аж ахуйгаас бусад салбарт хөдөлмөр эрхлэх боломжоор хангах. | | 3 |
| 11 | 2.4. | 2030 он гэхэд үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын онцгой нөхцөл, ган, үер, бусад гамшигт дасан зохицох чадварыг сайжруулах, газар, хөрсний чанарыг түлхүү дээшлүүлэхэд чиглэгдсэн хүнсний тогтвортой үйлдвэрлэлийн тогтолцоонууд болон хөдөө аж ахуйн салбарын уян хатан практик туршлагыг түгээх, хэрэгжүүлэх. | 2.3.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох<br>Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ. | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12 | 2.5. | 2020 он гэхэд үр, таримал ургамал, мал болон тэжээмэл амьтан, тэдгээрийн зэрлэг зүйл төрлийн генетикийн олон янз байдлыг хадгалах, үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд олон янзын үр, ургамлын фондыг зохистой менежментээр хангах, генетикийн нөөц болон уламжлалт мэдлэгийг ашигласны үр ашгийг шударга , тэгш байдлаар хүртэх асуудлыг олон улсын хэмжээнд тохиролцсон ёсоор шийдвэрлэх. | | 3 |
| 13 | 2.а. | Хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй орнуудын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чадавхыг  нэмэгдүүлэх зорилгоор хөдөө орон нутгийн дэд бүтэц, хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээ болон үйлчилгээ, технологийн хөгжил, ургамал болон малын генийн фондыг сайжруулахад хөрөнгө оруулалтыг, тухайлбал олон улсын хамтын ажиллагааны шугамаар нэмэгдүүлэх. | Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ. | 2 |
| 14 | 2.б. | Дохагийн Хөгжлийн хэлэлцээний мандатын дагуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт, түүнтэй адил үр дагавартай экспортын бүх арга хэмжээний бүх төрлийн тэтгэмжийг зэрэгцэн халах замаар дэлхийн хөдөө аж ахуйн зах зээлийн худалдааны хориг хязгаарлалт, гажуудлыг зогсоох, залруулах. | | 3 |
| 15 | 2.в. | Хүнсний бүтээгдэхүүний үнийн хэт хэлбэлзлийг хязгаарлах зорилгоор хүнсний болон дагавар бүтээгдэхүүний зах зээлийн зохистой үйл ажиллагааг хангах, хүнсний нөөц болон зах зээлийн бусад мэдээллийг цаг тухайд нь авах боломжийг бүрдүүлэх. | | 3 |
| **Зорилго 3. Нийт хүн амыг насан турш эрүүл, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах.** | | | | |
| 16 | 3.1. | 2030 он гэхэд дэлхийн хэмжээнд эхийн эндэгдлийн хувийг 100,000 амьд төрөлтөд 70-аас дээшгүй болгон бууруулах. | **III үе шат** (2026-2030): Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 15 болгож бууруулна. | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 17 | 3.2. | 2030 он гэхэд шинэ төрсөн болон 5-аас доош насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг зогсоох. Ингэхдээ улс орнууд 1000 амьд төрөлтөд шинэ төрсөн хүүхдийн эндэгдлийг 12-оос, 1000 амьд төрөлтөд 5-аас доош насны хүүхдийн эндэгдлийг 25-аас дээшгүй байлгах зорилт тавина. | **III үе шат** (2026-2030): тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 9, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах. | 1 |
| 18 | 3.3. | 2030 он гэхэд ДОХ, сүрьеэ, хумхаа, урьд нь анхааралгүй орхисон халуун орны өвчнийг зогсоох, шар, усаар дамждаг болон халдварт бусад өвчинтэй тэмцэх. | Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.<br>**III үе шат** (2026-2030): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99.8, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2, сүрьеэгийн тохиолдлыг 13 болгон бууруулах. | 1 |
| 19 | 3.4. | 2030 он гэхэд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон эмчилгээ, оюуны эрүүл мэнд болон амьжиргааг сайжруулах замаар халдварт бус өвчний нас баралтыг гуравны нэгээр бууруулах. | **III үе шат** (2026-2030): Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж,10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 14, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 8 хүртэл бууруулах. | 1 |
| 20 | 3.5. | Сэтгэцэд нөлөөлдөг, тухайлбал мансууруулах бодис, архи зэрэг хорт зуршлаас сэргийлэх, эмчлэх үйлчилгээг сайжруулах. | **I үе шат** (2016-2020): Хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар, стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах. | 2 |
| 21 | 3.6. | 2020 гэхэд замын хөдөлгөөнөөс үүдэлтэй нас баралт, эндэгдэл, гэмтлийг дэлхийн хэмжээнд тэн хагасаар бууруулах. | | 3 |
| 22 | 3.7. | 2030 он гэхэд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, тухайлбал гэр бүлийн төлөвлөлт, мэдээлэл, боловсролд бүх нийтээр хамрагдах боломжийг хангах, үндэсний стратеги, хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг тусгах. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 23 | 3.8. | Эрүүл мэндийн үйлчилгээ, санхүүгийн эрсдэлийн хамгаалалтад бүх нийтээр хамрагдах, бүх хүмүүсийг чанартай эрүүл мэндийн үйлчилгээ болон аюулгүй, үр дүнтэй, чанартай, хямд эм болон вакцинаар хангах. | **III үе шат** (2026-2030): Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулна. Зорилт 4.Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна. | 2 |
| 24 | 3.9. | 2030 он гэхэд химийн хорт бодис, агаар, ус, хөрсний бохирдол, хордуулалтаас үүдэлтэй үхэл, өвчлөлийн тоог үлэмж бууруулах. | | 3 |
| 25 | 3.a. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Тамхинд хяналт тогтоох суурь конвенцын хэрэгжилтийг бүх улс оронд зохих ёсоор эрчимжүүлэх. | | 3 |
| 26 | 3.б. | Халдварт болон халдварт бус өвчний вакцин, эмийн эрдэм шинжилгээ, судалгаа болон боловсруулалтыг дэмжих, ялангуяа хөгжиж байгаа орнуудад анхаарах, Дохагийн тунхаглалын ТРИПС-ийн гэрээний дагуу хөгжиж байгаа орнуудын хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Оюуны өмчийг худалдаалах хэлэлцээрийн уян хатан байдлын заалтыг бүрэн ашиглах эрхийн хүрээнд бүх хүмүүсийг хямд, нэн хэрэгцээтэй эмийн хэрэгсэл, вакцинаар хангах. | Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна. | 2 |
| 27 | 3.в. | Хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй болон арлын хөгжиж байгаа жижиг орнуудад эрүүл мэндийн санхүүжилтийг үлэмж нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн хүчнийг дайчлах, хөгжүүлэх, сургах, тогтвортой ажиллуулах байдлыг сайжруулах. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 28 | 3.г. | Үндэсний, дэлхий дахины эрүүл мэндийн эрсдэлийн менежментийг сайжруулах, улс орнууд, ялангуяа хөгжиж байгаа орнуудын урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх. | Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.<br>**I үе шат** (2016-2020): Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 71-д хүргэх. | 2 |

| **Зорилго 4. Хүн бүрт чанартай боловсролыг тэгш, оролцоотой хүргэх, насан турш сурч боловсрох боломжийг бүрдүүлэх.** | | | | |
|---|---|---|---|---|
| 29 | 4.1. | 2030 он гэхэд бүх охид, хөвгүүд үнэ төлбөргүй, тэгш, чанартай бага болон дунд боловсрол эзэмших, сургалтын зохих үр дүнд хүрэх нөхцлийг хангах. | Зорилт 2. Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.<br>**III үе шат** (2026-2030): Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд эзлэх байрыг 5-аар урагшлуулж, сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх сургуулийг 100 хувь хангах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 50 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 20-оос илүүгүй байлгах. | 1 |
| 30 | 4.2. | 2030 он гэхэд бүх охид, хөвгүүд бага насны, сургуулийн өмнөх асрамж, боловсролд хамрагдан бага сургуулийн боловсрол эзэмшихэд бэлтгэгдэх нөхцөлийг хангах. | **III үе шат** (2026-2030): Сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоог 20 хүртэл бууруулж сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 90 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх. | 1 |
| 31 | 4.3. | 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэйчүүд хямд, чанартай техникийн техник мэргэжлийн,гурван шатны болон их сургуулийн боловсролд адил эрхтэй хамрагдах нөхцөлийг хангах. | Зорилт 3. Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ.<br>Зорилт 4. Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно. | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 32 | 4.4. | 2030 он гэхэд зохистой ажил хөдөлмөр, бизнес эрхлэх чадвартай, техникийн болон техник мэргэжлийн боловсролтой залуучууд, насанд хүрсэн хүмүүсийн тоог үлэмж нэмэгдүүлэх. | Зорилт 3. Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ.<br>**III үе шат** (2026-2030): Үндэсний ажиллах хүчний хэрэгцээг мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнээр бүрэн хангах. | 1 |
| 33 | 4.5. | 2030 он гэхэд боловсрол дахь жендэрийн тэгш бус байдлыг арилгах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, уугуул ард иргэд, эмзэг эртөмтгий байдалд байгаа хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийнхэн бүх шатны боловсрол болон техник мэргэжлийн сургалтад тэгш хамрагдах нөхцөлийг хангах. | | 3 |
| 34 | 4.6. | 2030 он гэхэд бүх залуучууд, насанд хүрсэн эмэгтэй, эрэгтэйчүүдийн дийлэнх хэсэгт унших, бичих, тоолох мэдлэг олгох. | | 3 |
| 35 | 4.7. | 2030 он гэхэд бүх суралцагчид тогтвортой хөгжлийн болон тогтвортой амьдралын зан үйл, хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайванч болон хүчирхийллийн бус соёл, дэлхийн иргэншил болон соёлын олон янз байдал, тогтвортой хөгжилд соёлын оруулах хувь нэмэр зэрэг тогтвортой хөгжлийг түргэсгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх нөхцөлийг хангах. | | 3 |
| 36 | 4.а. | Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, жендэрийг харгалзсан боловсролын байгууламжийг байгуулах, шинэчлэх, бүх хүмүүст аюулгүй, хүчирхийлэлгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах нөхцөл орчныг  хангах. | | 3 |
| 37 | 4.б. | 2020 он гэхэд хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй болон арлын хөгжиж байгаа жижиг орнууд, Африкийн орнуудад дээд, техник мэргэжлийн, мэдээллийн болон холбооны технологийн боловсрол эзэмших, техникийн, инженерчлэлийн, шинжлэх ухааны хөтөлбөр сургалтад хамрагдах зорилгоор олгох сургалтын тэтгэмжийг дэлхий даяар үлэмж нэмэгдүүлэх, хөгжингүй болон бусад хөгжиж байгаа орнуудад суралцах боломжийг өргөжүүлэх. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 38 | 4.в. | 2030 он гэхэд хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй болон арлын хөгжиж байгаа жижиг орнуудад багш нарыг олон улсын хамтын ажиллагааны шугамаар бэлтгэх зэрэг замаар мэргэшилтэй багш нараар хангах явдлыг үлэмж нэмэгдүүлэх. | Сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоог 20 хүртэл бууруулах. | 2 |

| **Зорилго 5. Жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх.** | | | | |
|---|---|---|---|---|
| 39 | 5.1. | Бүх эмэгтэйчүүд, охидын эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг зогсоох. | | 3 |
| 40 | 5.2. | Олон нийт болон хувийн хэвшлийн салбарт бүх эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тухайлбал хууль бус наймаа, бэлгийн болон бусад мөлжлөгийг устгах. | | 3 |
| 41 | 5.3. | Бага насны хүүхдийг эрт болон албадан гэрлүүлэх, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг гэмтээх зэрэг хор хөнөөлтэй бүх үйлдлийг устгах. | | 3 |
| 42 | 5.4. | Асран хүмүүжүүлэх болон гэрийн цалингүй ажил хөдөлмөрийг олон нийтийн үйлчилгээ, дэд бүтэц, нийгмийн хамгааллын бодлогоор хүлээн зөвшөөрч үнэлэх, айл өрх болон гэр бүлд хариуцлагыг тэнцвэржүүлэх нөхцөлийг үндэсний онцлогийг харгалзан сайжруулах. | | 3 |
| 43 | 5.5. | Улс төр, эдийн засаг, олон нийтийн амьдралын шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн бүрэн болон үр бүтээмжтэй оролцоо, удирдах тэнцүү боломжоор хангах. | | 3 |
| 44 | 5.6. | Хүн ам, хөгжлийн олон улсын бага хурлын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Бээжингийн Үйл ажиллагааны хөтөлбөр, тэдгээрийн үр дүнгийн бусад бага хурлаар хүрсэн тохиролцооны дагуу бүх нийтээр бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах, нөхөн үржихүйн эрхийг эдлэх нөхцөлийг хангах. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 45 | 5.а. | Эмэгтэйчүүдэд эдийн засгийн нөөцийг ашиглах, газар болон хөрөнгийн бусад хэлбэрийг өмчлөх, хянах, залгамжлах, санхүүгийн үйлчилгээ, байгалийн нөөцийг эдлэхэд тэгш эрх олгоход чиглэгдсэн шинэчлэлийг үндэсний хуулийн хүрээнд хийх. | | 3 |
| 46 | 5.б. | Эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд дэвшилтэт технологи, тухайлбал мэдээлэл холбооны технологийг түлхүү ашиглах. | | 3 |
| 47 | 5.в. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бүх эмэгтэйчүүд, охидын эрх мэдлийг бүх түвшинд нэмэгдүүлэх зохистой, мөрдөх боломжтой бодлогыг боловсруулан эрчимжүүлэх. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилго 6. Нийт хүн амыг усны нөөцийн тогтвортой менежмент, хүртээмжтэй, ариун цэврийн байгууламжаар хангах.** | | | | |
| 48 | 6.1. | 2030 он гэхэд нийт хүн амыг аюулгүй, хямд ундны усаар тэгш хангах. | **III үе шат** (2026-2030): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэж, хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох. | 1 |
| 49 | 6.2. | 2030 он гэхэд бүх нийтээр ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой, тэгш үйлчилгээнд хамрагдах, ил бие засах явдлыг зогсоох, ингэхдээ эмэгтэйчүүд, охид, эмзэг байдалд байгаа хүмүүсийн шаардлага хэрэгцээнд онцгой анхаарал хандуулах. | **III үе шат** (2026-2030): Хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох. | 1 |
| 50 | 6.3. | 2030 он гэхэд дэлхий дахинд усны бохирдлыг багасгах, бохир хаягдал цутгахыг зогсоох, химийн хорт бодис болон материал цутгах явдлыг багасгах, цэвэрлээгүй бохир усны хувийг тэн хагасаар бууруулах, бохир усыг эргэлтэд оруулах, дахин аюулгүй ашиглах замаар усны чанарыг дээшлүүлэх. | | 3 |
| 51 | 6.4. | 2030 он гэхэд ус ашиглалтын үр ашгийг бүх салбарт үлэмж дээшлүүлэх, усны хомсдолыг шийдвэрлэх зорилгоор цэнгэг усны хашилт, хангалтыг сайжруулах, усны хомсдолоос тарчилж байгаа хүмүүсийн тоог үлэмж бууруулах. | Зорилт 1.Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.<br>**III үе шат** (2026-2030): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх. | 1 |
| 52 | 6.5. | 2030 он гэхэд усны нөөцийн цогц менежментийг шаардлагатай тохиолдолд хил дамнасан хамтын ажиллагаагаар бүх түвшинд хэрэгжүүлэх. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 53 | 6.6. | 2020 он гэхэд устай холбоотой экологийн тогтолцоо, тухайлбал уул, ой, намаг балчиг, гол мөрөн, усны судал, нууруудыг хамгаалах, сэргээх. | Зорилт 1. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.**III үе шат** (2026-2030): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх. | 2 |
| 54 | 6.а. | 2030 он гэхэд хөгжиж буй орнуудад ус, ариун цэвэртэй холбоотой үйл ажиллагаа болон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, тухайлбал усыг хуримтлуулах, давсгүйжүүлэх, ус ашиглалтыг  сайжруулах, бохир усыг цэвэршүүлэх, эргэлтэд оруулах, дахин ашиглах технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх. | **II үе шат** (2021-2025): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх, гадаргын усыг хуримтлуулах усан сангуудыг байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 23 хувьд хийх. | 2 |
| 55 | 6.б. | Ус, ариун цэврийн менежментийг сайжруулахад орон нутгийн ард иргэдийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилго 7: Нийт хүн амыг хямд, найдвартай, тогтвортой, орчин үеийн эрчим хүчээр хангах.** | | | | |
| | 2.1.5. Дэд бүтцийн салбар: Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно. | | | 1 |
| 56 | 7.1. | 2030 он гэхэд нийт хүн амыг хямд, найдвартай, орчин үеийн эрчим хүчээр хангах. | 2026-2030 онд эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүчний экспортлогч орон болох. | 1 |
| 57 | 7.2. | 2030 он гэхэд дэлхийн эрчим хүчний тогтолцоонд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг үлэмж нэмэгдүүлэх | Зорилт 2. Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангах. 2026-2030 онд нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30-д хүргэх | 1 |
| 58 | 7.3. | 2030 он гэхэд эрчим хүч ашиглалтын үр ашгийг дэлхийн хэмжээнд нэг дахин өсгөх. | 2026-2030 онд цөмийн эрчим хүч ашиглаж эхлэх. | 2 |
| 59 | 7.а. | 2030 он гэхэд экологийн цэвэр эрчим хүчний судалгаа шинжилгээ болон технологийг эзэмших явдлыг эрчимжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, дэвшилтэт, цэвэр ашигт малтмалын шатахууны технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний дэд бүтэц болон цэвэр эрчим хүчний технологид хөрөнгө оруулалтыг дэмжих. | 2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн: Зорилт 5. Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ. 2030 онд технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь хүртэлх түвшинд хүргэх. | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 60 | 7.б. | 2030 он гэхэд, хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй орнууд, далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд, арлын хөгжиж байгаа жижиг орнуудын нийт хүн амыг орчин үеийн, тогтвортой эрчим хүчний үйлчилгээгээр хангах зорилгоор холбогдох дэмжлэгийн хүрээнд дэд бүтцийг өргөжүүлэх, технологийг шинэчлэх. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилго 8: Хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийт хүн амыг бүрэн, үр бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах.** | | | | |
| | 2.2.1. Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал: Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна. 2026-2030 онд: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 70 хувьд, ажилгүйдлийн түвшинг 3 хувьд хүргэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээг 300 тэрбумаас доошгүй төгрөгт хүргэх. | | | 2 |
| 61 | 8.1. | Үндэсний нөхцөл байдалтай уялдуулан нэг хүнд ногдох эдийн засгийн өсөлтийг үргэлжлүүлэх, тухайлбал хамгийн буурай хөгжилтэй орнуудад жил тутмын ДНБ-ий өсөлтийг 7-гоос доошгүй хувьтай байлгах. | Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монгол Улс 2030 онд: 1. Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17500 ам.долларт хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ. 2. Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6,6 хувиас доошгүй байна. | 1 |
| 62 | 8.2. | Төрөлжүүлэх, технологийг шинэчлэх, инновацийг дэмжих замаар эдийн засгийн үр бүтээмжийг дээшлүүлэх, нэмүү өртөг өндөртэй болон эрчимтэй хөдөлмөрийн салбаруудыг хөгжүүлэх. | 2.1. Эдийн засгийн тогтвортой хөгжил. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ. | 1 |
| 63 | 8.3. | Үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх, зохистой ажлын байр бий болгох, бүтээлч сэлгэлгээ болон инновацийг дэмжихэд чиглэгдсэн хөгжлийн бодлого, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах замаар бичил, жижиг, дунд аж ахуйн байгууллагуудыг албажуулах, өсөлтийг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. | 2.1.1. Хөдөө аж ахуйн салбар: Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ. | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 64 | 8.4. | 2030 он хүртэл дэлхийн нөөцийн хэрэглээ болон үйлдвэрлэлийн үр ашгийг давшингуй сайжруулах, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн 10 жилийн суурь хөтөлбөрүүдийн хүрээнд байгаль орчноос эдийн засгийн өсөлтийн хамаарлыг бууруулах арга хэмжээ авах, үүнд хөгжингүй орнууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх. | | 3 |
| 65 | 8.5. | 2030 он гэхэд бүх эрэгтэй, эмэгтэйчүүд, залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэлтэд хамруулах, зохистой ажлын байраар хангах,адил үнэлэмжтэй  ажилд адил цалин хөлс олгох. | | 3 |
| 66 | 8.6. | 2030 он гэхэд хөдөлмөр, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын хувийг үлэмж бууруулах. | | 3 |
| 67 | 8.7. | Албадан хөдөлмөрийг устгах, орчин үеийн боолчлол болон хүний хууль бус наймааг зогсоох  яаралтай, үр дүнтэй арга хэмжээ авах, цэрэгт хүүхдийг дайчлах, ашиглах зэрэг хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хэрцгий хэлбэрийг хориглох, устгах, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг зогсоох. | | 3 |
| 68 | 8.8. | Хөдөлмөрийн эрхийг хамгаалах, бүх ажилчид, тухайлбал цагаач ажилчид, ялангуяа эмэгтэй цагаач ажилчид, түр ажил эрхлэлж байгаа хүмүүсийн ажлын байрны аюулгүй, баталгаатай орчныг хангах. | | 3 |
| 69 | 8.9. | 2030 он гэхэд ажлын байр бий болгох, орон нутгийн соёл болон бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих тогтвортой аялал жуулчлалын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх. | 2.1.2. Аялал жуулчлалын салбар: Зорилт 1. Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно. 2026-2030 онд: Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брендийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2.0 саяд хүргэнэ. | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 70 | 8.10. | Бүх нийтээр банк, даатгал, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл бололцоог сайжруулах зорилгоор үндэсний санхүүгийн байгууллагуудын чадавхыг  бэхжүүлэх. | 2.1.6. Макро эдийн засгийн бодлого: Зорилт 2. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ. 2026-2030 онд: Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 12-д хүргэн нэмэгдүүлэх, арилжааны банкны эзлэх хувийг 86-д хүргэн бууруулах, даатгалын зах зээлийн эзлэх хувийг өсгөх. | 1 |
| 71 | 8.а. | Хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй орнуудад Худалдаатай холбоотой техникийн тусламж үзүүлэх өргөжүүлсэн цогц тогтолцооны хүрээнд тусламж, худалдааны дэмжлэг үзүүлэх. | | 3 |
| 72 | 8.б. | 2020 гэхэд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн дэлхийн стратегийг боловсруулан мөрдөж эхлэх, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Дэлхий дахины ажлын гэрээг хэрэгжүүлэх. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилго 9: Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг хөгжүүлэх, инновацийг хөхүүлэн дэмжих.** | | | | |
| | 2.1.5. Дэд бүтцийн салбар: Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно. | | | |
| 73 | 9.1. | Эдийн засгийг хөгжүүлэх, хүний сайн сайхан амьдралд дэмжлэг үзүүлэх зорилгоор бүх нийтэд хүртээмжтэй, хямд, тэгш үйлчлэх, чанартай, найдвартай, тогтвортой болон уян хатан дэд бүтцийг хөгжүүлэх, үүнд бүс нутгийн болон хил дамнасан дэд бүтцийг хамруулах. | Зорилт 2. Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана.<br>Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.<br>Зорилт 4. Аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлнэ.<br>Зорилт 6. Хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.<br>Зорилт 7. Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 74 | 9.2. | Хүртээмжтэй, тогтвортой аж үйлдвэрийг дэмжиж, 2030 он гэхэд үндэсний нөхцөл байдалд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлт болон ДНБ-ий үйлдвэрлэлд аж үйлдвэрийн эзлэх хувийг үлэмж нэмэгдүүлэх, хамгийн буурай хөгжилтэй орнуудад эзлэх хувийг нэг дахин өсгөх. | 2.1.3. Аж үйлдвэрийн салбар: 2030 онд: Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх. | 2 |
| 75 | 9.3. | Хөгжиж байгаа орнуудын аж үйлдвэрийн жижиг болон бусад байгууллагууд санхүүгийн үйлчилгээ, хямд зээлд хамрагдах, зах зээл болон үнийн сүлжээний интеграцид нэгдэх боломжийг нэмэгдүүлэх. | | 3 |
| 76 | 9.4. | 2030 он гэхэд дэд бүтцийг шинэчлэх, аж үйлдвэрийн салбаруудын тогтвортой байдлыг хангах зорилгоор шинэчлэн тоноглох, нөөцийн ашиглалтын үр дүнг дээшлүүлэх, цэвэр, байгальд ээлтэй технологи ба үйлдвэрлэлийн процессийг түлхүү нэвтрүүлэх, ингэхдээ улс орнууд өөрсдийн чадавхыг харгалзан холбогдох арга хэмжээг авах. | 2.1.3. Аж үйлдвэрийн салбар: Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, Зорилт 2. Хүнсний үйлдвэрлэл, Зорилт 3. Химийн аж үйлдвэр, Зорилт 4. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх. | 1 |
| 77 | 9.5. | Бүх улс орон, тухайлбал хөгжиж байгаа орнуудад шинжлэх ухааны судалгааг сайжруулах, аж үйлдвэрийн салбаруудын технологийн чадавхыг нэмэгдүүлэх, 2030 он гэхэд инновацийг дэмжих, нэг сая хүн ам тутамд эрдэм шинжилгээ болон хөгжлийн асуудал хариуцсан ажилтнуудын тоо, төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээ, хөгжлийн зардлыг үлэмж нэмэгдүүлэх. | 2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн: Зорилт 5. Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ. 2030 онд технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувь хүртэлх түвшинд хүргэх. | 1 |
| 78 | 9.а. | Африкийн орнууд, хамгийн буурай хөгжилтэй орнууд, далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд,,арлын хөгжиж байгаа жижиг орнуудад үзүүлэх санхүү, технологи, техникийн тусламжийг өргөжүүлэх замаар хөгжиж байгаа орнуудын тогтвортой, баталгаатай дэд бүтцийн хөгжлийг хангах. | | 3 |
| 79 | 9.б. | Бодлогын ээрэг орчин бүрдүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, бараа бүтээгдэхүүний нэмүү өртгийг нэмэгдүүлэх замаар хөгжиж байгаа орнуудад дотоодын технологи, эрдэм шинжилгээ болон инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 80 | 9.в. | Мэдээлэл, холбооны технологийн хүртээмжийг үлэмж нэмэгдүүлэх, 2020 он гэхэд хамгийн буурай хөгжилтэй орнуудад хямд интернетийн хэрэглээг нийтийн хүртээл болгох. | | 1 |

| Зорилго 10:Улс орнуудын дотоод дахь болон улс хоорондын тэгш бус байдлыг багасгах. | | | | |
|---|---|---|---|---|
| 81 | 10.1. | 2030 он гэхэд хүн амын хамгийн бага орлоготой 40 хувийн орлогыг үндэсний дунджаас дээгүүр хэмжээгээр өсгөх ба тэр хэмжээнд барих. | | 1 |
| 82 | 10.2. | 2030 он гэхэд бүх хүн амын нийгэм,эдийн засаг,  улс төрийн эрх мэдэл, оролцоог нэмэгдүүлэх, ингэхдээ нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, үүсэл гарал, шашин, эдийн засаг болон бусад байдлыг үл харгалзах | | 3 |
| 83 | 10.3. | Ялгаварлан гадуурхах хууль, бодлого, практикийг устгах, холбогдох хууль эрх зүй, бодлого,үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар адил боломжийг хангах, үр дүнгийн тэгш бус байдлыг бууруулах | | 3 |
| 84 | 10.4. | Санхүү, цалин хөлс, нийгмийн хамгааллын бодлогыг боловсруулж, илүү эрх тэгш байдлыг давшингуй хангах. | | 2 |
| 85 | 10.5. | Дэлхийн санхүүгийн зах зээл болон байгууллагуудын зохицуулалт, хяналт шинжилгээг  сайжруулах, хууль дүрмийн хэрэгжилтийг бэхжүүлэх. | | 3 |
| 86 | 10.6. | Дэлхийн, олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудын шийдвэр гаргах явцад хөгжиж байгаа орнуудын төлөөлөл, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор эдгээр байгууллагуудын илүү үр бүтээмж, нэр хүнд, тайлагнах чадвар, хууль ёсны статусыг хангах. | | 2 |
| 87 | 10.7. | Сайтар төлөвлөсөн, менежментээр хангасан цагаачлалын бодлогын хүрээнд журамтай, аюулгүй, байнгын, хариуцлагатай цагаачлал болон хүн амын шилжилт хөдөлгөөнийг хэрэгжүүлэх. | | 3 |
| 88 | 10.а. | ДХБ-ын гэрээ хэлэлцээрийн дагуу хөгжиж байгаа орнууд, ялангуяа хамгийн буурай хөгжилтэй орнуудад ялгавартай, тусгай нөхцөл баримтлах зарчмыг хэрэгжүүлэх. | | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 89 | 10.б. | Хөгжлийн албан ёсны тусламж, санхүүгийн урсгал, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, ялангуяа хамгийн хэрэгцээтэй байгаа, тухайлбал Африкийн орнууд, хамгийн буурай хөгжилтэй орнууд, далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд, арлын хөгжиж байгаа жижиг орнуудад тэдгээрийн үндэсний төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг харгалзан дэмжлэг үзүүлэх. | | 2 |
| 90 | 10.в. | 2030 он гэхэд цагаачдын мөнгөн гуйвуулгын хураамжийг 3 хувиас доош болгох, 5-аас дээш хувийн хураамжтай гуйвуулгын үйл ажиллагааг устгах. | | 3 |

| **Зорилго 11: Хот, суурин газруудын тэгш, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой хөгжлийг дэмжих** | | | |
|---|---|---|---|
| 91 | 11.1. | 2030 он гэхэд бүх нийтээр зохистой, аюулгүй, хямд орон сууц болон үндсэн үйлчилгээнд хамрагдах, ядуу хүмүүс амьдардаг хорооллын нөхцөлийг сайжруулах. | 3 |
| 92 | 11.2. | 2030 он гэхэд бүх нийтээр аюулгүй, хямд, хүртээмжтэй, тогтвортой тээврийн үйлчилгээнд хамрагдах, нийтийн тээврийг ихээхэн өргөжүүлэх аргаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэх, ингэхдээ эмзэг байдалд байгаа хүмүүс, эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагад онцгой анхаарал хандуулах. | 2 |
| 93 | 11.3. | 2030 он гэхэд бүх улс орнуудад хүртээмжтэй, тогтвортой хотжуулалт, бүх нийтийн оролцоотой, цогц, тогтвортой хотын төлөвлөлт, менежментийг хэрэгжүүлэх. | 1 |
| 94 | 11.4. | Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хадгалах хүчин чармайлтыг нэмэгдүүлэх. | 2 |
| 95 | 11.5. | 2030 он гэхэд гамшиг, тухайлбал усны холбоотой гамшгийн улмаас нас барсан, хохирсон хүмүүсийн тоо, дэлхийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд үзүүлэх эдийн засгийн шууд хохирлыг ихээхэн бууруулах, ингэхдээ ядуу болон эмзэг байдалд байгаа хүмүүсийг хамгаалахад анхаарал хандуулах. | 2 |
| 96 | 11.6. | 2030 он гэхэд хотуудын байгаль орчинд үзүүлэх нэг хүн тутмын сөрөг нөлөөллийг бууруулах, агаарын чанар, хотын болон бусад хог хаягдлын менежментэд онцгой анхаарал хандуулах | 2 |
| 97 | 11.7. | 2030 он гэхэд бүх хүмүүст, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст аюулгүй, хүртээмжтэй, ногоон болон олон нийтийн газарт нэвтрэх нөхцөлийг хангах | 2 |
| 98 | 11.а. | Үндэсний, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах замаар хот, хотжуулсан бүс болон хөдөө орон нутаг хоорондын эдийн засаг, нийгэм, байгаль орчны эерэг холбоог бэхжүүлэх. | 1 |
| 99 | 11.б. | 2020 он гэхэд Гамшгийн эрсдлийг бууруулах Сэндайн 2015□2030 оны Хөтөлбөрийн хүрээнд гамшгийн эрсдлийн бүх түвшний менежментийг боловсруулан хэрэгжүүлэх, баталгаатай, нөөцийг үр ашигтай зарцуулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, гамшигт тэсвэртэй байх цогц бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлдэг хот, суурингуудын тоог ихээхэн нэмэгдүүлэх | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 100 | 11.в. | Хамгийн буурай хөгжилтэй орнуудад орон нутгийн материалыг ашиглан баталгаатай, найдвартай байшин барилга барихад санхүүгийн болон техникийн тусламж үзүүлэх. | | 3 |
| **Зорилго 12. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжих.** | | | | |
| 101 | 12.1. | Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн 10 жилийн суурь хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөгжингүй орнууд тэргүүлэх үүргийг хүлээж бүх орнууд холбогдох арга хэмжээ авах, ингэхдээ хөгжиж байгаа орнуудын хөгжлийн түвшин, чадавхыг харгалзах. | 2.1. Эдийн засгийн тогтвортой хөгжил Салбарын хөгжлийн зорилтыг хангах зарчим:<br>• Өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах;<br>• Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэлийг дэмжих;<br>• Үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг эдийн засаг, нийгмийн бүх салбарт чанд баримтлах. | 2 |
| 102 | 12.2. | 2030 он гэхэд байгалийн нөөцийн тогтвортой менежмент, үр ашигтай ашиглалтыг нэвтрүүлэх. | Зорилт 2.3.1: Усны нөөцийн нэгдсэн менежмент | 2 |
| 103 | 12.3. | 2030 он гэхэд нэг хүнд ногдох дэлхийн хүнсний хаягдлыг бөөний болон хэрэглэгчийн түвшинд тэн хагасаар бууруулах, үйлдвэрлэл болон хангамжийн сүлжээний хүнсний алдагдал, ургацын дараах алдагдлыг багасгах. | | 3 |
| 104 | 12.4. | 2020 он гэхэд олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу химийн бодис болон хаягдлыг ашиглалтын бүх хугацаанд байгаль орчинд ээлтэй менежментээр хангах, тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор агаар, ус, хөрсөнд хаях явдлыг үлэмж багасгах. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 105 | 12.5. | 2030 он гэхэд хаягдлыг багасгах, эргэлтэд оруулах, дахин ашиглах замаар хаягдлын хэмжээг ихээхэн бууруулах. | 2.3.3. Экосистемийн тэнцвэрт байдал. Зорилт 2. Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна. **I үе шат** (2016-2020): Хот, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх, Улаанбаатар хотыг утаагүй болгох. **II үе шат** (2021-2025): Хот, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх. **III үе шат** (2026-2030): Хот, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 30 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 40 хувьд хүргэх. | 1 |
| 106 | 12.6. | Компаниуд, ялангуяа том болон үндэстэн дамнасан компаниуд тогтвортой үйлдвэрлэлийн практикийг хэрэгжүүлэх, тайланд нөөцийн үр ашигтай ашиглалтын мэдээллийг тусгахыг дэмжих. | 2.1.1. Хөдөө аж ахуйн салбар. Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.<br>Зорилт 2. Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.<br>Зорилт 3. Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ. | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 2.1.3. Аж үйлдвэрийн салбар. Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх. Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60-80 хувьд хүргэх<br>Зорилт 2. Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ. (2016-2030): Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 30-70 хувь, сүүний 40-80 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах.<br>Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.<br><br>Зорилт 4. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.<br>2.1.4. Эрдэс баялгийн салбар.<br>Зорилт 2. Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.<br>2.1.5. Дэд бүтцийн салбар.<br>Зорилт 2. Нийт эрчим хүчинд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг ашиглах бэлтгэлийг хангана. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 107 | 12.7. | Үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төрийн тогтвортой худалдан авалтын практикийг хөгжүүлэх. | | 3 |
| 108 | 12.8. | 2030 он гэхэд бүх нийтээр холбогдох мэдээлэл авах, тогтвортой хөгжлийн талаар мэдрэмжтэй байх, байгаль орчинтой зохицон орших нөхцлийг хангах. | 2.3.3. Экосистемийн тэнцвэрт байдал Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална. | 2 |
| 109 | 12.а. | Хөгжиж байгаа орнуудыг илүү тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн горимд шилжүүлэх зорилготой шинжлэх ухаан, технологийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | | 4 |
| 110 | 12.б. | Орон нутагт ажлын байр бий болгох, соёл болон үйлдвэрлэлийг дэмжих аялал жуулчлалын тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөллийн хяналт шинжилгээний арга хэрэгслийг боловсруулж, хэрэгжүүлэх. | | 3 |
| 111 | 12.в. | Малтмалын түлшний үр ашиггүй тэтгэлгийг оновчтой болгох, үндэсний нөхцөл байдалтай уялдуулан зах зээлийн тэнцвэргүй байдлыг арилгах, татварын тогтолцоог шинэчлэх, ашиггүй тэтгэлгээс татгалзах замаар үр ашиггүй зарцуулалтыг бууруулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзах, ингэхдээ хөгжиж байгаа орнуудын онцгой нөхцөл байдал, хэрэгцээг анхаарах, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийнхний хамгаалалд сөргөөр үйлчлэх нөлөөллийг багасгах. | | 2 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилго 13. Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг яаралтай авах** | | | | |
| 112 | 13.1. | Бүх улс орны байгалийн гамшиг, уур амьсгалтай холбоотой гамшигтай тэмцэх, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх. | | 1 |
| 113 | 13.2. | Үндэсний бодлого, стратеги, төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг тусгах. | | 1 |
| 114 | 13.3. | Уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох, эрт илрүүлэхэд чиглэгдсэн боловсрол, мэдрэмж, хүний болон институцийн чадавхыг дээшлүүлэх. | | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 115 | 13.а. | 2020 он хүртэл жил тутам 100 тэрбум ам.долларыг бүх эх сурвалжаас дайчлах, түүнийг хөгжиж байгаа орнууд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад ил тод байдлаар зарцуулах зорилгоор НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хүрээнд хөгжингүй орнуудын хүлээсэн үүрэг амлалтыг хэрэгжүүлэх, Уур амьсгалын ногоон сангийн хөрөнгийг бүрдүүлж аль болох богино хугацаанд ажиллагаанд оруулах. | | 3 |
| 116 | 13.б. | Хамгийн буурай хөгжилтэй орнууд, арлын хөгжиж байгаа жижиг орнуудын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үр дүнтэй төлөвлөлт, менежментийн чадавхыг дээшлүүлэх механизмыг бүрдүүлэх, ингэхдээ эмэгтэйчүүд, залуучууд, орон нутгийн ард иргэдэд анхаарал хандуулах. | | 3 |

| | | |
|---|---|---|
| **Зорилго 14. Далай тэнгисийн нөөцийг хамгаалах, нөөцийг тогтвортой хөгжилд зүй зохистой ашиглах** | | |
| 117-126 | Хамаарахгүй 10 зорилт байна. | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 126 | | Зорилго 15. Хуурай газрын экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой байдлыг хангах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг мөхөж устахаас сэргийлэх. | Зорилт 2.3.1: Усны нөөцийн нэгдсэн менежмент 3 | |
| 127 | | 2020 он гэхэд хуурай газрын цэнгэг усны экологийн тогтолцоо, түүний үйлчилгээ, тухайлбал ой, намаг балчиг, уулс, хуурайшилттай газрыг олон улсын гэрээний хүрээнд хүлээсэн үүргийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах. | Зорилт 1. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ. **I үе шат** (2016-2020): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тундас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх. | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 15.1. | | **II үе шат** (2021-2025): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх, гадаргын усыг хуримтлуулах усан сангуудыг байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 23 хувьд хийх.<br>**III үе шат** (2026-2030): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх. | |
| 128 | 15.2. | 2020 он гэхэд бүх төрлийн ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, ой устгахыг зогсоох, доройтсон ойг нөхөн сэргээх, дэлхий дахинд ойжуулах, ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг үлэмж нэмэгдүүлэх. | | 3 |
| 129 | 15.3. | 2030 он гэхэд цөлжилттэй тэмцэх, цөлжилт, ган, үерийн улмаас доройтсон газар, хөрсийг нөхөн сэргээх, дэлхийд газрын доройтлыг зогсоох нөхцлийг бүрдүүлэх. | 2.3.3. Экосистемийн тэнцвэрт байдал<br>Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.<br>**I үе шат** (2016-2020): Цөлжилтийг саарууулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх.<br>**II үе шат** (2021-2025): Цөлжилтийг саарууулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 27 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.7 хувьд хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Цөлжилтийг саарууулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9 хувьд хүргэх. | 1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 130 | 15.4. | 2030 он гэхэд уулын экологийн тогтолцоо, түүний биологийн олон янз байдлыг хадгалах, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах чухал чадавхыг нэмэгдүүлэх. | 2.3.3. Экосистемийн тэнцвэрт байдал<br>Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.<br>**I үе шат** (2016-2020): Цөлжилтийг бууруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх.<br>**II үе шат** (2021-2025): Цөлжилтийг бууруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 27 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.7 хувьд хүргэх.<br>**III үе шат** (2026-2030): Цөлжилтийг бууруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9 хувьд хүргэх. | 2 |
| 131 | 15.5. | Тойрон байгаа орчны доройтлыг бууруулах нэн яаралтай, өргөн арга хэмжээ авах, биологийн олон янз байдал устахыг зогсоох, устах аюултай амьтан, ургамлын зүйл аймгийг хамгаалах, сэргийлэх нөхцлийг 2020 он гэхэд хангах. | | 3 |
| 132 | 15.6. | Олон улсын хэмжээнд тохиролцсоны дагуу генетикийн нөөцийг ашигласны үр шимийг шударга, тэгш хүртэх, эдгээр нөөцийг тэгш ашиглах нөхцлийг бүрдүүлэх. | | 3 |
| 133 | 15.7. | Хамгаалалтад байгаа амьтан, ургамлын зүйл аймгийг хууль бусаар агнах, ашиглах, тээвэрлэхийг зогсоох яаралтай арга хэмжээ авах, байгалийн хууль бус бүтээгдэхүүний хэрэгцээ, хангалтын асуудлыг шийдвэрлэх. | | 3 |
| 134 | 15.8. | 2020 он гэхэд хуурай газар, усны экологийн тогтолцоонд гадны харш зүйл аймаг нэвтрэх боломж, сөрөг үр дагаврыг үлэмж бууруулах, сэргийлэх арга хэмжээ авах, тэргүүлэх зүйл аймгийг хамгаалах | | 3 |
| 135 | 15.9. | 2020 он гэхэд үндэсний болон орон нутгийн төлөвлөлт, хөгжлийн явц, ядуурлыг бууруулах стратеги, тооцоонд экологийн тогтолцоо, биологийн олон янз байдлын үнэлгээг тусгах. | | 3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 136 | 15.а. | Экологийн тогтолцоо, биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ашиглалтын санхүүгийн нөөцийг бүх эх сурвалжаас дайчлах, үлэмж нэмэгдүүлэх. | | 3 |
| 137 | 15.б. | Ойн тогтвортой менежментийн санхүүжилтийг бүх эх сурвалжаас, бүх түвшинд ихээхэн дайчлах, хөгжиж байгаа орнуудад ийм төрлийн менежментийг нэвтрүүлэх, ой хамгаалал болон дахин ойжуулах хөшүүрэг олгох. | | 3 |
| 138 | 15.в. | Орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааны боломжийг хангах замаар хамгаалалтад байгаа амьтан, ургамлын зүйл аймгийг хууль бусаар агнах, ашиглах, тээвэрлэхтэй тэмцэх хүчин чармайлтыг дэлхий дахинд дэмжих. | | 3 |

| **Зорилго 16. Амгалан тайван, бүх нийтийн оролцоог хангасан хууль ёст тогтвортой хөгжлийн нийгмийг бүрдүүлж, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцийг бүх шатанд бий болгох.** | | | | |
|---|---|---|---|---|
| 139 | 16.1. | Хүчирхийллийн бүх хэлбэр, түүнээс үүдэлтэй нас баралт, эндэгдлийн түвшинг дэлхий дахинд үлэмж бууруулах. | | 3 |
| 140 | 16.2. | Хүүхдийн эсрэг дарангуйлал, хүүхдийн мөлжлөг, хууль бус наймаа, хүчирхийллийн бүх хэлбэр, хүүхдийг тарчлан зовоох явдлыг зогсоох. | | 3 |
| 141 | 16.3. | Үндэсний, олон улсын түвшинд хуулийг дээдлэх, бүх нийтээр шударга шүүхэд хамрагдах нөхцлийг бэхжүүлэх. | Тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим: хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх; | 2 |
| 142 | 16.4. | 2030 он гэхэд санхүүгийн болон зэвсгийн хууль бус гүйлгээг үлэмж бууруулах, хулгайлагдсан актив хөрөнгийг илрүүлэх, буцааж өгөх явдлыг бэхжүүлэх, зохион байгуулалттай гэмт хэргийн бүх хэлбэртэй тэмцэх | | |
| 143 | 16.5. | Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж бууруулах. | 2.4. Тогтвортой хөгжлийн засаглал Зорилт 3. Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана. | |
| 144 | 16.6. | Үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцийг бүх шатанд бий болгох. | | |
| 145 | 16.7. | Нийгмийн бүх давхаргын төлөөллийн оролцоотой, хариуцлагатай шийдвэр гаргах тогтолцоог бүх шатанд нэвтрүүлэх. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 146 | 16.8. | Дэлхий дахины засаглалын байгууллагуудад хөгжиж байгаа орнуудын оролцоог өргөжүүлэн бэхжүүлэх. | | |
| 147 | 16.9. | 2030 он гэхэд бүх нийтээр хууль ёсны баримт бичиг, тухайлбал төрсний гэрчилгээтэй болох. | | |
| 148 | 16.10. | Үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу олон нийтийн мэдээлэлд хамрагдах эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах. | | |
| 149 | 16.а. | Олон улсын хамтын ажиллагааны шугамаар үндэсний, ялангуяа хөгжиж байгаа орнуудын холбогдох институцийн чадавхыг бүх түвшинд бэхжүүлэх, хүчирхийллээс сэргийлэх, терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх. | МУТХҮБ 2030 эхлэл: 10. Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна. | |
| 150 | 16.б. | Тогтвортой хөгжлийн ялгаварлан гадуурхах үзэлгүй хууль, бодлогыг хэрэгжүүлэн мөрдөх. | | |

| | | | |
|---|---|---|---|
| **Зорилго 17. Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг эрчимжүүлж, хэрэгжүүлэх арга механизмыг бүрдүүлэх.** | | | |
| | | Санхүү | 2.4. Тогтвортой хөгжлийн засаглал |
| 151 | 17.1. | Татвар болон бусад орлогыг хураах дотоодын чадавхыг сайжруулах зорилгоор дотоодын нөөцийг дайчлах боломжийг нэмэгдүүлэх, ингэхдээ хөгжиж буй орнуудад олон улсын хамтын ажиллагааны шугамаар дэмжлэг үзүүлэх. | Зорилт 4. Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно. |
| 152 | 17.2. | Хөгжингүй орнууд Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд хүлээсэн үүрэг амлалтаа бүрэн биелүүлэх, тухайлбал хөгжингүй олон орон ҮНО 0.7 хувийг Хөгжлийн албан ёсны тусламжийн шугамаар хөгжиж байгаа орнуудад, ҮНО-ын 0.15-0.20 хувийг хамгийн буурай хөгжилтэй орнуудад хандивлах, хөгжлийн тусламж олгогч орнууд ҮНО-ын 0.20 доошгүй хувийг хамгийн буурай хөгжилтэй орнуудад хандивлах зорилт дэвшүүлэхийг дэмжих. | |

| | | | |
|---|---|---|---|
| 153 | 17.3. | Олон төрлийн эх сурвалжаас хөгжиж байгаа орнуудад нэмэгдэл санхүүгийн нөөц дайчлах. | Зорилт 2. Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ. |
| 154 | 17.4. | Өр барагдуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх, өрийг хөнгөлөх, өрийн бүтцийг өөрчлөхөд чиглэгдсэн зохицуулалттай бодлогоор хөгжиж буй орнуудын өрийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, их хэмжээний гадаад өртэй орнуудын өрийн ачааллыг хөнгөлөх асуудлыг шийдвэрлэх. | 2.1.6. Макро эдийн засгийн бодлого<br>Зорилт 3.Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлнэ.<br>**I үе шат** (2016-2020): Хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгоно. Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 58,6 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах.<br>**II үе шат** (2021-2025): Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэн бэхжүүлнэ. Өрийн удирдлагын оновчтой тогтолцоог хөгжүүлж, гадаад өрийн ачааллыг зохистойгоор удирдаж, өрийн дээд хязгаарыг чанд баримтлан, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 50 хувиас хэтрүүлэхгүй байх.<br>**III үе шат** (2026-2030): Өрийн дээд хязгаарыг чанд баримтлан, гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 40 хувиас хэтрүүлэхгүй байх. |
| 155 | 17.5 | Хамгийн буурай хөгжилтэй орнуудад хөрөнгө оруулах урамшууллын дэглэмийг боловсруулж хэрэгжүүлэх. | |
| 156 | 17.6 | Шинжлэх ухаан, технологи, инновацийн Өмнөд-Умард, Өмнөд-Өмнөд, бүс нутгийн гурвалжин болон олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан тохирсон нөхцлөөр, тухайлбал өнөөгийн механизмд зохицуулалт хийх, НҮБ-ын түвшинд, технологийг хөгжүүлэх дэлхий дахины механизмын шугамаар мэдлэг хуваалцах нөхцлийг сайжруулах. | |

| | | | |
|---|---|---|---|
| 157 | 17.7. | Хөгжиж байгаа орнуудад байгаль орчинд ээлтэй технологийг боловсруулах, шилжүүлэх, түгээхэд хөнгөлөлт үзүүлэх, тохиролцсон ёсоор концесс болон хөнгөлөлттэй нөхцөл бий болгоход дэмжлэг үзүүлэх. | 2.3.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох<br>Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна.<br>I **үе шат**: Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх.<br>**III үе шат**: Эдийн засгийн бүтцэд өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 14 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 10 дахин нэмэгдүүлэх. |
| 158 | 17.8. | 2017 он гэхэд хамгийн буурай хөгжилтэй орнуудын технологийн сан, шинжлэх ухаан, технологи, инновацийн чадавхыг бүрэн ажиллагаанд оруулах, мэдээлэл, холбооны зэрэг өндөр үр бүтээмжтэй технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх. | Зорилт 5.Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ. |
| 159 | 17.9. | Чадавхыг бэхжүүлэх<br>17.9. Өмнөд-Умард, Өмнөд-Өмнөд, бүс нутгийн гурвалжин хамтын ажиллагааны шугамаар хөгжиж байгаа орнуудын Тогтвортой хөгжлийн бүх зорилтуудыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөнд дэмжлэг үзүүлэх зорилгоор үр бүтээмжтэй, зорилтот чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн олон улсын дэмжлэгийг өргөжүүлэх. | 2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий монгол хүн.<br>**I үе шат**: Инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг ДНБ-ий 2 хувь хүртэлх түвшинд хүргэх.<br>**II үе шат**: Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг ДНБ-ий 2.5 хувь хүртэлх түвшинд хүргэх.<br>**III үе шат:** Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг ДНБ-ий 3 хувь хүртэлх түвшинд хүргэх. |

| | | | |
|---|---|---|---|
| 160 | 17.10. | Худалдаа<br>ДХБ-ын харьяанд, түүний Дохагийн Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэлэлцээ хийх шугамаар бүх нийтийг хамарсан, дүрэмд суурилсан, нээлттэй, ялгаварчлалгүй, шударга олон талт худалдааны тогтолцоог хөгжүүлэх. | |
| 161 | 17.11. | Хөгжиж байгаа орнуудын экспортыг үлэмж нэмэгдүүлэх, тухайлбал 2020 он гэхэд хамгийн буурай хөгжилтэй орнуудын дэлхийн экспортод эзлэх хувийг нэг дахин өсгөх зорилго тавих. | |
| 162 | 17.12. | ДХБ-ын шийдвэрээр хамгийн буурай хөгжилтэй орнуудад татвар, квотоос чөлөөт зах зээлд нэвтрэх хугацаа олгох, ингэхдээ хамгийн буурай хөгжилтэй орнуудын импортод үүсэл гарлын давуу, ил тод, хялбар байх эрх олгох, зах зээлд нэвтрэхэд хувь нэмэр оруулах. | |
| 163 | 17.13 | Тогтолцооны асуудлууд<br>Бодлого, институцийн уялдаа холбоо | Бодлогын зохицуулалт, уялдаа холбоог хангах замаар дэлхийн макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх. |
| 164 | 17.14. | Тогтвортой хөгжлийн бодлогын уялдаа холбоог бэхжүүлэх. | Макро эдийн засгийн тогтвортой бодлогын суурь зарчим: урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлогоо уялдуулж, идэвхтэй хамтран ажиллах. |
| 165 | 17.15. | Улс орнуудын ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх бодлогын орон зай, удирдлагыг хүндэтгэх. | |
| 166 | 17.16. | Олон талт оролцогчдын түншлэл<br>Тогтвортой Хөгжлийн Дэлхий Дахины Түншлэлийг бэхжүүлэх, мэдлэг, туршлага, технологи, санхүүгийн нөөцийг дайчлах, хуваалцах олон талт оролцогчдын түншлэлийг дэмжих, Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг бүх улс орон, ялангуяа хөгжиж байгаа орнуудад хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | |

| | | | |
|---|---|---|---|
| 167 | 17.17. | Төр засгийн байгууллага, төр засаг, хувийн хэвшил, иргэний нийгэм хоорондын түншлэлийг дэмжин хөгжүүлэх, түншлэлийн стратегийн туршлага, нөөц боломжийг ашиглах. | |
| 168 | 17.18. | Мэдээ мэдээлэл, хяналт шинжилгээ, тайлагнах зарчим<br>2020 гэхэд хөгжиж байгаа орнууд, тухайлбал хамгийн буурай хөгжилтэй болон арлын хөгжиж байгаа жижиг орнуудын чадавхийг бэхжүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх, орлого, хүйс, нас, арьс өнгө, гарал, цагаачлалын статус, хөгжлийн бэрхшээл, газар зүйн байршил зэрэг үндэсний хэмжээнд холбогдол бүхий үзүүлэлтээр хэмжигдсэн өндөр чанартай, цагаа олсон, баталгаатай мэдээллээр хангах боломжийг үлэмж нэмэгдүүлэх. | |
| 169 | 17.19. | 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн дэвшлийг үнэлэх үзүүлэлтийг өнөөгийн санаачилгуудад үндэслэн боловсруулах, ингэснээр ДНБ-ий өсөлтөд нэмэр оруулах, хөгжиж байгаа орнуудын статистикийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | |

Үндэсний хөгжлийн газар
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1
Засгийн газрын II байр
Утас: 976-51-263333
www.nda.gov.mn

3 245456 345344